



ХҮЧ БА ГАЛТ ЗЭВСЭГ ХЭРЭГЛЭХ НЬ

**Цагдаагийн алба хаагчийн үйл
ажиллагааны гарын авлага**

Улаанбаатар хот
2007 он

ТАЛАРХАЛ

Энэхүү номыг зохиохыг санаачилсан НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн хүний эрхийн багийн ахлагч байсан Ван Хи Ли, Монголын цагдаа нарын хүртээл болгоход дэмжлэг үзүүлсэн Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсаас Монгол улсад суугаа элчин сайдын яаманд талархаж байгаагаа илэрхийлье.

Мөн энэхүү номонд олон улсын эрх зүй, хүний эрхийн талаас шүүмж бичсэн Монголын Эмнести Интернэшнлийн гүйцэтгэх захирал Б. Алтантуяа, хууль эрх зүйн талаас шүүмж бичсэн өмгөөлөгч Б.Энхтуяа, Ч.Аюурзана нарт талархаж байгаагаа илэрхийлье.

Туршилт сургалтанд амжилттай оролцож, энэхүү номыг сайжруулах, бусад цагдаа нарын хүртээл болгоход хувь нэмрээ оруулсан Эргүүл хамгаалалтын газар, Дотоодын цэргийн 805-р анги, Дархан-Уул, Орхон-Уул, Төв аймгийн цагдаагийн газар болон Хан-Уул дүүргийн цагдаагийн хэлтэсийн хамт олонд талархсанаа илэрхийлье.

Цагдаагийн Ерөнхий газраас цагдаагийнхаа алба хаагчдыг сургаж дадлагажуулах, иргэдэд үйлчлэх үйлчилгээнийхээ чанарыг дээшлүүлэхэд зохих хувь нэмэр үзүүлнэ хэмээн үзэж байгаагаа илэрхийлэн, 5000 хувийг нэмж олгохыг санал болгосны дагуу “Хүч ба галт зэвсэг хэрэглэх нь” цагдаагийн үйл ажиллагааны гарын авлага нь 2 дахь удаагаа хэвлэгдсэн болно.



ISBN-99929-27-07-0
DDC
362.22 023
X-863

Зохиогч:	Б.Алтанбагана Т. Гантулга
Хянасан:	Б.Алтантуяа М.Батаев
Зургийг:	Карл Вэтам
Эх бэлтгэл:	Карл Вэтам Л.Азжаргал

© Хэвлэн нийтлэх эрх Монголын Эмнести Интернэшнлд хадгалагдана. Энэхүү номыг зохиогчийн зөвшөөрөлгүйгээр хувилах, цахим хэлбэрээр дамжуулан хэрэглэхийг хориглоно.

ГАРЧИГ

1. Өмнөх үг.....	6
2. Тусгай хэрэгсэл.....	7
3. Галт зэвсэг.....	30
4. Хүч хэрэглэсний дараа үзүүлэх эмнэлгийн анхны тусламж.....	38
5. Жагсаал цуглааны үед хүч хэрэглэх тухай.....	47
6. Хууль бусаар хүч хэрэглэсэн тохиолдолд хүлээлгэх хариуцлага.....	56
7. Галт зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэх ёс зүй.....	62
8. Албаны бэлтгэл.....	66
9. Мэдвэл зохих гол хуулиуд.....	77
§ Нийгмийн хэв журам сахиулах үүрэг бүхий албан тушаалтан галт зэвсэг болон хүч хэрэглэх үндсэн зарчмууд	
§ Монгол Улсын Үндсэн Хууль	
§ Монгол Улсын Цагдаагийн байгууллагын тухай хууль	
§ Цагдаагийн тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх заавар	
10. Ном зүй.....	131
11. Хавсралт: Цагдаагийн байгууллагад хэрэглэгдэж буй галт зэвсэг, тусгай хэрэгсэл	

Эмнести Интернэшнл

Эмнести Интернэшнл нь Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал болон бусад хүний эрхийн олон улсын гэрээ, баримт бичигт заасан хүний эрхийг дэлхийн хүн бүрт эдлүүлэх чиглэлээр ажилладаг дэлхий даяарх хүний эрхийг хамгаалагчдын хөдөлгөөн юм.

Хүний бүхий л эрхийг хамгаалахын төлөөх өөрийн үйл ажиллагааныхаа хүрээнд бие махбод, сэтгэл санаагаар бүрэн бүтэн байлгах буюу чөлөөтэй сэтгэн бодох, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх зэрэг эрх, эрх чөлөөг ноцтой зөрчихөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох зорилгоор судалгаа хийх ба үйл ажиллагаа явуулж бодитой арга хэмжээ авдаг.

Ингэхдээ дараах үндсэн чиглэлд тулгуурлаж кампанит ажил явуулдаг.Үүнд

- Хүний эрхийн зөрчил үйлдэгсэдтэй хариуцлага тооцохыг уриалах
- Хүний эрхийг үр дүнтэйгээр хамгаалахыг засгийн газруудаас шаардах
- Хүний эрхийн олон улсын гэрээ хэлэлцээрүүдэд нэгдэхийг уриалах
- Хүний эрхийн боловсрол олгох сургалт, сурталчилгаа явуулах зэргийг дурьдаж болно

Эмнести Интернэшнл нь дэлхийн 150 гаруй улс оронд 1.8 сая гаруй гишүүд дэмжигчидтэй бөгөөд тэднийхээ хандив, тусламж, татвараар санхүүждэг.

ЦАГДААГИЙН ТАНГАРАГ

*Монгол улсын иргэн би
цагдаагийн албанд орж ажиллахдаа төрийн
хуулийг дээдлэн биелүүлж,
хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэж, гэмт хэрэгтэй
тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах
үйл хэрэгт чин шударгаар зүтгэж,
шаардлага гарвал амь насаа үл хайрлахаа
батлан тангараглая.*

*Би цагдаагийн ажлын эрдэм ухаанд цуцалтгүй
суралцаж, алба хаагчийн сахилга, ёс зүйг чанд
сахиж ажиллахаа тангараглая.*

*Би энэ тангарагаасаа няцваас төрийн хуулийн
цээрлэл хүлээнэ.*

ӨМНӨХ ҮГ

Та арван найман насанд хүрч өөрийн чин хүслээр цагдаагийн байгууллагад тангараг өргөн орж ажиллаж байгаа бол алдах эрх танд үгүй.

Дүрэмт хувцсаа өмсөөд төрийн төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэж яваа цагдаа жирийн нэг иргэн биш. Харин,

§ та төрийн жинхэнэ албан хаагч

§ та хууль сахиулагч

§ та гэмт хэрэгтэй тэмцэгч

§ та нийгмийн хэв журам хамгаалагч

§ та хүний эрх, эрх чөлөөг хамгаалахаар илгээсэн төр, ард түмний үйлчлэгч элч

§ та, амьд хууль тул аливаа асуудалд ямар ч цаг үед өөрийн хувийн үзэл бодлоор болон хувь хүн талаасаа огт хандаж болохгүй. Учир нь та бусдад цагдаа гэж л харагддаг учир зөвхөн хуулийн дагуу ажиллаж, нөхцөл байдалд зөв дүгнэлт хийж, хүнлэг энэрэнгүй байх зарчим баримтлан хуулийг сахиулах үүрэгтэй.

Хэдий ийм боловч зарим алба хаагчид маань үүргээ түр зуур ч гэсэн огоорон мартаж, эсвэл биеэ хянах чадвараа алдсаны улмаас бусдад тусгай хэрэгсэл, мэх буруу хэрэглэх тохиолдлууд гарсаар байна.

Цагдаагийн байгууллага нь сүүлийн үед хэв журам хамгаалах, гэмт хэрэгтэй тэмцэх тодорхой хэмжээний хүн хүч, тусгай хэрэгсэл, мэргэшсэн чадварлаг боловсон хүчин, алба хаагчтай болсон ч галт зэвсэг тусгай хэрэгсэл буруу хэрэглэснээс иргэдийг хохироон иргэдийн өмнө цагдаагийн байгууллага, алба хаагчийн нэр хүндийг унагаах явдал цөөн бус гарсаар байна. Тиймээс цагдаагийн алба хаагчдыг тусгай хэрэгсэл хэрэглэх арга зүйг сайн эзэмших, хэрэглэх явцдаа алдаа гаргахаас сэргийлэхэд тус дөхөм болгох үүднээс энэхүү гарын авлагад хүч ба галт зэвсгийг хэрхэн хэрэглэх талаар зөвлөмж өгөхийг зорилгоо.

ТУСГАЙ ХЭРЭГСЭЛ

“Цагдаагийн байгууллага, алба хаагч гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах, харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэхдээ дараах тусгай хэрэгсэл, мэх ашиглана:

- 1/ олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл;
- 2/ нэг бүрийн тусгай хэрэгсэл;
- 3/ тээврийн хэрэгсэл албадан зогсоох тусгай хэрэгсэл;
- 4/ хамгаалах тусгай хэрэгсэл;
- 5/ самбо, каратэ зэрэг зэвсэггүйгээр тулалдах мэх;
- 6/ албаны нохой¹

1. Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл

Хоёр ба түүнээс дээш хүнд нэгэн зэрэг хэрэглэх боломжтой хэрэгслийг олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл гэнэ. Монгол улсын цагдаагийн байгууллагын түүхэнд олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг ашиглаж, хэрэглэсэн практик жишээ өнөөдрийг хүртэл алга байна. Олон нийтийг хамарсан арга хэмжээ, жагсаал цуглаан ихээр зохион байгуулагдах болсон өнөө үед нийтийн эмх замбараагүй байдал үүсэх магадлалтай учир олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийн талаарх мэдлэг, түүнтэй хэрхэн яаж ажиллах талаарх дадлагыг зайлшгүй эзэмших шаардлагатай.

Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэлд дараахь хэрэгсэл хамаарна:

- 1/ олон хүнд нэг зэрэг нөлөөлөх нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч;

ТУСГАЙ ХЭРЭГСЭЛ _____

2/ усан хөөрөг;

3/ утаан хөшиг үүсгэгч²

Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг дараах зорилгоор хэрэглэнэ.

Үүнд:

А. Нийтийн эмх замбараагүй байдлыг таслан зогсоох

Б. Нийгмийн хэв журмыг бүлэглэн зөрчиж байгааг таслан зогсоох

В. Байгууллага иргэдийн мэдэлд байгаа барилга байгууламж, орон байрыг эзлэн авсан, гудамж замын хөдөлгөөнийг бүслэн хаасныг чөлөөлөх

Г. Хориглон эсэргүүцэж байгаа сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтныг баривчлах

Д. Цагдаагийн алба хаагч болон бусад хүний амь нас эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болзошгүй байдлаар довтолсон

Е. Цагдаагийн болон дотоодын цэргийн хамгаалалтанд байгаа объект руу нууцаар нэвтрэн орсон, эсхүл зэвсэг хэрэглэн буюу бүлэглэн довтолсон

Ё. Хүнийг барьцаанд авсан

Ж. Ялтан, цагдан хоригдогч оргосон, хүнд, онц хүнд гэмт хэрэгт сэжиглэгдсэн этгээд зугтсан

З. Галт зэвсэг, нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч, хүний амь нас эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болох бусад зүйлээр зэвсэглэсэн этгээд зэвсгээ хураалгах шаардлагыг үл биелүүлэн эсэргүүцсэн

И. Хуяглан хүргэж яваа этгээдийг суллахаар зэвсэг хэрэглэн эсхүл бүлэглэн довтолсон

¹ Монгол Улсын цагдаагийн байгууллагын тухай хууль 41-1-р зүйл, ТМ.1993. N°

² Монгол Улсын цагдаагийн байгууллагын тухай хууль 42-1,2-р зүйл, ТМ. 1993. N°

К. Хорих, цагдан хорих, баривчлах байранд болон шүүх хуралдааны үед нийтийн эмх замбараагүй байдал гарч, хүний амь нас, эд хөрөнгөнд ноцтой хохирол учрах бодитой нөхцөл байдал бий болсон.

Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэхдээ анхаарах зүйл:

1. Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэх үндэслэл байгаа эсэхийг, магадлан, тусгай хэрэгсэл хэрэглэх зорилгыг тодорхойлно.
2. Хэрэглэх тусгай хэрэгслийн төрөл, тоо, хэмжээ, хэрэглэх хүрээ, дэс дараа, тактикийг тодорхойлно.
3. Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэхийн өмнө урьдчилан сануулна. Урьдчилан сануулахдаа чанга яригчаар зарлах, удирдагч, зохион байгуулагчийг нь буюу тэдний төлөөлөгчийг урьж мэдэгдэх, сануулга бичиг тараах зэрэг боломжтой аргыг хэрэглэнэ. Урьдчилан сануулах аль нэг аргыг сонгож мэдэгдсэний дараа үйлдлээ таслан зогсоох шинж тэмдэг мэдэгдэхгүй бол тусгай хэрэгсэл хэрэглэж болно.
4. Цаг хугацааны хувьд боломжтой бүх тохиолдолд олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг хэрэглэх үндэслэлийг прокурорт урьдчилан танилцуулж, байлцахыг урина.
5. Нэг зэрэг олон хүнд нөлөөлөх нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчийг хэрэглэхдээ салхины эсрэг хэрэглэж болохгүй.
6. Усан хөөргөнд-гал унтраах ангийн машин болон цэргийн зориулалттай техникт байрлуулсан усан буу, тодорхой барилга байгууламжийн дотор хананд байрлуулсан галын усны хоолой зэргийг ашиглаж болно.

ТУСГАЙ ХЭРЭГСЭЛ _____

7. Утаан хөшиг үүсгэгчийг хэрэглэхдээ довтолж байгаа бүлэг хүмүүсийн салхины дээд талаас хэрэглэнэ.

2. Нэг бүрийн тусгай хэрэгсэл

§ Гар, хөл, хурууны гав

§ Хүлэг

§ Ороох цамц

§ Резинин бороохой

§ Цахилгаан бороохой

§ Нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч

§ Резинин сумтай буу

§ Хуванцар сумтай буу

§ Тор шидэгч буу – зэргийг цагдаагийн ажилтны хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй, сэжигтэн, гэмт хэрэгтэн, яллагдагчийг хуяглан хүргэх, цагдаагийн ажилтны амь бие болон бусдын эрүүл мэндэд ноцтой хохирол учруулахаар довтолсон үед хэрэглэнэ.

Гав хэрэглэх тухай

Гавыг гар, хөл, хуруунд хооронд нь холбож буюу бусад зүйлтэй холбон гавлаж хэрэглэнэ.

Хурууны гавыг эрхий хурууны 1-р үений хойд хэсгээр, хоёр эрхий хурууг хооронд нь буюу хоёр хүний эрхий хурууг хооронд нь холбож биений урд нь ба ард нь гавлаж болно.

Гарны гавыг хоёр гарны бугуйн хэсгээр хооронд нь буюу өөр хүнтэй холбон гавлаж болно. Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг хуяглан хүргэх үед гарыг нь өөртэйгээ холбон гавлаж болох бөгөөд тээвэрлэх үед гар буюу хөлийг нь автомашины суудал, тэвш бусад эд

_____ ТУСГАЙ ХЭРЭГСЭЛ
зүйлтэй холбон гавлаж болно. Мөн гавтай хүнийг түр хугацаагаар орхихдоо хүний амь нас эрүүл мэндэд хохирол учрахааргүйгээр үл хөдлөх зүйлээс гавлаж болно.



**ГАВЫГ ҮЛ ХӨДЛӨХ ЗҮЙЛЭЭС ХОЛБОЖ
ГАВЛАХДАА ХЯНАЛТТАЙ ХЭРЭГЛЭХ ЗАРИМ
ТОХИОЛДОЛ**



Хөлний гавыг, хөлний нарийн шилбээр хөлийг хооронд нь буюу хоёр хүний хөлийг холбон гавлаж болно. Мөн үл хөдлөх зүйлээс холбон гавлаж болно.

ТУСГАЙ ХЭРЭГСЭЛ _____

Гав хэрэглэхдээ анхаарах зүйл:

§ Хүйтний улиралд хуруу болон гарны гавыг хэрэглэхдээ хүний биений ил хэсэг хайрагдахаас болгоомжлох

§ Гав хүний биед шигдэж орох, чангарах зэргийг анзаарч хянаж байх

§ Гавыг хэрэглэхдээ заавал түгжиж хэрэглэх

§ Хүнийг тээврийн хэрэгсэл дотор холбож гавлахдаа донсолгоонд татагдаж гэмтэхээс сэргийлэх

§ Сэжигтэн буюу яллагдагчийг гавлаад дагуулж явахдаа урд нь ба чанх ард нь явж болохгүй, зөвхөн баруун, зүүн хажууд нь эсвэл баруун хойно нь буюу зүүн хойно нь явах, аль болохоор аль нэг гараас нь барьж, зугтаах болон бүдэрч унахаас хамгаалж явах

§ Гавтай этгээд өөрөө гаваа чангалж, мэдрэлийн судал, судаснуудыг боож үхжүүлдэг тул анхаарч байх

Тусгай хэрэгслийг буруу хэрэглэсэн зарим жишээ баримт, анхаарах зүйлүүдийг дурдъя.

Баримт

Өвлийн улиралд суудлын галт тэргэнд үүрэг гүйцэтгэж явсан цагдаа С нь тасалгаат өрөөний парнаас сэжигтэнг гавлаж орхиод, дараагийн зөрчил гаргасан хүн рүүгээ яваад ирэх хооронд гавлагдсан хүний гар түлэгдэж, үүнээс болж сэжигтэн гараа эмнэлэгт тайруулсан тохиолдол гарчээ.

Алдаа:

§ Гавтай сэжигтнээ хуулийн хугацаанд шалгаагүй

§ Сэжигтэнг холбож гавлах газраа буруу сонгосон

§ Орчноо буруу мэдэрч үнэлсэн, мэргэжлийн уучилшгүй алдаа юм.

Анхаарах зүйл:

Хэдийгээр яг ийм, ийм зүйлд хүнийг гавлаж болно болохгүй гэж тодорхой зааж өгөх боломжгүй боловч таны хүнлэг зан чанар, хуультай хослон нийлж орчноо зөв мэдрэн юунаас, ямар хугацаанд гавлах вэ гэдгээ зөв сонгож гол нь, нэгэнт гэмт хэрэг үйлдэж, зөрчил гаргасан, орчин тойрондоо буюу нийгэмд аюултай, эсвэл оргон зайлах үндэслэлтэй байвал та гав хэрэглэх ёстой. Аль болох ойрхон шалгаж, гар нь түлэгдэж, хайрагдах, холгох, шигдэж орох зэргийг урьдчилан тооцож шалгаж, хүнлэг байх зарчмаа хэзээ ч алдаж болохгүй.

Мөн сэжигтнийг мөрдөн байцаагч гадуур авч яваа үедээ удаан, чанга гавласнаас болоод хүний гар хөхөрч гэмтэх явдал байдаг.

Хүлэг хэрэглэх тухай

Хүлэгний материал нь хүний гар биед шигдэхээргүй, агшиж сунадаггүй, үрж гэмтэл учруулахааргүй, тасрахааргүй зөөлөн зүйлээр хийгдсэн байх шаардлагатай.

Хүлгийг хэрэглэхдээ 2 гарыг урд нь буюу ард нь холбож уях, шаардлагатай тохиолдолд хөдөлгөөнгүй зүйлээс хүлж болно. Гэхдээ холбож хүлсэн зүйл нь унаж дарах, цохихоос сэрэмжилнэ. Зөрчил гаргагчийн 2 гарыг урд нь хүлэхдээ тайлж болзошгүйг анхааралдаа авбал зохино. Хүлгийг хэрэглэхдээ 2 гарын бугуйгаар буюу эрхий хуруунуудын 2-р үеэ дээгүүр холбож хүлнэ.

ТУСГАЙ ХЭРЭГСЭЛ _____

Гарыг урд нь буюу ард нь хүлэхэд тухайн зөрчил гаргагчийн эсэргүүцэл зогсохгүй бол дөрвөлжин хүлэг хэрэглэнэ.

Баримт

1993 онд, Сүхбаатар дүүргийн эрүүлжүүлэх байрны цагдаа А нь, согтуугаар хэрцгий догшин авирласан этгээдийг дөрвөлжин хүлгээр удаан хугацаагаар чанга хүлжээ. Үүний улмаас агсан тавьсан этгээд ухаан алдаж, эмнэлгийн тусламж авах хэмжээнд хүрсэн байна.

Алдаа:

§ Дөрвөлжин хүлгээр хүлсэн хүнийг удаан хугацаагаар байлгасан

§ Хэт чанга хүлсэн

§ Эсэргүүцэл нь зогссон хойно хүлээтэй нь байлгасан

§ Байнгын хяналтанд, ухаан алдуулахгүй байлгах ёстой.

Анхаарах зүйл:

- Дөрвөлжин хүлэг нь, хүний биед гэмтэл учруулах магадлал өндөр тул түүнийг хэрэглэхдээ аюулгүй байдлыг сайн хангах ба хяналтгүй орхиж хэрхэвч болохгүй.

- Энэ төрлийн хүлгийг 1 цагаас илүү хугацаагаар хэрэглэж болохгүй

- Мөн хүүхэд болон жирэмсэн болох нь илэрхий мэдэгдэж байгаа хүнд хэрэглэхгүй.

Ороох цамц хэрэглэх тухай

Сэтгэл мэдрэлийн өвчний улмаас өөрийгөө жолоодох чадвараа алдсан буюу согтуу этгээд догшин хэрцгий авирлаж, цагдаагийн алба хаагчийн болон бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд хохирол учруулах, сэжигтэн яллагдагч амиа хорлохоор үйлдэл хийвэл ороох цамцыг хэрэглэнэ.

Ороох цамцыг даавуун эдлэлээр 2м урт ханцуйтай хийнэ. Ороох цамцыг хүний урд талаас өмсгөж, арын гурван бүчийг хөврөхөөр уяж, ханцуйтай гарыг урд нь зөрүүлэн, ханцуйг хоёр суган доогуур оруулан ар тийш татаж, нуруун дээр нь зөрүүлээд урагш эргүүлэн хоёр гарын булчинг даруулан, суган доогуур оруулан ар тийш татаж, нуруун дээр нь зөрүүлээд урагш эргүүлэн хоёр гарын булчинг даруулан, суган доогуур оруулж үзүүрийг зөрүүлэн буцааж ар нуруунд хөврөхөөр уяна.

Ороох цамцтай хүнийг байнгын хяналтанд байлгах ба нэг цагаас илүү хугацаагаар үргэлжлүүлэн хэрэглэж болохгүй. Нэг цагаас илүү хугацаагаар хэрэглэх шаардлагатай бол өөр арга ба тусгай хэрэгсэлтэй ээлжилнэ. Жирэмсэн болох нь илэрхий мэдэгдэж байгаа эмэгтэй хүнд ороох цамц, хэрэглэж болохгүй.

Ороох цамц хэрэглэхдээ анхаарах зүйл:

Сэтгэцийн өвчтэй хүнд ороох цамц хэрэглэхээр бол эмчийн зөвшөөрөл авах, эсвэл байлцуулах;

Сэжигтэн яллагдагчид ороох цамц хэрэглэсэн тохиолдолд байнгын хяналтанд байлгах;

Баримт

Цагдан хорих төвийн ажилтан амиа хорлох оролдлого хийсэн сэжигтэнд ороох цамц хэрэглэсэн байна. Ороох цамцтай сэжигтэн шатаар уруудаж явахдаа бүдэрч унаснаас толгойгоо гэмтээжээ.

Алдаа:

§ Ажилтан ороох цамцтай хүнийг шатаар өгсөж, уруудах үед нь түшиж, барьж яваагүй

§ Амиа хорлох оролдлого хийсэн сэжигтнийг өөр бусад оролдлого хийхээс сэрэмжлэн бүрэн хяналтанд аваагүйгээс болж унасан

Анхаарах зүйл:

Гэмт хэрэг үйлдсэндээ харамсах, нэр хүндээ унагасандаа гутрах зэрэг бусад тохиолдлуудаас болон амиа хорлох оролдлого хийсэн хүнийг өөр бусад оролдлого хийхээс сэрэмжлэн бүрэн хяналтанд авах ёстой. Ороох цамц, хүлэгтэй хүнд өндрөөс унаж осолдох, цонхоор үсрэх боломж олгохгүй байх хэрэгтэй.

Бороохой хэрэглэх тухай

Цагдаагийн алба хаагчийн хууль ёсны шаардлагыг зориуд биелүүлээгүй, илт эсэргүүцсэн, хамгаалалтанд байгаа объект руу довтолсон, бүлэглэн довтолсон, тухайн гэмт хэрэг зөрчил үйлдэгдэж байгаа үед уг үйлдлийг таслан зогсоох болон хамгаалах зорилгоор резинин буюу цахилгаан бороохойг хэрэглэнэ.

Бороохой хэрэглэхдээ анхаарах зүйл:

- Резинин бороохойгоор хүний биений толгой болон хэвлий, зүрхэн тус газар, бөөрний харалдаа, нуруун тус газар цохих;
- Цахилгаан бороохойг хүний нүүрэн тус газар, биеийн ил хэсэгт хэрэглэхийг тус тус хориглоно.
- Бороохой хэрэглэсэн үед зөрчил гаргагч нь эсэргүүцэл үзүүлэх, хаалт хийх зэргээр зөвшөөрөгдөөгүй газарт цохиулж болохыг анхаарах хэрэгтэй.

Нийтлэг зөрчил

Гэмт хэрэг, зөрчлийн учир шалгагдаж буй хүний гар, хуруунуудыг бороохойгоор цохих, гарт нь юм бариулж байгаад бороохой, гаваар цохьдог, зоддог, үүнийгээ “гэсгээлт” гэж ойлгодог зэрэг нь бүгд хууль зөрчсөн үйлдэл юм.

Алдаа:

§ Цагдаагийн ажилтан нь өөрийн эрхшээлд бүрэн орсон хүнийг бороохойдсон

§ Гав, бороохой зэрэг тусгай хэрэгслийг зориулалтын бусаар ашигласан

Анхаарах зүйл:

Гэмт хэрэг үйлдэж зөрчил гаргасан, шалгагдах явцад саатуулан ямар нэг эсэргүүцэл үзүүлээгүй байхад нь хийсэн хэргийнх нь төлөө цагдаа шийтгэх ёсгүй.

Гэмт хэрэгтэн болон сэжигтэнг барьсан бол дахин гэмт хэрэг үйлдэх, бусдын амь нас, эрүүл мэнд, эрх, эрх чөлөө, эд хөрөнгөд халдах, оргон зайлахаас урьдчилан сэргийлж гавлах, түр саатуулах эрхтэй /6 цаг хүртэл/.

Эсэргүүцэл үзүүлбэл хүлэг хэрэглэх, зэвсэггүй тулалдах мэх хэрэглэнэ. Гэхдээ хуульд заасан цагдаагийн алба хаагчийн эрх мэдлээ хэтрүүлэхгүй байх, тусгай хэрэгсэл, мэхийг зааврын дагуу зөв хэрэглэх ёстой.

Нэг бүрийн тусгай хэрэгсэл буюу бороохойг шаардлага гарсан үед уг этгээдийн (хэрэв хүүхэд, жирэмсэн эмэгтэй, илт өвчтэй буюу тахир дутуу хүн биш бол шүү) эрээн булчин, дал хавсарч, эсвэл тахим руу нь өөрт тохирсон байрлал, нөхцөл байдлаас хамаарч хэрэглэж болно.

Гэхдээ бороохой чинь заавал резинин байх шаардлагатай. Бороохойгоор цохих зайнд орж ирэхгүй буюу цохих боломжгүй бол амьсгал боогдуулагч, нулимс асгаруулагч ашиглавал зохино. Гэхдээ тухайн хүний нүүрэн хэсгээс 1-1.5 метрийн зайнаас ашиглах хэрэгтэй.

Ингээд эсэргүүцэл зогсохгүй бол байлдааны самбо, каратегийн мэхийг хэрэглэн аль болох цаг алдалгүйгээр буюу бусдад хохирол учруулахгүйгээр

баривчилж, гавлан цагдаагийн байгууллага, эрх бүхий албан тушаалтанд хүргэх буюу хүлээлгэн өгнө.

Мэдээж хэрэг, Та дээрх эрхээ эдлэхээс өмнө урьдчилан анхааруулж, сануулах бүх боломжоо ашиглах ёстой. Учир нь, дээрх арга хэрэгсэл мэхүүдийг хэрэглэхээс аргагүй, өөр гарцгүй болсон цагт л зөвхөн довтолгоо буюу эсэргүүцлийг, зогсоох зорилгоор ашиглана гэдгийг хэзээ ч мартаж болохгүй.

Цагдаагийн байгууллагын ажилтнуудын нэг алдаа нь гэмт этгээдтэй харьцах явцад үүссэн цочирдол уур, бухимдлаа гэмт этгээдийг номхорсон хойно нь үргэлжлүүлэн цээрлүүлэх, би чамаас илүү гэдгээ төрийн нэр барин мэдрүүлэх зорилгоор хүч хэрэглэдэг явдал юм. Энэ нь цагдаагийн алба хаагч өөрөө эрхээ хэтрүүлж бусдын эрх чөлөөнд халдаж байгаа гэмт үйлдэл. Яагаад гэвэл, гэмт хэрэгтнийг илрүүлж, баривчилж, гэмт үйлдлийг нь таслан зогсоосон гавьяатай хэдий ч хууль зөрчин зодож доромжилж, авилгал авбал тэр барьсан хүнээсээ хувцсаараа л ялгарна гэхээс биш хүний хувьд, хулгайчаас дор бөгөөд хамгийн жигшүүртэй хэрэгтэн болж байгаа нь тэр.

Зөвхөн шүүх л гэм буруутайг тогтоох зарчмыг хэзээ ч ямар ч үед мартаж болохгүй, бас ямар ч тохиолдол, орчинд цагдаа гэдгээ мартаж эрхгүй гэдгийг сануулья.

Мөн хэнийг ч эрүүдэн шүүж болохгүйг бүү март!!!

**БОРООХОЙ ХЭРЭГЛЭЖ
БОЛОХГҮЙ ЗАРИМ ТОХИОЛДОЛ**



Амьсгал боогдуулагч, нулимс асгаруулагч хэрэглэх тухай

Цагдаагийн байгууллагад ОХУ, БНХАУ, Герман зэрэг улсуудад үйлдвэрлэсэн 150 мл-ээр савлагдсан амьсгал боогдуулагч, нулимс асгаруулагчийг ашиглаж байна. Амьсгал боогдуулагч, нулимс асгаруулагчийг салхины эсрэг, ил галын дэргэд хэрэглэж болохгүй. Амьсгал боогдуулагч, нулимс асгаруулагчийг бусдад булаалгахааргүй зайнаас буюу 1-1.5 м-ын зайнаас салхины дээд талаас хэрэглэнэ.

Амьсгал боогдуулагч, нулимс асгаруулагч хэрэглэхдээ анхаарах зүйл:

Амьсгал боогдуулагч, нулимс асгаруулагчийг хүний нүүрэнд 1м-ээс ойр зайд хэрэглэх, халаасандаа сул хийж явахыг хориглодог бөгөөд зориулалтын гэрэнд хийж

ТУСГАЙ ХЭРЭГСЭЛ

бүсэндээ зүүж явбал зохино. Амьсгал боогдуулагч, нулимс асгаруулагчийг автомашины кабинд, галт тэрэгний тасалгаат өрөөнд, онгоцонд болон жижиг өрөөнд хэрэглэхгүй бөгөөд -20°C $+50^{\circ}\text{C}$ хэмд хадгална. Тэсрэх болон шатах магадлалтай учир ил гал, хүүхэд зэргээс хол байлгана.

Баримт

Нийслэлийн цагдаагийн газрын жижүүрийн шуурхай албаны ажилтан Ж – нь оюутны дотуур байранд дуудлагаар очиж ажиллахдаа, жижиг өрөөн дотор өөдөөс нь довтолсон 3 хүнд нулимс асгаруулагч хэрэглэхдээ өөрийгөө аюултай байдалд оруулжээ.

Алдаа:

§ Өрөөн доторхи сэжигтний тоог мэдэхгүй байж ганцаараа орсон;

§ Нулимс асгаруулагч хэрэглэх орчноо буруу үнэлсэн;

§ Тусгай хэрэгсэл хэрэглэх зааврыг дутуу судалсанаас өөрийгөө аюултай байдалд оруулсан;

§ Нулимс асгаруулагчийг жижиг өрөөн дотор хэрэглэхгүйгээр, байлдааны самбо, каратэгийн мэх, бороохой хэрэглэх ёстой байсан.

Анхаарах зүйл:

Цагдаагийн алба хаагч нь иргэд, гэмт хэрэгтэн хэнтэй ч харьцсан, хамгийн түрүүнд цагдаа гэдгээ хэлж (зарим тохиолдолд хашгирч, гэрэл дор зогсох гэх мэт) үнэмлэх, бичиг баримтаа боломжтой бол үзүүлж, ямар ч байсан эсрэг хүндээ, төрийн цагдаатай харьцаж



ТУСГАЙ ХЭРЭГСЭЛ

байгаа юм байна шүү гэдгийг эхний ээлжинд ойлгуулна.

Хийж байгаа буюу хийх гэж буй зарим ялангуяа гэмт хэрэгтний тухайд үйлдлээ үргэлжлүүлэхгүй байх нь зүйтэй гэдгийг цаг алдалгүй ойлгуулах хэрэгтэй. Ойлгуулж чадсан бол тухайн хүнийг өөртөө болон бусдад хохирол учруулахгүйн тулд гавлах болон хүлэх өөр ямар нэг хүч хэрэглэх шаардлага гарвал хуулийн дагуу ажиллана. Гэмт хэргийн газрыг (байр байдал, нөхцлийг өөрчлөхгүйгээр) гэмтээлгүйгээр уг газраас сэжигтэнг холдуулна. Харин ойлгуулах боломжгүй буюу ойлгохгүй бөгөөд ойлгохыг хүсэхгүй байвал тусгай хэрэгсэл болон бусад хүч хэрэглэж эхлэнэ. Гэхдээ орчин нөхцөлөө зөв үнэлж ямар хэмжээний хүч хэрэглэн уг үйлдлийг таслан зогсоох вэ? гэдэг нь таны овсгоо оюун ухаан, сонор сэрэмж, тэвчээрээс шалтгаална. Хуулийн дагуу, орчин тойрондоо аюулгүй байдлаар зорьсондоо хүрэх арга зам сонгож авах нь цагдаагийн алба хаагчийн мэргэжлийн ур чадварын “дүн” байдаг.

Резинин болон хуванцар сумтай, тор шидэгч бууг хэрэглэх тухай

Резинин болон хуванцар сумтай бууг цагдаагийн алба хаагчийн хууль ёсны шаардлагыг үл биелүүлсэн, хамгаалалтанд байгаа объект руу бүлэглэн довтолсон тохиолдолд толгой, нүүрнээс бусад газар буудаж хэрэглэнэ. Тор шидэгч бууг аюултай аргаар довтолсон довтолгоог зогсоох зорилгоор хэрэглэнэ.

Резинин болон хуванцар сумтай, тор шидэгч бууг хэрэглэхдээ анхаарах зүйл :

Резинин болон хуванцар сумтай, тор шидэгч бууг бусдад булаалгах, унагааж гэмтээх зэргээс болгоомжлох хэрэгтэй. Тор шидэгч бууг хэрэглэхдээ 10-25 м хүртлэх зайнд замдаа ямар нэг тээглэх зүйлгүй үед бай руугаа чиглүүлж буудна.

Баримт

1994 онд Өвөрхангай аймгийн Есөн зүйл суманд болсон Даншиг наадам дээр морьтой танхайрсан залуучууд цагдаа Г-гийн шаардлагыг биелүүлээгүй учир резинин сумтай буу ашиглажээ. Бууны сум танхайрсан залууг оноод ойж, хажууд нь явж байсан энгийн хүнийг оножээ.

Алдаа:

§ Резинин болон хуванцар сумтай бууг хэрэглэхдээ орчноо буруу үнэлсэн

§ Буудах хүний ойр орчинд байгаа энгийн иргэдэд нөлөөлөх эсэхийг тооцоогүй

Анхаарах зүйл:

Резинин болон хуванцар сумтай бууг хэрэглэхдээ орчноо зөв дүгнэж хаана ямар тохиолдолд хэрэглэх вэ гэдгээ зөв тооцох шаардлагатай. Олон хүн цугласан үйлчилгээний газар, наадмын талбай, ойр орчиндоо хатуу ханатай газар резинин болон хуванцар сумтай бууг хэрэглэхдээ, сум байнаасаа ойж гэмгүй иргэдийг хохироож болзошгүйг юуны түрүүн тооцвол зохино.

ТУСГАЙ ХЭРЭГСЭЛ

Хэт ойр зайнаас буюу 10 метрээс дотогш зайд хэрэглэвэл хүний биеийн ясыг хугалах буюу бэртээх магадлал өндөр байдаг байна.

3.Тээврийн хэрэгсэл албадан зогсоох тусгай хэрэгсэл

“Тээврийн хэрэгслийг зогсоох зорилгоор ашиглах зориулалттай төхөөрөмжийг тээврийн хэрэгсэл албадан зогсоох тусгай хэрэгсэл гэнэ”¹

Хүний амь нас, эрүүл мэндэд учирч болох бодит аюулыг таслан зогсоох шаардлага тулгарсан мөн сэжигтэн, яллагдагч, шүүгчдэгч өөрөө жолоодон зугатсан эсхүл тийм этгээдийг тээвэрлэн зугатсан тохиолдолд тээврийн хэрэгсэл албадан зогсоох тусгай хэрэгсэл хэрэглэх боломжгүй бол галт зэвсэг хэрэглэн эсхүл ачааны автомашин болон бусад зүйлээр хаалт тавьж тээврийн хэрэгслийг албадан зогсооно.²

Галт зэвсэг хэрэглэж тээврийн хэрэгслийг албадан зогсоохдоо жолооч болон зорчигчийг буудахгүй байх нөхцлийг хангана.

Ачааны автомашинаар хаалт тавихдаа шатахууны банкинд шууд цохилт ирэхгүй байхаар байрлуулна.

Тээврийн хэрэгслийг албадан зогсоох тохиолдолд түүний хурд, замын онцлог зэргээс шалтгаалж онхолдож, замаас гарах зэргээр жолооч, зорчигч, бусад хүмүүсийн амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учирч болзошгүй бөгөөд эдгээр нь зөрчил гаргагч этгээдийн үйлдлийг нийгмийн хор аюулын хэмжээнээс давахгүй байх ёстой.

¹ Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 44 дүгээр зүйл, ТМ.1998 №

² Цагдаагийн тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх заавар. ЦЕГ-ын даргын тушаал 1999 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн №75 тоот тушаал

Тээврийн хэрэгслийг албадан зогсоохын өмнө хурдыг хасах зорилгоор саад хэрэглэж болно.

Баримт

Замын цагдаагийн ажилтан Б нь, зөрчилтэй байх магадлалтай тээврийн хэрэгслийг зогсох дохио өгөхөд нь зогсолгүй зугтжээ. Уг тээврийн хэрэгслийн жолоочийг өөрт нь болон өөр бусдад хохирол учруулахгүйн тулд зогсоож шалгахаар дараагийн машиныг дайчилжээ. Дайчилсан машинаа өөрөө барин хөөн гүйцэж, зугтсан машиныг мөргөн зогсоожээ.

Алдаа:

§ Шууд мөргөн зогсоосон

§ Дайчилсан машиныг гэмтээсэн

§ Зугтсан тээврийн хэрэгслийн талаар төв рүүгээ мэдээлж зарлуулаагүй

§ Дараагийн цэг рүүгээ холбоогоор анхааруулаагүй

Анхаарах зүйл:

Аюултай гэмт хэрэгтэн, өөрийгөө хянах чадваргүй согтуу буюу мансуурсан этгээд явж байх үндэслэл нь тогтоогдсон, гарцаагүй тохиолдолд Цагдаагийн байгууллагын тухай хууль болон тээврийн хэрэгсэл албадан зогсоох зааврыг үндэслэн тээврийн хэрэгслийг албадан зогсоох арга хэмжээ авна.

Дээрх тохиолдолд дараагийн хэсэг рүүгээ сэжиг бүхий тээврийн хэрэгсэл зугтсан тухай мэдээлэн, бусад постонд уг машины марк, улсын дугаарыг яаралтай

ТУСГАЙ ХЭРЭГСЭЛ

мэдэгдэх шаардлагатай. Үг мэдээллийг авсан, зугтсан тээврийн хэрэгслийг угтсан замын цагдаагийн ажилтан нь орчиндоо аль болох аюулгүй аргаар тухайн тээврийн хэрэгслийг зогсоох арга хэмжээ авна. Үүнд зориулалтын хаалтын хэрэгсэл ашиглах, дугуй хагалагч (зараа) зам дээгүүр хөндлөн татах, хүнд даацын тээврийн хэрэгслээр замын зорчих хэсгийг хаах зэрэг бусад арга хэмжээг авна. Тодорхой шалтгаан нь мэдэгдээгүй үед бусдын тээврийн хэрэгслийг хөөж зогсоох, дайчлах явцдаа буруу шийдвэр гаргаж гэмтээвэл цагдаагийн алба хаагч өөрөө буруутан болно.

4. Хамгаалах тусгай хэрэгсэл

Хамгаалах тусгай хэрэгслийг цохилт, доргилт, уналт, дэлбэрэлтийн нөлөө, хорт утаа, дуу, гэрлийн нөлөө, хутга мэс гэх мэт зүйлээс хамгаалах зорилгоор хэрэглэнэ. Хамгаалах тусгай хэрэгсэлд төрөл бүрийн дуулга өмсгөл, бамбай, бээлий, хорт утаа, дуу, гэрлийн нөлөөнөөс хамгаалах баг өмсгөл, хамгаалах олс, уналтаас хамгаалах бусад төхөөрөмж багтана. Олон нийтийг хамарсан үймээн самуун, гэмт хэргийн дуудлаганд очих болон эргүүлд гарах үедээ хөдөлмөр хамгааллын шаардлага, зааврын дагуу, тухайн нөхцөлд тохирох тусгай хэрэгслийг заавал тавьж олгосон байх ёстой.

Баримт

2006 онд, удаа дараа жагсаал цуглаан болж Засгийн Газрын ордонд орохоор хэсэг хүмүүс дайрахад, хамгаалалтанд ажилласан цагдаагийн алба хаагчид

нэг ч тусгай хэрэгсэл болон хамгаалах хэрэгсэл ашиглаагүй. Зөвхөн гинжин хамгаалалтыг 2-3 давхар хийж ажилласнаас цөөнгүй алба хаагч бэртэж, хувцсаа уруулжээ.

Алдаа:

§ Цагдаагийн албан хаагчид шаардлагатай бүлгүүдэд хуваагдаж ажиллаагүй

§ Нэг бүрийн болон олон хүнд зэрэг нөлөөлөх тусгай хэрэгслийг ч бэлэн байдалд байлгаагүй

§ Хамгаалах тусгай хэрэгсэл бэлтгээгүй, ашиглаагүй

Анхаарах зүйл:

Цагдаагийн алба хаагчид нь аливаа жагсаал цуглаан, олон нийтийг хамарсан үймээн самууны үед ажиллахдаа хамгаалах тусгай хэрэгслийг бүрэн гүйцэд ашиглах хэрэгтэй. Шаардлагатай тохиолдолд олон хүнд зэрэг нөлөөлөх усан хөөрөг, нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч, утаан хөшиг үүсгэгчийг ашиглахад бэлэн байлгана. Цагдаагийн алба хаагч нь олныг хамарсан үймээн самуун, жагсаал цуглааны үед аль нэг талыг барилгүй ямарч тохиолдолд зөвхөн хууль сахиулах, эмх замбараагүй үйлдлийг таслан зогсоох үүрэгтэй.

5. Самбо, каратэ зэрэг зэвсэггүйгээр тулалдах мэх

Самбо, каратэ зэрэг зэвсэггүйгээр тулалдах мэх, байлдааны хувилбарыг онц ноцтой гэмт хэрэгтэнг баривчлах, өөрийн болон бусдын амь нас эрүүл мэндэд

ТУСГАЙ ХЭРЭГСЭЛ _____

аюул тохиолдсон үед хамгаалах, довтолгооныг зогсоох баривчлах зорилгоор ашиглаж болно.

Самбо, каратэ зэрэг зэвсэггүйгээр тулалдах мэхний байлдааны хувилбарт спортын төрлийн мэхнүүд ордог байна. Гэвч өнөөдөр манай улсад мөрдөгдөж байгаа хуулинд самбо, каратэ зэрэг зэвсэггүйгээр тулалдах мэх гэж үүнийг хэлнэ гэсэн тодорхойлсон заалт байхгүй. Гэхдээ аливаа тохиолдолд самбо, каратэ зэрэг зэвсэггүйгээр тулалдан мэх хэрэглэхдээ зөрчил гаргагчийн үйлдлийн хор аюулын хэр хэмжээнээс хэтрүүлж болохгүй.

Самбо, каратэ зэрэг зэвсэггүйгээр тулалдах мэхийг практик дээр галт зэвсэг тусгай хэрэгсэл хэрэглэхийн өмнө хэрэглэдэг боловч шүүхийн практикт самбо каратэ хэрэглэсэн хүн, хүн зодсон гэдэг ойлголтоор буруудах тохиолдол цөөнгүй гарч байна.

Гав, хүлэг, бороохойг буруу хэрэглэх, хэрэглэх ёсгүй хүнд хэрэглэх, нэг бүрийн тусгай хэрэгслийг орчноо дутуу үнэлж хэрэглэх, галт зэвсэгтэй болгоомжгүй харьцах зэрэг нь мэргэжлийн ур чадвар дутуу дулимаг байгаагийн нэг илрэл юм.

Баримт

2005 онд, Баянгол дүүргийн хэв журмын ажилтан Б, С, Г нар нь Сонгины амралтанд өдрөөр амарч байх үедээ дүрэмт хувцастайгаар ууж согтууран бусадтай бүлэглэн тус амралтанд амарч байсан жирийн иргэдийг зодож танхайрчээ.

Алдаа:

§ Дүрэмт хувцастай амралтанд явж, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн

§ Согтуугаар жирийн иргэдийг өдөөн хоргоож танхайрсан

§ Байлдааны самбо каратэ зэрэг зэвсэггүйгээр тулалдах мэхийг жирийн иргэдэд хэрэглэн гэмтээсэн

§ Цагдаагийн алба хаагчид олуулаа согтууруулах ундааны зүйл хэтрүүлэн хэрэглэж ёс зүйн ноцтой зөрчил дутагдал гарган, эрүүгийн хууль зөрчсөн

Анхаарах зүйл:

Цагдаагийн байгууллагын алба хаагчид нь амралт баяр ёслолын өдрүүдэд ажилгүй, амрах үедээ хамт олон, найз нөхдөөрөө нийлж амрах, алжаал ядаргаагаа тайлах эрхтэй боловч архи, согтууруулах ундааны зүйлийг хэтрүүлэн хэрэглэж нийгмийн хэв журмыг ноцтойгоор зөрчих нь цагдаагийн байгууллагад ёс зүйн хувьд шаардлага хангахгүй хүмүүс байсаар байна гэсэн үг! Цагдаагийн байгууллагын алба хаагчдад гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журмыг хамгаалах, хамгаалуулах үүднээс байлдааны самбо, каратэ зааж сургадаг. Харин сурсан зэвсэггүйгээр тулалдах мэхээ энгийн ард иргэдэд хүчирхийллийн чанартайгаар хэрэглэх ёсгүй билээ.

ГАЛТ ЗЭВСЭГ

Цагдаагийн байгууллага нь өөрт байгаа галт зэвсэг, тусгай хэрэгслийг өөрийн боломжийн хирээр нэмэгдүүлж, шинэчлэн сайжруулж байдаг билээ. Нэг үеэ бодвол зэвсэглэсэн гэмт хэрэгтэнтэй тэмцдэг тусгай алба, ажилтнууд бий болж, ард иргэдийг гэмт халдлагаас хамгаалах болсон боловч нийгэм, цаг үе, эрүүгийн нөхцөл байдалтай харьцуулахад хоцрогдонгуй зэвсэг, техник хэрэгсэл ашигласаар байна.

Цагдаагийн байгууллага нь өөрийн гэсэн хуульгүй олон жил явж ирсэн ч 1993 онд Цагдаагийн байгууллагын тухай хууль анх удаа батлагдаж уг хуульд галт зэвсэг хэрэглэх талаар мөн анх удаа тусгажээ.

“Цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах, харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэх алба хаагчиддаа галт зэвсэг олгох, алба хаагчид нь уул зэвсгийг биедээ авч явах эрхтэй.”¹

Хэв журам сахиулах албан тушаалтан галт зэвсэг хэрэглэх талаар тусгай курст суралцаж төгссөний дараа галт зэвсгийг биедээ зохих зөвшөөрлийн дагуу авч явах ёстой.²

Гэмт хэрэгтэй тэмцэх, хэв журам хамгаалах, харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэх үедээ биедээ галт зэвсэг авч явах эрхээ урвуулан ашиглах, ан гөрөө хийх, хувийн асуудлаас болж бусадтай маргалдаж зөрчилдсөн юмуу, сэтгэл хөдлөл, айж сандрах үедээ өөрийн хийсвэр төсөөллөөр ашиглаж хэрхэвч болохгүйг анхаар.

¹ Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 1

² “Шүүх эрх мэдлийн салбар дахь хүний эрх” 97 дахь тал. /1990 оны 8 дугаар сарын 27-ноос 9 дүгээр сарын 7-ны хооронд хуралдсан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эрх зүйн зөрчил гаргагчидтай харьцах асуудлаархи НҮБ-ын 8 дугаар их хурал”-аас баталсан “Нийгмийн хэв журам сахиулах үүрэг бүхий албан тушаалтан галт зэвсэг болон хүч хэрэглэх үндсэн зарчмууд” 19-р зүйл/

Өөрөөр хэлбэл, бодит заналхийлэл учраагүй үед буюу ам хэлээр ална, халдана, довтолно гэсэн болгоны төлөө галт зэвсэг хэрэглэхгүй гэсэн үг бөгөөд, цагдаагийн алба хаагч болон бусад эргэн тойронд байгаа хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой аюул, хохирол бодитойгоор учруулж болзошгүй байдлаар довтолсон, эсэргүүцсэн үед л галт зэвсэг хэрэглэх тухай асуудал хуулийн хүрээнд яригдана. Гэхдээ боломжтой нөхцөл байдлыг харан, аль болох галт зэвсэг хэрэглэх тухайгаа хэлж анхааруулах, хий буудах, бүр боломж хомсдвол амин бус газар нь буудаж довтолгоо, эсэргүүцлийг таслан зогсоох хэрэгтэй.

Харин галт зэвсэг хэрэглэсэн даруйдаа хохирогчид боломжтой бүхий л эмнэлгийн анхны тусламж үзүүлж, өөрийн удирдлагад мэдэгдэн аль болох цаг хожиж эмнэлгийн тусламж дуудах шаардлагатай. Гэхдээ, шархадсан хүнд ойртохдоо, мөн бүлэглэн халдсан үед хохирогчид тусламж үзүүлэх үедээ, довтлогч болон хамтрагчдын довтлох санаа гүйцэд арилаагүй байгаа гэдгийг мартуузай. Энэ нь өөрийгөө төдийгүй өрөөл бусдыг хамгаална гэсэн үг. Гэмт үйлдэл бүрэн гүйцэд таслан зогсоогдоогүй үед сонор сэрэмжтэй байхын зэрэгцээ, Та галт зэвсэг хэрэглэх үедээ орчин тойрноо сайтар анзаарч соргог хандвал зохино. Учир нь өөрийн эзэмшиж байгаа бууны сумны нисэлтийн хүч, алах, нэвтлэх чадвар зэргийг сайн мэддэг байх шаардлагатай. Галт зэвсэг хэрэглэх үед гэмт этгээдийн ард шатамхай бодис, дэлбэрэх магадлалтай зүйл болон энгийн иргэд өртөж болзошгүй байдлыг аль болох анзаарч байх ёстойгоос гадна алдаа гаргахгүйн тулд байнга сургуулилж

ГАЛТ ЗЭВСЭГ

дадлагажих, сэтгэл зүйн хувьд өөрийгөө бэлтгэж байх хэрэгтэй.

Цагдаагийн алба хаагч зөвхөн гэмт хэрэгтэй тэмцэх буюу албан үүрэг гүйцэтгэх үедээ галт зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэх эрхтэй байдаг. Гэвч ажил дуусаагүй, албаны шаардлага, орой юм уу, шөнө дунд тарсан гэх мэт шалтгаар албаны бус цагаар галт зэвсэг, тусгай хэрэгслийг авч явж, харьцаж байдаг бөгөөд үүнээс үүдэн золгүй, хариуцлагагүй байдал цөөнгүй гарсан байдаг.

Баримт

2002 онд Дорноговь аймагт цагдаагийн байгууллагын ажилтан эхнэрээ хардан, албаны гар буугаар бусдыг буудсан.

Алдаа:

- § Албан үүрэг гүйцэтгээгүй үедээ галт зэвсэг авч явсан
- § Хувийн зорилгоор галт зэвсэг ашигласан
- § Өш хонзон авахад ашигласан
- § Тухайн ажилтаны албаны болон сэтгэл зүйн бэлтгэл муу байсан

Анхаарах зүйл:

Галт зэвсэг тавьж олгох, хурааж авах журам цагдаагийн анги байгууллагууд дээр тэр бүр мөрдөгддөггүй. Тусгай хэлтсээс бусад анги байгууллагуудад галт зэвсэг хариуцсан орон тоо байдаггүйгээс уг ажлыг ямар нэг албан тушаалтанд хавсаргах байдлаар хариуцуулдаг явдлыг өөрчлөн шийдвэрлэх хэрэгтэй юм.

Буу, галт хэрэгслийг хууль бус зүйлд, зүй бусаар ашиглаж байна гэдэг бол цагдаагийн алба хаагчийн хувьд мэргэжил, ёс зүй, нэр хүндэд харш аюултай уршиг тарьж болох үйлдэл.

“Хэв журам сахиулах үүрэг бүхий албан тушаалтан хүч, галт зэвсэг хэрэглэх зайлшгүй шаардлагад хүрэхийн өмнө хүч хэрэглэхгүй зохицуулах боломжтой бүх арга хэрэгслийг ашиглаж үүргээ гүйцэтгэнэ. Тэд зөвхөн бусад төрлийн арга хэрэгсэл хэрэглээд тодорхой үр дүнд хүрээгүй, ашиггүй болсон буюу үр дүнд хүрэх найдлагагүй болсон нөхцөлд л хүч, галт зэвсэг хэрэглэж болно.

Баримт

БНХАУ-ын ЭСЯ-ны байрны хамгаалалтанд гарч байсан цагдаа Г албан үүргээ гүйцэтгэж байгаад галт зэвсгээ бусдад алдан амь насаа алдсан.

Алдаа:

§ Онц чухал объект дээр албан үүрэг гүйцэтгэж байх үедээ сонор сэрэмж алдсан

§ Шөнийн цагт үл мэдэгдэх хүнтэй хэт ойроос харьцаж, дүрэм журмаа зөрчсөн

§ Ганц хүн ажилладаг онц чухал объектод алба удирдлагын зүгээс тавих хяналт, сургалт бэлтгэл дутагдсан

Анхаарах зүйл:

Шөнийн цагт үүрэг гүйцэтгэж байх үедээ өндөр сонор сэрэмжтэй ажиллах ёстой. Хамгаалалтанд байгаа объектын ойр орчинд сэжигтэйгээр мэдэгдсэн аливаа нэг хөдөлгөөнийг тэр даруйд нь төвдөө мэдэгдэж байх шаардлагатай. Албан үүрэг гүйцэтгэж байгаа постонд гадны хүнийг нэвтрүүлэхгүй байх, ялангуяа хэн нь танигдахгүй хүнийг өөртөө ойртуулахгүй байхаас гадна таньдаг хүнтэйгээ ч албаны журмаар харьцахаас аргагүй. Эргүүл шалгалтаар яваа боловч нууц үг, дохио ашиглаагүй хэнийг ч ойртуулахгүй байх. Албан үүрэг гүйцэтгэж байгаа үедээ буюу хадгалах биш шаардлагатай үед ашиглахад хэзээд бэлэн байх ёстой. Цагдаагийн алба хаагчдыг онцгой объектод хосын системээр ажиллуулдаг байх нь аюулгүй байдлыг хангахад чухал.

Буугаар тоглох, буугаар онцын шаардлагагүй үед оролдох, буутай харьцах чадварыг эзэмшиж чадаагүйгээс алдаа гаргаж осолдох, буугаа гэмт хэрэгтэнд алдах зэрэг асуудал гарсаар байгаа нь цагдаагийн албаны сургалтыг анхаарах болсны нэг гэрч юм.

Баримт

Дархан Уул аймгийн цагдаагийн офицер албаны галт зэвсгээр амь насаа егүүтгэсэн. Мөн Дорноговь аймагт өөр нэг алба хаагч ахуйн асуудлаас болж өөрийгөө буудсан.

Алдаа:

§ Албан үүрэг гүйцэтгээгүй үедээ галт зэвсэг авч явсан

§ Хувийн зорилгоор галт зэвсэг ашигласан

§ Тухайн ажилтны албаны болон сэтгэл зүйн бэлтгэл муу байсан

§ Цагдаагийн албаны дарга нар нь, алба хаагчдын ахуй амьдрал, сэтгэл зүйн байдал чөлөөт цагаа өнгөрөөж байгаа байдал, хувийн ямар асуудал байгаа зэрэг алба хаагчдын нийгмийн байдалд тавих анхаарлыг сулруулж, урьдчилан сэргийлж чадаагүй.

§ Алба хаагчийн хувийн эрх ашиг, албаны эрх үүргээс өндөрт тавигдсан

Анхаарах зүйл:

Цагдаагийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан, хэзээ, хаана, хэнд галт зэвсэг олгогдсон, юунд ашиглагдаж байгааг хянаж байх ёстой. Онц хүнд гэмт хэрэг гарсан үед болон галт зэвсэг шаардагдах магадлалтай үед галт зэвсгийг зохих журмын дагуу тавьж олгодог бөгөөд түүнийг хэрэглэх, хэрэглэж болзошгүй ажиллагаа дууссан үед галт зэвсэг болон сумыг тоо ёсоор нь даруй хураан авдаг байх шаардлагатай. Цагдаагийн алба хаагч нь өөрийн зан байдлын онцлог албаны бэлтгэл, ахуй нөхцөл болон сэтгэл санааны хямралтай үедээ галт зэвсэг тусгай хэрэгслийг биедээ авч явахгүй байх нь зохимжтой.

ГАЛТ ЗЭВСЭГ

ГАЛТ ЗЭВСЭГ ХЭРЭГЛЭХДЭЭ АНХААРАХ ЗҮЙЛ

§ олон хүнтэй газар

§ нийтийн үйлчилгээний унаа болон үзвэр

үйлчилгээний газар

§ халдлага зогссон үед

§ гэмт этгээд бууж өгсөн

§ сэжигтэн танигдахгүй үед

§ хүүхэд болон жирэмсэн болох нь илэрхий мэдэгдэж байгаа хүмүүст

Тайлбар: Гэхдээ олон хүнтэй газрыг ашиглаж эсхүл хүүхэд, жирэмсэн эмэгтэйн дүрээр таны буюу бусдын амь нас, эрүүл мэндэд галт зэвсэг хэрэглэн халдахаар завдвал цагдаагийн албан хаагч нь галт зэвсэг хэрэглэж болно.

Галт зэвсэг хэрэглэх тохиолдол

§ Цагдаагийн алба хаагчид болон бусад хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болзошгүй байдлаар довтолсон;

§ Хамгаалалтанд байгаа объект руу халдсан, шаардлагыг үл биелүүлэн зугтаасан, эсвэл эсэргүүцсэн;

§ Хамгаалалтанд байгаа объект руу зэвсэглэж буюу бүлэглэж довтолсон;

§ Хүнийг барьцаанд авсан;

§ Ялтан, цагдан хоригдож байгаа хүн оргосон;

§ Онц хүнд гэмт хэрэгтэн зугтах буюу довтолсон;

§ Зэвсэглэсэн этгээд зэвсгээ хураалгах буюу хаях шаардлагыг биелүүлээгүй, эсэргүүцсэн;

§ Хуяглан хүргэж яваа этгээдийг суллахаар зэвсэглэн буюу бүлэглэн довтолсон;

§ Хорих, цагдан хорих, баривчлах байранд эмх замбараагүй байдал үүсч бусдын эд хөрөнгө, амь насанд бодит хохирол учрах нөхцөл үүссэн.

Галт зэвсэг хэрэглэсэн цагдаагийн алба хаагч нь тусгай тайлан бичнэ. Хүний амь нас хохирсон хүндээр шархадсан, бусад хүнд хор хохирол учруулсан тухай бүрт хэрэг бүрдүүлэх үүрэгтэй хараат бус захиргааны буюу шүүхийн хяналт хэрэгжүүлэгч байгууллагад тодорхой илтгэнэ.¹

Олон улсын эрх зүйд “Энэхүү тайланд бичсэн үйлдлийг захиргааны буюу шүүн таслах байгууллагаар байцаан шийтгэх хуулийг Засгийн газар болон хууль сахиулах байгууллага тогтоох ёстой” гэж заасан байдаг.

¹ “Шүүх эрх мэдлийн салбар дахь хүний эрх” 97 дахь тал /1990 оны 8 дугаар сарын 27-ноос 9 дүгээр сарын 7-ны хооронд хуралдсан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эрх зүйн зөрчил гаргагчидтай харьцах асуудлаархи НҮБ-ын 8 дугаар их хурал”-аас баталсан “Нийгмийн хэв журам сахиулах үүрэг бүхий албан тушаалтан галт зэвсэг болон хүч хэрэглэх үндсэн зарчмууд” 22-р зүйл/

ХҮЧ ХЭРЭГЛЭСНИЙ ДАРАА ҮЗҮҮЛЭХ ЭМНЭЛГИЙН АНХНЫ ТУСЛАМЖ

Цагдаагийн байгууллагын алба хаагч албан үүрэг гүйцэтгэх явцдаа галт зэвсэг, тусгай хэрэгслийг бусдад хүч хэрэглэсэн тохиолдолд наад захын эмнэлгийн анхны тусламж үзүүлэх шаардлагатай. Ер нь ямар ч осол аюул тохиолдсон үед анхны тусламжийг зөв, тодорхой дэс дараалалтайгаар үзүүлэх явдал нь цагдаагийн ажилтны мэдлэг, чадварын нэг үзүүлэлт мөн.

“Анхны тусламж гэдэг нь аливаа осол гэмтэл, гэнэтийн биеийн хямрал, өвчин эмгэгийн үед эмнэлгийн тусламж иртэл, гарын доорхи материалыг ашиглан, өөртөө болон нөхөртөө үзүүлэх тусламжийг хэлдэг. Өөрөөр хэлбэл эмнэлгийн мэргэжлийн бус жирийн ард иргэдийн өөртөө болон нөхөртөө үзүүлж байгаа тусламжийг анхны тусламж гэж нэрлэх ба үүнийг эмнэлгийн мэргэжлийн түвшинд үзүүлж байгаа анхны тусламжаас ялгаж ойлгох хэрэгтэй.

Анхны тусламжийг зөв үзүүлснээр:

§ Амь насыг аврах

§ Осол гэмтлээс шалтгаалсан бусад хүндрэлүүдээс сэргийлэх

§ Эдгэрэлтийг түргэсгэх

§ Эмчилгээний зардлыг бууруулах

§ Хөдөлмөрийн чадвар алдалтын хугацааг богиносгох зэрэг эерэг үр дагаврыг бий болгоно¹ гэжээ.

Алба хаагчийг албан үүргээ биелүүлэх явцад бусдад гав бороохой, нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч,

¹Осол гэмтлийн үед үзүүлэх анхны тусламж

_____ ХҮЧ ХЭРЭГЛЭСНИЙ ДАРАА ҮЗҮҮЛЭХ ЭМНЭЛГИЙН АНХНЫ ТУСЛАМЖ хүлэг болон ороох цамц хэрэглэх, гэмт этгээдийн ашиглаж буй тээврийн хэрэгслийг албадан зогсоох үед машин, мотоцикл унадаг дугуй хажуулах, онхолдох тохиолдолд хүн гэмтэх, осолдох, хаалга цонхоор нь хүн шидэгдэж унах, мөн тээврийн хэрэгсэлдээ даруулах гэх мэт маш олон тохиолдол гарч болно. Энэ л үед та, өөрийн болон бусдын амь нас эд зүйлийг аварч чадсан ч хэрэгтний амь биед халтай гэмтэл тохиолдсон үед эмнэлгийн анхны тусламж үзүүлэх шаардлагатай болно. Ийм тохиолдолд дараах зөвлөмжийг зайлшгүй ашиглах нь зүйтэй.

§ өвчтөний биеийн байдалд үнэлгээ өгөх

§ орчин тойрны байдалд үнэлгээ өгөх

§ амьсгал зүрх судас болон сэтгэцийн байдлыг үнэлэх

§ эцэст нь биеийн ерөнхий байдалд үнэлгээ өгч, анхны шаардлагатай тусламж үзүүлнэ.

Гэмтэл авсан хүний биеийн байдал сайжирч, эсвэл муудаж байгааг байнга хянах шаардлагатай тул энэ нь тасралтгүй үйл ажиллагаа юм.

Орчны байдал, өвчтөний биеийн байдалд бодит үнэлгээ өгөхөд хүндрэлтэй болгож болзошгүй. Гадна орчинд анхаарал сарниулах олон хүчин зүйлс байгаа бол, /чимээ, гаднах орчны хөдөлгөөн гэх мэт/ та тухайн газарт өвчтөний биеийн байдалд бодит үнэлгээ өгөх болон өвчтөнийг цаг алдалгүй эмнэлэгт хүргэх гэсэн хоёр арга хэмжээг хослуулан хийх шаардлагатай. Эхлээд та үзлэг хийх төлөвлөгөөг, өөрийн санаанд боловсруулах хэрэгтэй. Амьсгал аюултай хүчин зүйлс ба бусад асуудлуудыг шийдэхийн сацуу гэмтэгсдийг тээврийн хэрэгсэлд байрлуулах, эмнэлэг рүү тээвэрлэх, эмнэлэгтэй



ХҮЧ ХЭРЭГЛЭСНИЙ ДАРАА ҮЗҮҮЛЭХ ЭМНЭЛГИЙН АНХНЫ ТУСЛАМЖ _____
холбоо барих, шаардлагатай мэдээллийг өгөх үйл
ажиллагаа нь тус бүртээ хугацаа шаардана.

Гэмтсэн хүнд анхаарлаа хандуулахаас гадна бусад
өвчин эмгэгийг анзаарч байх хэрэгтэй.

Амин чухал шинж тэмдгүүд

Анагаах ухаанд үндсэн дөрвөн амин чухал шинж тэмдэг
байдаг байна. Үүнд: цусны даралт, судасны лугшилт,
амьсгал болон биеийн дулаан. Анхны тусламжийн үед
эхний гурван шинжийг голчлон үздэг ба биеийн дулааныг
харьцангуй цөөн үздэг.

Насанд хүрсэн хүний хэвийн үзүүлэлт

Агшилтын даралт

§ Эрэгтэй 120-150

§ Эмэгтэй 110-140

§ Лугшилт 60-80

§ Амьсгалын тоо 12-20

§ Биеийн температур 37°

Цагдаагийн байгууллагын ажилтан галт зэвсэг
хэрэглэлээ гэж бодъё. Тухайн буудуулсан хүн цагдаад
буудуулаад халдлага, довтолгоо, эсэргүүцлээ зогсоовол
уг этгээдэд цагдаагийн ажилтан эмнэлгийн анхны
тусламж үзүүлэх шаардлагатай болно. Энэ нөхцөлд чухам
юу хийх вэ?

Анхны тусламж үзүүлэхдээ орчноо зөв үнэлж дүгнэн
хамтрагч этгээд нь ойр хавьд чинь байгаа үгүйг эхлээд
тогтоох хэрэгтэй. Дараа нь орчин тойрондоо байгаа
шударга иргэдэд зөв ойлгуулан, эмнэлэг болон нэмэгдэл
хүч дуудахыг хүсэх, боломжгүй бол өөрийн бололцоогоор
дуудлага өгнө. Энэ нь гар утас, богино долгионы станц,
бусдын гар утас зэргийг ашиглан дуудахыг хэлнэ.

ХҮЧ ХЭРЭГЛЭСНИЙ ДАРАА ҮЗҮҮЛЭХ ЭМНЭЛГИЙН АНХНЫ ТУСЛАМЖ

Буудуулж эсэргүүцэл үзүүлэхээ больсон, эсвэл довтлохоо больсон этгээдийн биед анхаарал болгоомжтой дөхөж очин, хамгийн түрүүнд түүний зэвсгийг гэмт хэрэгтнээс холдуулан аюулгүй болгох, баашлан хэвтэж байгаад ойртож ирэхийг чинь хүлээж байж магадгүйг анхааран өөрийн бууг байлдаанд бэлнээр барин ойртоно. Осол аюулгүйг бүрэн мэдэрсэн үед хэрэгтэн ямар гэмтэл авсан, аль зэрэг хүнд гэмтсэнийг шалган үзэж, үнэхээр дахин довтлох чадваргүй болсон байвал та одоо, тэр хүний амийг аврахын тулд эмнэлгийн мэргэжлийн бус анхны тусламж яаралтай үзүүлэх хэрэгтэй.

Үүнд эхлээд:

§ гарынхаа долоовор хуруу дунд хуруу хоёрын өндгөн хэсгээр хамрын нүхэнд ойртуулан, амьсгалж байгаа эсэхийг шалгах;

§ хүзүүний хоёр талд байрлах гол судсанд хуруугаа зөөлөн хүргэж, зүрхний цохилтыг мэдрэх;

§ гарын шууны дотор талын судаснаас барин үзэж, цохилж буй эсэхийг үзэх;

§ амьд байгаа тохиолдолд, хаанаа ямар шарх авсныг тогтоох;

§ уг шарх нь ямар нэг эрхтний яс дайрч гэмтээсэн эсэхийг зөөлөн дарж, хөдөлгөж үзэх

§ алдаж буй цусыг тогтоох арга хэмжээ яаралтай авах;

§ Хэрэв хөл болон гарын аль нэг яс хугарсан байвал шархны дээд талаар бүс болон үдээс, боолт зэрэг гарын доорхи материалыг ашиглан яаралтай боох;

§ шархны цусны гоожилтыг багасган, шархан дээр цэвэр марль, материал тавин боох;

§ уг хугарсан хэсэгт, тухайн үед олдох боломжтой хатуу, хатуувтар биетээр чиг барин боож, эмнэлгийн түргэн



ХҮЧ ХЭРЭГЛЭСНИЙ ДАРАА ҮЗҮҮЛЭХ ЭМНЭЛГИЙН АНХНЫ ТУСЛАМЖ

тусламж иртэл буюу өөрийн боломжоор эмнэлэгт яаралтай хүргэж өгөх шаардлагатай.

Ингэснээр Та албан үүргээ биелүүлж, магадлал өндөртэй аюулаас өөрийгөө болон бусдыг хамгаалаад зогсохгүй гэмт хэрэгтнийг хүнийх нь хувьд аварч байгаа юм. Албан үүрэг гүйцэтгээгүй үедээ, эсвэл хууль бус тушаалаар галт зэвсэг хэрэглэхийг олон улсын хэм хэмжээнд дараах байдлаар авч үздэг байна.

“Хүч, галт зэвсэг хэрэглэх талаар дээд тушаалын албан тушаалтнаас өгсөн тушаал нь илт хууль бус болохыг мэдсэн атлаа бусдын амь нас хохироосон буюу хүнд шархдуулсан бол түүнээс ухаалгаар татгалзаагүй хэв журам сахиулах албан тушаалтанг дээд тушаалын хүний тушаал биелүүлсэн гэж хариуцлагаас чөлөөлөхгүй. Харин ямар ч тохиолдолд, хууль бус тушаал өгсөн албан тушаалтанд нэгэн адил хариуцлага хүлээлгэнэ.”¹

Харин албан үүрэг гүйцэтгэх үедээ хүч хэрэглэвэл хэрхэх тухайд:

“Хэв журам сахиулах үүрэг бүхий албан тушаалтан хүч галт зэвсэг зайлшгүй хэрэглэх болсон тохиолдол бүрт:

а/ зөрчлийн хүнд, хөнгөн, гарч болох үр дагаврыг нарийн тооцож хүлээцтэй хандах,

б/ аль болох бага хор хохирол, шарх үүсгэх үүднээс хандаж хүний амь насыг хамгаалах,

в/ шархадсан буюу бусад байдлаар хохирсон хэнд ч, аль болох богино хугацаанд эмнэлгийн болон бусад тусламж үзүүлэх,

¹ Хүний эрх- Шүүх эрх мэдлийн салбар дахь хүний эрх 1996 он 98 дахь нүүр 26-р зүйл

ХҮЧ ХЭРЭГЛЭСНИЙ ДАРАА ҮЗҮҮЛЭХ ЭМНЭЛГИЙН АНХНЫ ТУСЛАМЖ

г/ шархадсан буюу бусад байдлаар хохирсон этгээдийн эцэг, эх, төрөл төрөгсөд, ойр дотны найз нөхдөд богино хугацаанд мэдээлэх боломжоор хангах²

Цагдаагийн алба хаагч нь албан үүрэг гүйцэтгэх үедээ өөрийн болон захирах даргын шийдвэрээр хүч хэрэглэсний улмаас бусдыг гэмтээвэл зайлшгүй эмнэлгийн анхны тусламж үзүүлэх ёстойг дээрх байдлаар тусгажээ.

Баримт

1992 онд дэнжийн мянгын бараан зах дээр бусдын халаасыг суйлж түрийвчтэй мөнгийг аваад цагдаагаас зугтаасан хүн зам хөндлөн гарахдаа авто машинд мөргүүлжээ. Тухайн хүнийг хөөж барьсан Эргүүл хамгаалалтын 0801 ангийн цагдаа Г нь хохирогчид түрийвчтэй мөнгийг нь буцааж өгөөд гэмтсэн хүнийг гэмтлийн эмнэлэгт хүргээд орхижээ.

Алдаа:

§ Цагдаа Г нь гэмт хэрэгтнийг цаг алдалгүй хурдан баривчилсан боловч хэн болохыг нь гүйцэд тогтоогоогүй.

§ Гэнэтийн осол гэмтэлтэй тулгарсан үед боох, цус тогтоох анхны тусламж үзүүлээгүй.

§ Хулгайн хэрэгт холбогдогчийг хэдийгээр цаг алдалгүй гэмтлийн эмнэлэгт хүргэж өгсөн боловч орхиод явсан.

§ Хохирогчид эд зүйлийг нь бүрэн бүтэн хүлээлгэж өгсөн боловч хохирогчоо хаанахын хэн болохыг нь тогтоогоогүй.

§ Гэмт хэрэгтэнд ял завших боломж олгосон.

² Хүний эрх- Шүүх эрх мэдлийн салбар дахь хүний эрх 1996 он 94 дахь нүүр 5-р зүйл

Анхаарах зүйл:

Цагдаагийн байгууллагын алба хаагчийг нь албан үүрэг гүйцэтгэж байхад ямар нэг гэмтэж бэртэх тохиолдол олонтой таардаг. Гэмт этгээд зугатсан үед түүнийг баривчлах гэж явахдаа бусдыг аваар, осолд оруулахгүй, гэмтээхгүй байх талаар онцгой анхаарвал зохино. Дээрх жишээнд дурдсан цагдаа Г албан үүргээ биелүүлсэн боловч цаг алдахгүй гэсэн бодолдоо хэт хөтлөгдөн хохирогч холбогдогч нарыг хэн бэ гэдгийг гүйцэд тогтоолгүй хөнгөн гоомой хандсан байх ба зүй нь холбогдох мэдээллийг тушаалтанд өгч зохих арга хэмжээг авахуулах, эргээд юу болсон бэ гэдгийг мэдэх ёстой байв.

Баримт

1993 онд Хайлаастын уурын зууханд шөнийн 22 цагийн орчимд гаднаас согтуу хүн орж ирж, уурын зуухны галчид буу тулган архины мөнгө нэхжээ. Уурын зуухны галч тулгасан бууг нь булааж авах гэж ноцолдон, буудуулсан хэрэг гарчээ. Хэргийн газар дээр тусгай тасгийн бүрэлдэхүүн ажиллаж хэрэгтэнг аюулгүй болгож 102-ын бүрэлдэхүүнд хүлээлгэн өгчээ. Харин 102-ын бүрэлдэхүүн гавгүйгээр хүлээж аван хэрэг бүртгэлт шууд явуулжээ.

Алдаа:

§ 102-ын бүрэлдэхүүн уг этгээдийг гавгүйгээр өрөөндөө суулгаж байсан

§ Буудуулсан хохирогчийг шууд эмнэлэгт хүргэж өгөлгүйгээр, тайлбар авч байсан

§ Эмнэлэгт хүргэж өгөхийн оронд түргэн тусламж, телевизийн сурвалжлагч дуудсан

Анхаарах зүйл:

Зүй нь гэмт хэргийн улмаас хохирч гэмтэл авсан хүнийг аль болох яаралтай, цаг алдалгүйгээр эмнэлэгт хүргэх ёстой.

Баримт

1999 онд Чингэлтэй дүүргийн “Нарны титэм” үйлчилгээний төвийн ард байрлах 9 давхар байрны 9-р давхарт оршин суугч этгээд, хоёр гартаа хутга барин зэвсэглэж эхнэрийнхээ биеийг сийчиж байна гэсэн дуудлагаар Чингэлтэй дүүргийн жижүүрийн бүрэлдэхүүн очсон боловч дорвитой арга хэмжээ авч чадалгүйгээр тусгай тасгийг дуудан уг этгээдийг баривчилжээ.

Алдаа:

§ Тухайн жижүүрийн бүрэлдэхүүн хутгаар зэвсэглэсэн гэмт хэрэгтэнг баривчлах мэргэжлийн ур чадвар дутсан

§ Гэмт хэрэгтэнтэй сэтгэл зүйн ярилцлага хийж буулгаж авч чадаагүй

§ Нөхөртөө хутгалуулсан эхнэр нь дотор байгааг мэдсээр байж эмнэлгийн түргэн тусламж яаралтай дуудаагүйгээс болж хохирогчийн биеийн байдал муудсан

§ Онц ноцтой хэргийн дуудлага, мэдээлэл авсан даруйдаа болзошгүй тохиолдлоос урьдчилан сэргийлж түргэн тусламж дуудан хамт очоогүй байна

Анхаарах зүйл:

Цагдаагийн байгууллагын нийгмийн хэв журам сахиулах, гэмт хэрэгтэй тэмцэх үүрэг бүхий алба хаагчид ойр зуурын хүйтэн зэвсэг, хутга, мод чулуугаар зэвсэглэсэн хүнийг баривчлах чадвартай байх ёстой. Тухайн гэмт хэргийн үйлдлийг өөрсдийн хүчээр таслан зогсоох боломжгүйгээ мэдсэн даруйдаа холбогдох дарга, албадуудад яаралтай мэдэгдэн нэмэлт тусламжийг цаг алдалгүйгээр авах ёстой. Цагдаагийн газар хэлтсүүдийн жижүүрийн бүрэлдэхүүнд сэтгэл зүйчээр давхар мэргэшсэн алба хаагч ажиллах нь зарим нэг төрлийн гэмт үйлдлийг хохирол багатайгаар таслан зогсоох үндэс болно. Баривчлах ажиллагааны явцад гарч болзошгүй хохирлыг тооцон түргэн тусламжийг байнга дуудаж байх ёстой. Өнөөгийн практикт эмнэлгийн байгууллагын төсөв мөнгө, шатахуун тосны хүрэлцээгүйгээс болоод тэр болгон гэмт хэргийн дуудлаганд түргэн тусламж ирэх боломж хомс байдаг хэдий ч иргэдийн эрүүл мэнд амь насыг цаг алдалгүй аврахын тулд цагдаа, эмнэлгийн байгууллага хэргийн газарт шуурхай очиж хамтарч ажиллах шаардлагатай.



ЖАГСААЛ ЦУГЛААНЫ ҮЕД ХҮЧ ХЭРЭГЛЭХ ТУХАЙ

Цагдаагийн байгууллагын олон нийтийг хамарсан спорт, урлаг, уран сайхны тоглолт, баяр наадам, жагсаал цуглааны үед явуулах үйл ажиллагааны чиглэл нь:

- Олон нийтийг хамарсан арга хэмжээ хэвийн явагдах нөхцлийг хангаж хэв журмыг хамгаалах;
- Олон нийтийн аюулгүй байдлыг хангах;
- Гэмт хэрэг, хэв журмын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох;
- Оролцогч талуудаас хууль тогтоомж зөрчихгүй байхыг сануулж, ухуулан таниулах;
- Олон нийтийг хамарсан арга хэмжээ рүү гол хүчээ чиглүүлж арга хэмжээ явагдаагүй бусад газруудад хэв журам сахиулах ажлаа сулруулахгүй байх;
- Бусад

Цагдаагийн байгууллага нь гудамж талбай, авто тээврийн зорчих хэсэгт жагсаал, цуглаан, олон нийтийн эмх замбараагүй байдал үүссэн үед гэмт хэрэг, хэв журмын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийн аюулгүй байдал, эрх, эрх чөлөөг ханган ажиллах, зохион байгуулах үүрэгтэй.

Монгол улс, 1990 оны ардчилсан хувьсгалаас хойшхи хугацаанд хүний эрх, эрх чөлөөг хангах талаар олон улсын хэмжээнд нэр хүнд өсч байна.

Гэвч, иргэдийн тайван замаар жагсаал цуглаан хийх эрхийг ашиглан зөвшөөрөгдсөн газарт, хуулийн дагуу

явуулахгүй хууль зөрчих, улс төр хийх, бусдыг хууль бус халдлагад өдөөн турхирах, бусдын болон төрийн тангараг өргөсөн алба хаагчдын эрх чөлөөнд халдах, бусдын болон нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг эвдэн гэмтээх, устгах, шатаах, иргэдийн нэр төр, алдар хүнд, эрх чөлөөнд бүдүүлгээр, хууль бусаар халдах, олон нийтийн зорчих хэсгийг хаах, төрийн тусгай хамгаалалтын бүсэд дур зоргоор нэвтэрч танхайрах зэрэг нийгмийн гажууд үзэгдэл гарсаар байна. Олон улсын зарчимд заахдаа :

“Хууль бус боловч аливаа хүч хэрэглээгүй жагсаал цуглааныг тараахдаа хэв журам сахиулах албан тушаалтан хүч хэрэглэхээс аль болохоор зайлсхийх ба хэрэв хүч хэрэглэх нөхцөл бүрэлдвэл, хамгийн наад захын гарцаагүй байдлыг хүртэл хязгаарлах хэрэгтэй”¹ гэж заажээ.

Хууль бус жагсаал цуглааныг тайван замаар, хохирол багатай зохицуулан тараах нь цагдаагийн удирдлагын нэн тэргүүнд тавих зорилго байдаг.

Нийтийг хамарсан эмх замбараагүй хууль бус жагсаал цуглааны үед цагдаа, дотоодын цэргийн алба хаагчид хуулийн дагуу хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлаа аль болох хангаж ажиллах шаардлагатай.

Нэг бүрийн болон, олон хүнд зэрэг нөлөөлөх тусгай хэрэгсэл болон (олон хүнд нэг зэрэг нөлөөлөх нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч; усан хөөрөг; утаан хөшиг үүсгэгч) хамгаалах хэрэгслээр бүрэн хангагдсан байх ёстойгоос гадна хуулийн дагуу хамгаалах тусгай хэрэгслээ хэрэглэх ёстой.

¹Хүний эрх- шүүх эрх мэдлийн салбар дах хүний эрх 1996 он 96-р нүүр 13-р зүйл

Үүнд бууны сум, мод чулуу гэх мэт зүйлээс хамгаалсан бамбай, дуулга, хантааз, бээлий орно. Хамгаалах хэрэгслээ бүрэн хэрэглэн, хэд хэдэн эгнээгээр гинжин хамгаалалт зохион байгуулсан үед жагсаал цуглааныг өдөөн хатгаж, турхирагч, хэв журам зөрчигчид тэр болгон хамгаалалтай бүс рүү дайрч эд хөрөнгө эвдэж, бусдын эрх чөлөөнд халдахгүй байх магадлал өндөр юм.

“Нийтийг хамарсан эмх замбараагүй арга хэмжээ гэдэг нь, олон тооны иргэдийг оролцуулсан, тэдний хэрэгцээ ашиг сонирхолыг хангахад чиглэгдсэн нийгмийн харилцаан дахь бие хүн, бүлэг хамт олныг эрх, эрх чөлөөгөө хэрэгжүүлж буй зохион байгуулалттай үйл ажиллагааны нийлбэр цогц юм.”²

Олон нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, жагсаал цуглаанд оролцогчдыг дараах байдлаар ангилж үзнэ.

§ Зохион байгуулагч

§ Оролцогч

§ Сонирхогч

§ Хэв журам зөрчигч

§ Хэв журам сахиулагч

§ Хариуцагч (ихэнхдээ төр, төрийн албан тушаалтан байдаг)

§ Бусад

Олон нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, жагсаал цуглаанд оролцогчдын үйл ажиллагааг агуулгаар нь:

§ Олон улсын хэмжээний

§ Улс орны хэмжээний

²Цагдаагийн ажилтны гарын авлага 2005 он . 126-дахь нүүр

§ Улс төрийн шинжтэй

§ Эдийн засгийн шинжтэй

§ Тухайн орон нутгийн (аймаг, дүүрэг, сумын)

§ Тухайн байгууллагын

§ Бусад

Олон нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, жагсаал цуглаанд оролцогчдын үйл ажиллагааг үргэлжлэх хугацаагаар нь:

§ Нэг удаагийн

§ өдөр тутмын

§ үргэлжилсэн

Олон нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, жагсаал цуглааны үед цагдаагийн удирдлагын байгуулбал зохих бүлгүүдэд:

§ Шуурхай удирдлагын;

§ Холбооны;

§ Шуурхай хяналтын;

§ Техник хэрэгслээр баримтжуулах;

§ Таслан хязгаарлах;

§ Эргүүлийн;

§ Суртал ухуулгын;

§ Хамгаалах;

§ Хуяглан хүргэх бүлэг

§ Тараах бүлэг

§ Татан гаргах;

§ Магадлах;

§ Автотехникийн зохицуулах;

§ Эмнэлгийн;

§ Нөөцийн;

§ Бусад гм.

Цагдаагийн байгууллагын алба хаагчид нь удирдлагаас заасан хугацаанд бэлэн байдалд орж цугларах бөгөөд цуглах дохионы онцлогоос, зэвсэг хэрэгслийг бэлэн болгоно. Техник, технологи, харилцаа холбоо хөгжсөн өнөө үед гэмт хэрэгтэн маш богино хугацаанд оргон зайлж, эргүүл хэв журмын нөхцөл байдал өөрчлөгдөж байна. Төв, орон нутгийн цагдаагийн алба хаагчдын бэлэн байдлын дохиогоор цугларч байгаа өнөөгийн практикийг өөрчилж боловсронгуй болгох шаардлагатай.

Цагдаагийн алба хаагч нь олон нийтийг хамарсан үймээн самууны үед тухайн асуудлыг хурцатгахгүйгээр аль болох ухаалаг, шуурхай, тайван аргаар таслан зогсоох арга хэмжээ авна. Олон нийтийн дунд ажиллаж байгаа цагдаагийн ажилтан нь аливаа хурцадмал зүйлд хувийн үзэл бодлоор хандаж болохгүй бөгөөд хуулийн дагуу хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн уян хатан ажиллах шаардлагатай байдаг. Аливаа жагсаал цуглааны үед аль нэг талыг дэмжих, эсэргүүцэх зэрэг цагдаагийн алба хаагчийн ёс зүйд нийцэхгүй үйлдэл хийхгүй байх ёстой.

Олон нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, жагсаал цуглааны талаарх зарим баримт дурдвал:

1954 онд, одоогийн Улсын их дэлгүүрийн хойд талд хятад монгол иргэдийн хооронд зодоон болж, тухайн үеийн цагдаагийн хүчээр дийлэхгүйд хүрч Хятад улсын элчин сайд нь өөрөө ирж уг зодооныг тарааж байжээ. Өнөөдөр монгол улсад олон тооны хятад иргэд суурьшин ажиллаж амьдарч байна. Үйлчилгээ, барилга, үйлдвэрлэлийн салбаруудад зөвшөөрөлтэй болон зөвшөөрөлгүй оршин сууж ажиллаж амьдрах БНХАУ-ын иргэдийн эзлэх хувь ихэссэнтэй холбогдон монгол хятад

иргэдийн хооронд их бага хэмжээний зөрчил удаа дараа гарч байна. Иймэрхүү асуудлуудыг тухайн цаг үед нь хуулийн дагуу түргэн шуурхай шийдэж байх ёстой.

Мөн 1982 онд, ОХУ-ын Элчин сайдын яамны арын замд цэргийн комендант, цэрэг хоёрын хооронд болсон маргаанаас, ойр орчинд байсан ард иргэд хоёр хуваагдан тал болон зодолдож, ихээхэн дуулиан гарч байжээ.

Баримт

2002 онд, Сүхбаатарын талбайд болсон тракторчдын цуглааны үеэр, төв замаас дуурийн театр руу хойш эргэх уулзвар дээр ирсэн Нийслэлийн Цагдаагийн газрын даргын машин доогуур хүн орж хэвтчихээд гарахгүй байсан тохиолдол гарчээ.

Алдаа:

§ Автомашины зорчих хэсэг дээр, хамгаалалтанд гарч байсан замын цагдаа хайнга ажилласан

§ Тусгай хамгаалалтанд авсан бүсэд иргэдийн зорчих хөдөлгөөнийг хэв журмын цагдаа хянаж чадаагүй

§ Жагсаал цуглааны үер далимдуулан танхайрч байсан согтуу иргэдийг салгаж аваагүйгээс уг зөрчил үүссэн

Анхаарах зүйл :

Аливаа жагсаал цуглааны үед жагсагчдаас гадна зориуд хэв журмын зөрчил гарган танхайрагчид, өдөөн хатгагчдыг цагдаагийн байгууллага нь хяналтандаа авч, баримтжуулан, тусгаарлах арга хэмжээг авч ажиллах ёстой.

Цагдаагийн байгууллага нь олон нийтийг хамарсан спорт, урлаг, уран сайхны тоглолт, баяр наадам, жагсаал цуглаан хэзээ хаана, ямар журмаар явагдах гэж байгааг урьдчилан судалсан, холбогдох байгууллага хүмүүсээс мэдээлэл авч, хүн хүчээ тооцож зохицуулахаас гадна уг арга хэмжээг зохион байгуулагч талтай хэв журам сахиулах талаар хамтран ажиллана.

Баримт

Төв цэнгэлдэх хүрээлэнд 1994 онд далай лам ном унших үеэр ирсэн хүмүүс хаалгаар орох гэж чихцэлдсэнээс болж эмх замбараагүй байдал үүссэнээс үзвэр үзэхээр ирсэн хүн газарт унан, олон хүнд гишгүүлэн гэмтэл авчээ.

Алдаа:

§ цагдаагийн байгууллага хамгаалалтын байгууллагатай уялдаа холбоо муутай ажилласан

§ олон хүн хаалга руу дайрч эмх замбараагүй байдал үүсч болзошгүй байдлыг урьдчилан тооцож хангалттай хүчээр зохион байгуулалттай ажиллаж чадаагүй

§ зарим цагдаа нь байрлавал зохих байран дээрээ байгаагүй, дотогшоо орсон

Анхаарах зүйл:

Цагдаагийн байгууллагын алба хаагчид нь олон хүн цугларсан, үзвэр үйлчилгээний газар ажиллахдаа гэмт хэрэг гарах, эмх замбараагүй байдал үүсэх, үүний улмаас болж бусдад ямар нэг хохирол учрахаас сэргийлэн ажиллах, үүрэгтэй бөгөөд цагдаагийн ажилтан нь хаалган дээр билет таслах, үзэгчид дунд чихцэлдэн орж үзэх зэрэг зохисгүй үйлдэлд оролцох ёсгүй. Ялангуяа өрсөлдөгч талуудыг дэмжигчид хоорондоо зөрчилдөх, тэнд согтууруулах ундааны зүйл авч орох, хэрэглэхээс урьдчилан сэргийлж ажиллана. Улам бүр даяарчлагдаж байгаа өнөө үед аливаа олон хүн цугласан газар алан хядах үйл ажиллагаа, бусдыг бөөнөөр нь барьцаанд авах үйл ажиллагаанаас сэрэмжлэн орж байгаа хүмүүсийн эд зүйл, техник хэрэгслийг нарийн хянаж, шалгаж байх шаардлагатай. Олон улсын жишгээр бол олон улсын шинжтэй хурал цуглаан, урлаг спортын тоглолтонд оролцох, үзэх, ажиллах хүн нэг бүрийн авч орох зүйл болон биед үзлэг хийдэг. Мөн овор ихтэй зүйл, шилэн савтай буюу хатуу савтай эд зүйл, эдлэлийг огт оруулдаггүй байна.

Баримт

1994 онд Сүхбаатарын талбайд болсон улс төрийн шинжтэй жагсаалын үед 0801-р хорооны цагдаа ахлагч Н, жагсаал хувцастай архи үнэртүүлэн ирж, жагсаж буй хүмүүсийг өөрийн дураар тараах гэж загнаж байв.

Алдаа:

§ Жагсаал цуглаан хийж байх үед дарга захирагч нарын тушаал шийдвэргүйгээр бие даан буруу үйлдэл хийсэн

§ Амарч байсан үеэрээ ажилд дуудагдсан шалтгаанаа тайлбарлаж, үүрэг гүйцэтгэхээс татгалзах байсан

§ Дүрэмт хувцастай согтуу явсан

§ Жагсагчдыг тараах гэж ганцаараа оролдсон буруу үйлдлээс болж байдлыг хурцатгах байдалд хүрсэн

§ Ажлаа хийж байсан алба хаагчид болон жагсагчдын хооронд зөрчил үүсгэж болох ноцтой алдаа

Анхаарах зүйл:

Цагдаагийн алба хаагч нь хэзээ ч дуудагдаж магадгүй ажил мэргэжлийн онцлогтой тул амралтын цагаараа согтууруулах ундааны зүйл хэтрүүлэн хэрэглэхгүй байх ёстой юм. Түргэн цугларалтаар цугласан алба хаагчдыг ажилд гаргахын өмнө захирах дарга нь, албан үүрэг гүйцэтгэх бэлэн байдал, эрүүл мэнд зэргийг шалгаж байвал зохино.



ХУУЛЬ БУСААР ХҮЧ ХЭРЭГЛЭСЭН ТОХИОЛДОЛД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Цагдаагийн байгууллагын алба хаагчийн тусгай хэрэгсэл хэрэглэх, хүч хэрэглэх, галт зэвсэг хэрэглэх давуу эрхээ урвуулан ашиглаж дээрх байдлаар хууль бус хүч хэрэглэсэн тохиолдол бүрийг мөрдөн шалгаж, олон нийтэд тайлагнаж байхыг олон улсын хэд хэдэн хууль тогтоомжинд тусгасан байдаг. Тухайлбал *Эрүүдэн шүүх, хэрцгий хүнлэг бусаар хүний нэр төрийг харьцаж шийтгэхийг хориглох тухай конвенцэд* “Эрүүдэн шүүх гэж төрийн албан тушаалтан буюу албан үүрэг гүйцэтгэж буй этгээд өөрөө эсхүл, түүний өдөөн хатгасанаар буюу ил далд зөвшөөрлөөр хэн нэгэн этгээдийг өөрөөс нь буюу гурав дахь этгээдээс мэдээлэл авах, хэрэг хүлээлгэх, үйлдсэн гэж сэжиглэгдэж буй хэрэгт нь шийтгэх, айлган сүрдүүлэх аливаа үндэслэлээр ялгаварлан гадуурхах шалтгаанаар бие махбод, сэтгэл санааны хувьд санаатайгаар хүчтэй өвтгөх, шаналгах аливаа үйлдлийг ойлгоно. Энэхүү тодорхойлолтод хуулин дагуух цээрлэл буюу тохиолдлоор үйлдсэн өвдөлт шаналгаа хамаарахгүй”, мөн “эрүүдэн шүүх бүх үйлдлийг гэмт хэрэг гэж үзэн зохих шийтгэл оноох бөгөөд чингэхдээ энэ нь онц аюултай гэмт хэрэг гэдгийг харгалзан үзнэ” гэж заасан байдаг. Дээр дурдсан алдаанууд нь хэдийгээр эрүү шүүлтийн хэлбэрт хамаарагдахгүй боловч, зүй бусаар, хэрцгий харьцах, хүний нэр төрийг доромжлон гутааж, харьцаж, хуулиас гадуур шийтгэж буйн нэг хэлбэр болох тул өөрийн үйл ажиллагаандаа туйлын хянамгай байж,

ХУУЛЬ БУСААР ХҮЧ ХЭРЭГЛЭСЭН ТОХИОЛДОЛД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА
мэргэжлийн өндөр түвшинд ажиллах ёстойг цагдаагийн
алба хаагчаас шаардаж байгаа юм.

Цагдаагийн байгууллагын алба хаагчдаас гэмт хэрэгтэй
тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах үедээ эрхээ
хэтрүүлэх, нөхцөл байдлыг буруу дүгнэх болон
харьцааны доголдолтой байдал гаргах, бусдад хүч
хэтрүүлэн хэрэглэх тохиолдол гарсаар байна. Цагдаагийн
алба хаагч албан үүрэг гүйцэтгэж байх үедээ бусдын эрүүл
мэндэд өөрийн буруутай үйл ажиллагаанаас болж хөнгөн
буюу хүнд гэмтэл учруулбал уг этгээдийн эрүүл мэндийг
хамгаалах зорилгоор эмнэлгийн яаралтай тусламжийг
нэн даруй үзүүлэх үүрэгтэй.

Уг үйлдэлд нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй
бол Захиргааны хариуцлагын тухай хууль болон
Цагдаагийн байгууллагын хуулийн дагуу хариуцлага
хүлээлгэдэг.

Цагдаагийн байгууллагын алба хаагч та, олон нийтийн
дунд ажиллахдаа хэдийгээр хууль сахиулан ажиллаж
байгаа ч гэсэн маш уян хатан байж, гэмт этгээдэд
чиглэсэн харьцаагаа туйлбартай явуулах ёстой. Гэхдээ
олон нийтийн дунд харьцааны алдаа гаргахгүйгээр
хүлээцтэй байж, ёс зүйтэй харьцах, үүрэгтэй бөгөөд аль
болох олон нийтийг өөртөө татахыг эрмэлзэж, тэдэнтэй
хамтран хэв журам зөрчигч болон гэмт этгээдийн эсрэг
байр суурийг бий болгон ажиллахгүй бол та үүргээ
гүйцэтгэж, зорилгоо биелүүлэхэд хэцүү болно.

Иргэдээс дэмжлэг аваагүй нөхцөлд олон хүн таны
эсрэг болж, та биеэ хянах чадвараа алдаж, улам олон
алдаа гаргаж эвгүй байдалд орохоос гадна, та өөрөө
буруутан болж ч болзошгүй.



ХУУЛЬ БУСААР ХҮЧ ХЭРЭГЛЭСЭН ТОХИОЛДОЛД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Иймд та албан үүргээ гүйцэтгэж явах үедээ санаатай болон санамсар болгоомжгүйгээр бусдын эрх, эрх чөлөө, амь бие, эрүүл мэнд, нэр төрд хууль бусаар хүч хэрэглэн халдвал наад зах нь цагдаагийн байгууллагын тухай хуулинд заагдсан:

§ сануулах;

§ сарын үндсэн цалингаа гурван сар хүртэл 20 хүртэл хувиар хасуулах;

§ албан тушаал буурах;

§ цагдаагийн цол буурах;

§ цолны нэмэгдлийг хасуулах;

§ удаан жилийн нэмэгдлийг хасуулах;

§ ажлаас халагдах;

гэх мэт шийтгэл хариуцлага хүлээнэ.

Харин та, Монгол Улсын Захиргааны хариуцлагын тухай хууль болон Эрүүгийн хууль зөрчсөн бол, таны уг гэмт үйлдлийг эрх бүхий байгууллага шалган хуулийн хариуцлага хүлээлгэнэ.

Баримт

Эргүүл хамгаалалтын 0801-р хорооны ажилтан Б нь шөнийн цэнгээний газарт дүрэмт хувцастай согтуугаар, хүн зодсоноос ажлаасаа халагджээ.

Алдаа:

§ Цагдаагийн байгууллагын алба хаагч нь дүрэмт хувцастайгаар баар цэнгээний газарт орж, согтууруулах ундаа ууж, үйлчлүүлэх ёсгүй.

§ Зөвхөн шаардлагатай үед ард иргэд, өөрийгөө хамгаалахад хэрэглэх самбо каратэгийн мэхийг согтуугаар бусдад хэрэглэсэн

ХУУЛЬ БУСААР ХҮЧ ХЭРЭГЛЭСЭН ТОХИОЛДОЛД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

§ Цагдаагийн байгууллага олон сайн ажилтан алба хаагчдын нэр хүндийг гутаан унагана гэдгээ санаж яваагүйгээс ёс зүйн онцгой зөрчил гаргасан

Анхаарах зүйл:

Цагдаагийн байгууллагын алба хаагч нь аливаа баяр ёслол тэмдэглэн согтууруулах ундааны зүйл хэрэглэх үедээ, дүрэмт хувцас өмсөөгүй байх ёстой бөгөөд ямар нэгэн хэмжээгээр хэрэглэсэн үедээ албаны яриа ярих, хэв журам сахиулах гэж оролддог явдлыг бүрмөсөн зогсоох хэрэгтэй юм. Байлдааны самбо каратэгийн зэвсэггүй тулалдах мэхийг энгийн иргэдэд хэрэглэж хэрхэвч болохгүй.

Төмөр бороохойтой гар чийдэнг зөвхөн гэрэлтүүлэх буюу хамгаалах зорилгоор ашиглана.

Баримт

“Нарантуул зах”-ын гэрээт цагдаагийн үүрэг гүйцэтгэж байсан цагдаа М нь бусдын хураагдсан эд зүйлийг хувьдаа ашигласан учир ажлаасаа халагджээ.

Алдаа:

§ цагдаагийн байгууллагын ажилтан өөрийн эрх мэдлийн хүрээнд аливаа гэмт хэргийн нотлох баримт болох эд зүйлсийг хувийн зорилгоор ашиглах;

§ хориотой, хууль бусаар олсон эд зүйлийг хураан авч ашиглахыг хориглосон байдаг

§ цагдаагийн байгууллагын алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээ дутагдаж, тэнд төлөвшөөгүй, хувийн сонирхолтой алба хаагчийг ажиллуулсан.



Анхаарах зүйл:

Цагдаагийн байгууллагын алба хаагч нь бэлэн мөнгө, биет эд зүйлийг шаардлагатай тохиолдолд хурааж авахдаа 2 буюу түүнээс дээш гэрчийг байлцуулан тэмдэглэл хөтлөж гэрч хохирогч, холбогдогчоор гарын үсэг зуруулан, хурааж авсан эд зүйлийг холбогдох албан тушаалтан, байгууллагад шилжүүлдэг. Хурааж авсан мөнгө болон эд зүйл нь хууль бус аргаар олсон нь тогтоогдвол улсын орлого болгохоор шилжүүлэх, хураагдсан эд зүйлийн жинхэнэ эзэн тогтоогдон нотлогдвол эргүүлэн өгнө.

Баримт

Цагдаагийн байгууллагын ажилтан Э нь алтны уурхайгаас хулгай хийсэн хүнийг 24 цаг саатуулсны учир захиргааны арга хэмжээ авагджээ.

Алдаа:

§ Цагдаагийн байгууллагын ажилтан нь, хэн нэгнийг гэмт хэрэг үйлдсэнийг тогтоогдоогүй үедээ 6 цаг хүртэл саатуулан шалгах эрхтэй.

§ Энэ хугацаанд үйлдлийг тогтоох, эсвэл тавьж явуулах ёстой.

Анхаарах зүйл :

Орон нутагт цагдаагийн байгууллагын ажилтан нь сэжигтэнг түр саатуулан гэмт үйлдлийг тогтооход 6 цаг нь хангалтгүй хугацаа, гэвч хууль ийм юм. Гэхдээ гэмт хэргийн тухай мэдээллийг авсан бол 1-үйлдэл дээр нь барих;

2-нотлох баримтыг цуглуулах;
3-хоширогчийг тогтоох;
4-сэжигтэнг оргон зайлахыг таслан зогсоох зэрэг арга хэмжээ авч зохих ажиллагааг хийсний дараа дээрх хугацаанаас илүү хугацаагаар хуулийн хүрээнд саатуулан шалгадаг.

Цагдаагийн алба хаагчдын өдөр тутмын практик үйл ажиллагаанд гарсаар байгаа зарим алдаа дутагдал, баримтыг дурдлаа. Сайн дураараа тангараг өргөн ард түмэнд үйлчилж байгаа цагдаа нь тухайн ажилдаа нягт нямбай найдвартай ажиллах үүрэгтэй.

ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧ ХУУЛЬ БУС ХҮЧ ХЭРЭГЛЭХ ТОХИОЛДОЛ

- СОГТУУГААР**
- ТАНХАЙРЧ**
- АЙСАНДАА**
- ХОМРОГЛОЖ**
- ХАЛДЛАГА ӨНГӨРСӨН ҮЕД**
- ХЭН НЭГЭНД ХУУЛЬ БУСААР ҮЙЛЧИЛЖ**
- ӨС ХОНЗОН АВАХ ЗОРИЛГООР**
- ХУВИЙН ЗОРИЛГООР**
- ЦЭЭРЛҮҮЛЖ**



ГАЛТ ЗЭВСЭГ, ТУСГАЙ ХЭРЭГСЭЛ ХЭРЭГЛЭХ ЁС ЗҮЙ

Цагдаагийн байгууллагын ажилтан нь галт зэвсэг болон тусгай хэрэгслийг хэрэглэхдээ хуульд заасан үндэслэл журмын дагуу хэргэлэнэ. Галт зэвсэг, тусгай хэрэгслийг хэрэглэх нь Үндсэн хуульд заасан хүний амьд явах, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг зөрчөөд зогсохгүй цаашлаад нийгмийн аюулгүй байдалд саад учруулна гэдгийг ямагт санах хэрэгтэй. Иймээс нийгмийн хэв журам сахиулах үүрэг бүхий албан тушаалтан хүч, галт зэвсэг хэрэглэх зайлшгүй шаардлагад хүрэхийн өмнө хүч хэрэглэхгүй зохицуулах боломжтой бүх арга хэрэгслийг ашиглаж үүргээ гүйцэтгэнэ. Цагдаагийн ажилтан нь бусад төрлийн арга хэрэгсэл хэрэглээд тодорхой үр дүнд хүрээгүй ашиггүй болсон буюу үр дүнд хүрэх найдлагагүй болсон нөхцөлд л хүч, галт зэвсгийг хэрэглэж болно.

Цагдаагийн ажилтан нь галт зэвсэг, тусгай хэрэгслийг зайлшгүй хэрэглэх болсон тохиолдол бүрт:

А) Зөрчлийн хүнд, хөнгөн, гарч болох үр дагаварыг нарийн тооцож хүлээцтэй хандах,

Б) Аль болох бага хохирол, шарх үүсгэх үүднээс хандаж хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалах,

В) Шархадсан буюу бусад байдлаар хохирсон хэнд ч гэсэн аль болох богино хугацаанд эмнэлгийн болон бусад тусламж үзүүлэх боломжоор хангах,

Г) Шархадсан буюу бусад байдлаар хохирсон этгээдийн эцэг, эх, төрөл төрөгсөд, ойр дотны найз нөхдөд нь богино хугацаанд мэдээлэх боломжоор хангах эсхүл

ГАЛТ ЗЭВСЭГ, ТУСГАЙ ХЭРЭГСЭЛ ХЭРЭГЛЭХ ЁС ЗҮЙ
өөрсдөө мэдэгдэх үүргийг өөрийн үйл ажиллагаандаа
нарийн чанд баримтлан ажиллах нь зүйтэй.

Цагдаагийн байгууллагын ажилтан нь галт зэвсэг болон тусгай хэрэгсэл хэрэглэхдээ цагдаагийн байгууллагын тухай хуулийн 29.5-д болон цагдаагийн ёс зүйн дүрмийн 2.7-д зааснаар хүнлэг бус харьцах, эрх чөлөө, эд хөрөнгөд хууль бусаар халдахыг хориглоно гэснийг чандлан сахиж ажиллах хэрэгтэй.

Цагдаагийн байгууллагын тухай хуульд галт зэвсэг болон тусгай хэрэгсэл хэрэглэх нөхцөл байдлуудыг тодорхой заасан байдаг ч гэсэн хуулинд заасан тохиолдол бүрт уг хэрэгслүүдийг хэрэглэх нь төдийлөн зохимжтой бус. Гэмт хэрэг, гэмт халдлагыг хүн л хийдэг. Иймд аль болох тухайн зөрчил гаргасан этгээдтэй ярилцах, ятгах, сануулах арга замыг сонгож ажиллах нь зүйтэй.

Цагдаагийн ажилтнаас олон нийттэй харилцахдаа бусдыг захиргаадах үүднээс хүнлэг бус, эрх чөлөө, эд хөрөнгөнд нь хууль бусаар хандах нь элбэг байдаг. Иймээс цагдаагийн ажилтан нь өөрийгөө төрийн нэрийн өмнөөс нийгмийн хэв журмыг сахиулах, иргэдэд үйлчлэх зорилготой төрийн тусгай албан хаагч гэдгээ байнга санаж ажиллах нь зүйтэй. Нийгэмд янз янзын хэрэг маргаан, зөрчил гардаг учраас тухай бүрт тохирсон үйл ажиллагааг явуулна.

Нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэхдээ бусдын амь насыг хөнөөх чадалгүй, тухайн үүссэн нөхцөл байдалд

ГАЛТ ЗЭВСЭГ, ТУСГАЙ ХЭРЭГСЭЛ ХЭРЭГЛЭХ ӨС ЗҮЙ

тохирох зэвсэг хэрэгслийг зөв сонгож хэрэглэх нь зүйтэй. Бусдын амь нас хөнөөх хүчин чадалгүй бусад төрлийн зэр зэвсэг хэрэглэх нь тухайн этгээдийн амьд явах, эрүүл аюулгүй байх эрхийн үндэс бөгөөд мөн орчин тойрны хүмүүсийн энх амгалан байдлыг хангах нэг үндэс юм.

Тусгай хэрэгсэл хэрэглэх шаардлага гарсан тохиолдолд тухайн этгээдийг доромжлох, толгой болон амин газар нь цохиж гэмтэл учруулахгүй байх үүднээс хандах.

Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэхдээ хүн бүр тайван жагсаал цуглаанд оролцох эрхтэй гэсэн хүний эрхийн түгээмэл тунхаглал, иргэний болон улс төрийн эрхийн тухай Олон улсын пакт мөн Монгол улсын Үндсэн хуулийн заалтыг баримтлан ажиллах хэрэгтэй. Хууль бус боловч аливаа хүч хэрэглээгүй жагсаал цуглааныг тараахдаа хэв журам сахиулах албан тушаалтан хүч хэрэглэхээс аль болохоор зайлсхийх ба хэрэв хүч хэрэглэх нөхцөл бүрдвэл хамгийн наад талын гарцаагүй байдлыг хүртэл хязгаарлах хэрэгтэй. Хүч хэрэглэсэн шинж бүхий жагсаал цуглааныг тараахдаа галт зэвсгийг зөвхөн аюул багатай бусад хэрэгсэл хэрэглэх боломжгүй болсон тохиолдолд хэрэглэнэ.

Тээврийн хэрэгсэл албадан зогсоох тусгай хэрэгслийг хэрэглэхдээ тээврийн хэрэгсэл албадан зогсох орчин тойрны аюулгүй байдал болон тухайн тээврийн хэрэгсэл доторх хүний амь нас, эрүүл мэндийг бодолцож уг зогсоох хэрэгслийг байрлуулна. Тээврийн хэрэгсэл хурдтай явж байгаад эхлээд нэг дугуй нь хагарсны

Галт зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэх ёс зүй улмаас нисэх, онхолдох аюул их байдаг. Иймээс дугуйнууд зэрэг хагарах нөхцөл байдлаар үйл ажиллагааг явуулах хэрэгтэй байдаг. Албадан зогсоох тээврийн хэрэгслийг орчин тойрон болон бусдын амь, нас, эрүүл мэндэд хохирол учруулах аюулаас зайлуулах мөн гэмт этгээдийг аюулгүй болгоход үйл ажиллагаа зориулна. Аливаа нэг хүч хэрэглэхдээ бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, эд баялагыг аль болох хохироохгүйгээр үүргээ гүйцэтгэж байх нь цагдаагийн албан хаагчийн ёс зүйн түвшний илэрхийлэл болох ёстой.



АЛБАНЫ БЭЛТГЭЛ

Галт зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэх тохиолдол бүрт хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой асуудал даган явдаг учир цагдаагийн байгууллагын ажилтаны хүч хэрэглэх тохиолдол бүр нь хуулийн дагуу байх зайлшгүй шаардлагатай. Та галт зэвсэг гэдэгт бүх төрлийн байлдааны урт богино бууг оруулан ойлгох учиртай. Ямарч тохиолдолд бүх төрлийн бууг мэргэжлийн төвшинд хэрэглэх явдал нь цагдаагийн ажилтан таны өөрийн болон бусдын амь нас эрүүл мэндтэй салшгүй холбоотой зүйл юм. Мөн бүх төрлийн бие хамгаалах урлагийн талаар мэдлэгтэй байхаас гадна аль нэг бие хамгаалах урлагаар өндөр төвшинд бэлтгэгдээгүй бол өөрийгөө болон бусдыг гэмт халдлагаас хамгаалах хууль сахиулах боломж зуун хувь бүрдэхгүй. Ажил ихтэй байсан ч сард 2-3 удаа галын бэлтгэл хийж байх, сард 5-10 удаа албаны спортоор, эсвэл аль нэг спортоор заавал хичээллэж дадлага чадвараа дээшлүүлж байх шаардлагатай.

Хэрэв бэлтгэлгүй явж байгаад гэмт этгээдтэй барьцалдаж авах, хөөж барих, ноцолдох, хол замд гүйх, өндөрт авирах, бусдыг аврах үед та өөрөө бэртэж гэмтэхээс эхлээд бусдыг аварч чадахгүйд хүрч болзошгүй. Та өөртөө аль болох бие хамгаалах урлаг болон спортоор байнга хичээллэх цагийг өөртөө гаргадаг чадвартай байх хэрэгтэй. Мэргэшсэн цагдаагийн ажилтан байж гэмээнэ ард олонд тусламж үзүүлэх найдвар нэмэгдэж, хүмүүс ч таныг төдийгүй цагдаагийн алба хаагчдыг хүндэтгэж харьцах болно гэдгийг ямагт сана. Цагдаагийн алба хааж ард иргэдтэй харьцана гэдэг бол

маш өндөр соёл, мэдлэг юм. Хэрэв та сайн сэтгэл зүйчийн төвшинд иргэд болон гэмт этгээдтэй харьцаж чадахгүй бол аливаа нэг зөрчлийг улам хурцатгаж эсвэл, тухайн этгээдийн нийгэмд болон бусдад учруулах хохирлыг нэмэгдүүлсэн асуудал ч гарах магадлалтай байдаг. Та мэдээжийн хэрэг, бусдад хууль ёсны шаардлага тавих эрхтэй, үүрэгтэй. Харин та бусдыг жаахан ч гэлээ үл хүндэлбэл таны хэлсэн үг, үйлдэл уг асуудлыг хурцатгана. Цагдаагийн Байгууллагад 35 жил ажиллаж байгаа НЦГ-ын зөвлөлийн гишүүн байсан цагдаагийн ахлах ахлагч Н.Бадарч хэлэхдээ:

“Цагдаа хүн бол ямар ч нийгэм засаглалын үед хувиршгүйгээр зөвхөн л хуулиа мөрдөн биелүүлж ажиллахаас гадна ямар ч ажил мэргэжилтэй, ямар ч боловсролтой аль ч насны хүнтэй тухайн хүний боловсрол соёл, мэдлэгийн төвшингөөс доогуур орохгүйгээр соёлтой зөв ухаалаг харьцах чадвартай байх ёстой” гэж хэлснийг үзвэл, цагдаа нь заавал гэмт хэрэгтэй тэмцэж, нийгмийн муу муухайтай харьцдаг гэсэн шиг уцаарлангуй, дээрэнгүй байдлаар битгий бусадтай харьцаж бай гэсэн утгатайгаас гадна, үг хүнийг алж ч болно, амьдруулж ч болно гэдгийн адил цагдаа хүн бол ямар ч үед гэмт хэрэгтнийг оюун ухаан, хүнлэг чанараараа түрүүлэн эзэмдэж, өөрийн хууль сахиулах зорилгодоо хүрэх хэрэгтэй гэсэн үг билээ. Олон улсын зарчимд энэ тухай заахдаа:

“Хэв журам сахиулах албан тушаалтанг бэлтгэхдээ цагдаагийн ажилтны ёс зүй, мөрдөн байцаалт явуулах үед хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, зөрчлийг аль болох

тайван замаар шийдвэрлэх, олон нийтийн хандлагыг ойлгох, тэдэнд итгүүлэх, хэлцэл хийх, зуучлах, галт зэвсэг хэрэглэхийг хязгаарлахын тулд бусад техник хэрэгсэл хэрэглэх боломж зэрэгт сургахад Засгийн газар, хууль хамгаалах байгууллага онцгой анхаарах хэрэгтэй. Хууль хамгаалах байгууллага сургалтын программ, тодорхой этгээдтэй харьцах шуурхай ажиллагааны журмаа дахин нягтлан авч үзэх ёстой.¹ гэжээ.

Монгол Улсад анхны тусгай тасгийг цагдаагийн байгууллагад 1990 онд байгуулан 15 жил амжилттай удирдсан цагдаагийн хурандаа Ц.Уугангэрэл

“Ямар ч гэмт хэрэг үйлдсэн, тэр дундаа сонсоход хэцүү хэрэг хийсэн хүнийг ч болов баривчлахдаа бага өвтгөж барих, болж өгвөл зэвсэг хэрэглэхгүй баривчлах ажиллагаа явуулж хамтрагч болон өөртөө, гэмт этгээдэд хохирол учруулахгүйгээр баривчлах нь мэргэжлийн ур чадвар юм” гэж хэлсэн нь цагдаа болон хүчний байгууллагын ажилтан нь хүч хэрэглэхийг урьтал болголгүй ухаанаа ажиллуулбал илүү үр дүнд хүрч болохыг өгүүлжээ.

“Буунаас айх хэрэггүй зөвхөн бууны арын залгаанаас ай” гэсэн энэ ёгт үг бол бууг хэн яаж, яах гэж, ямар зорилгоор ашиглаж байгаа нь чухал гэдгийг хэлжээ. Ингээд харахад галт зэвсэг тусгай хэрэгслийг хэрэглэх олон нөхцөл байдгийн нэг нь харьцааны ур чадварын асуудал байна.

Хэдийгээр цагдаагийн байгууллага өөрсдийн ажилтангууддаа янз бүрийн сургалт явуулдаг боловч

¹ Хүний эрх- шүүх эрх мэдлийн салбар дахь хүний эрх 1996 он 97-р нүүр 20-р зүйл

зарим сургалтуудыг тогтмол явуулдаггүй, зайлшгүй хэрэгцээтэй сургалтыг цаг тухайд нь явуулж байх сургалтын менежментийн алдаанаас үүдэн цагдаагийн алба хаагчид мэдээгүй эсхүл мэдлэггүйгээсээ болж хүний эрхийг ноцтойгоор зөрчих, байдлыг улам хурцатган үймээн самуунд хүргэх, хүч хэтрүүлэн хэрэглэх тохиолдол цөөнгүй гардаг билээ. Гэвч үүний бурууг дан ганц байгууллага руугаа тохох нь буруу юм. Цагдаагийн байгууллагын ажилтан нь өөрийн хувийн зохион байгуулалтаа өндөр байлгаж, өөрийгөө байнга шинэ мэдлэг, мэдээллээр цэнэглэж, тогтмол сургалтанд хамрагдаж байх хэрэгтэй юм. Тухайлбал олон улсын хүний эрхийн жишиг хэмжээгээр хууль сахиулах байгууллагын ажилтнуудад ёс зан заншилын тухай хичээл орох ёстой байдаг. Гэвч манай аль ч цагдаагийн алба, хэлтсүүд энэ сургалтыг зохион байгуулдаггүй билээ. Тэгвэл зан заншил мэдэхгүйгээс болж цагдаа алба хаагч ямар асуудал үүсгэж болох вэ, энэ нь яагаад хүч ба галт зэвсэг хэрэглэх талаархи бидний сэдэвтэй уялдаж байна вэ гэдгийг доорхи жишээгээр тайлбарлая.

Жишээ

2004 онд Завхан аймгаас 10 дугаар ангийн нэгэн сурагч тэмцээнд оролцохоор хотод ирээд эгчийндээ очсон боловч эгчийнх нь цоожтой байв. Газар мэдэхгүй хүү гадаа нь хүлээн зогсож байтал Баянгол дүүргийн эргүүлийн цагдаа тааралдан байцааж, хаягаа хэлж мэдэхгүй байна, овортой юм авч яваа хэмээн сэжиглэж хэлтэс дээрээ авчиран шалгажээ. Цүнхэн дэх хувцаснууд хиртэй байгааг хараад газарт асган, хөлөөрөө эргүүлж тойруулан шалгасан байна. Ингэхдээ дээлийнх нь захан

дээр гишгэсэнд хүү уурласан аж. Хүүг уурлаж буйг харсан цагдаа юунд уурлав хэмээн өшиглөх үед хүү зайлсхийснээс, уг цагдаа хүүгийн бэлэг эрхтэн рүү өшиглөж таарсан байна. Үүний улмаас хүү бүтэн 2 сарын турш эмчилгээ хийлгэсэн байна.”

Монгол улс маш олон үндэстэн ястнаар баян тул зан заншил, соёлын тухай хичээл, сургалт цагдаагийн алба хаагчдад зайлшгүй шаардлагатай бөгөөд даяаршиж буй өнөө үед янз бүрийн заншил соёлтой гадаадын иргэд Монголд цөөнгүй тоогоор орж ирэн, ажиллаж, амьдарч, аялан явж байгаа тул цагдаагийн алба хаагчид тодорхой хэмжээгээр тэдэнтэй харьцах нь зайлшгүй билээ. Ялангуяа олныг хамарсан жагсаал цуглааны үеэр зан заншил мэдэхгүйгээсээ болж алдаа гаргах, тухайн үндэстэн ястны баярын үеэр илт зан заншилын алдаа гаргаж хорио цээрийг нь эвдвээс олны бухимдалыг төрүүлэх, үймээн самуун гарахад амархан хүргэдэг. Тиймээс тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэдэг алба хаагчдыг төрөл бүрийн сургалтанд хамруулж байх нь тун чухал байдаг.

Цагдаагийн байгууллагын нийт бие бүрэлдэхүүний дунд галт зэвсэг тусгай хэрэгслийн сургалт дутмаг, жилдээ ганц удаа явагддаг цагдаагийн мэргэжлийн зэрэглэлийн шалгалтын үеэр зарим алба хаагч буудлагын дасгал хийж, шалгалтын үеэр 3 ширхэг сум тэнгэрт өргөөд л дараа жилийг хүлээж байдаг нь эдийн засгийн байдалтай холбоотой ч энэ байдлаас гарах гарц байж таарна. Галт зэвсэг тусгай хэрэгслийг хэрэглэх дасгал сургуулилт байнга хийж байж буунаасаа айж, айлгах биш цаг үед нь зөв хэрэглэж сурна.

Галт зэвсэгтэй буруу харьцаж гардаг алдаануудын нэг нь яах аргагүй галт зэвсгийг аюултай гэж сэтгэн,

чадварлаг эзэмших талаар өөрсдийгөө дайчилдаггүй, зэвсэгтэй туйлын бага харьцдаг нь өөрөө аюул юм. Учир нь бага харьцаж хэрэглэх тусам хэрэглээний аюул осол, зөрчил дагаж байдаг.

Хөөсөн хүнээ барьдаг, хайсан хэрэгтнээ олдог байх нь мэргэжлийн ур чадварын чухал үзүүлэлт болно.

Баримт

1996 онд, онц хүнд хэрэг үйлдсэн хүнийг Улаанбаатараас Төв аймаг руу хуяглан хүргээд жижүүрийн байрны радиаторын уурын хоолойноос гавлаад хяналтгүй орхисноос хэрэгтэн өөрийгөө хутгалж амиа егүүтгэжээ.

Алдаа:

§ саатуулж шалгадаг дүрэм, журмаа зөрчсөн

§ сэжигтний биед хийх үзлэгийг дутуу, хайхрамжгүй хийсэн

§ гэмт хэрэгтнийг, жижүүр, төлөөлөгч хоёр хариуцлагагүй хүлээлцсэн

§ хүн гавлаад явсан байхад дүрэм, зааврын дагуу хянаж шалгаж байгаагүй жижүүрийн бүрэлдэхүүний сонор сэрэмжгүй байдал мэргэжлийн алдаа

§ ноцтой гэмт хэрэгтэн бариад түүндээ тайвшран, хяналтаа сулруулсан

Анхаарах зүйл:

Цагдаагийн байгууллагын аль ч шатны алба хаагч өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэндийг хохироохгүйн тулд сэжигтэн яллагдагчийн биед үзлэгийг бүрэн гүйцэд хийж байх ёстой. Онц ноцтой гэмт хэрэг үйлдсэн болон анх удаа гэмт хэрэг үйлдсэн хүмүүс нь сэтгэхүйн хувьд өөрчлөлтөнд ордог учир тэднийг амиа егүүтгэх, оргон зайлахаас байнга сэрэмжлэх ёстой. Гавтай хүнийг 10 минут тутам шалгах ёстой.

Баримт

1997 онд эргүүл хамгаалалтын газрын хэдэн цагдаа улсын цолтой нэр бүхий дөрвөн бөхийг согтууран, хэвийн бус явлаа гэж Баянзүрх дүүргийн цагдаагийн хэлтсийн эрүүлжүүлэх байранд хүргэж өгчээ. Эрүүлжүүлэх байрны эмч, цагдаа нар нийлсэн дөрвөн хүн хувцсыг нь тайлж камерт хийх гээд чадахгүй болохоороо хуурч камерт оруулан түгжсэнд согтуу дөрвөн бөх агсарч, камерын төмөр сараалжийг эвдэн гарч ирээд дөрвөн цагдааг зодохоор дайрах үед тэд зугатан жижүүр дээрээ иртэл, тэнд байсан ахлах нь хамт байсан цагдаа нараа дагуулан хэлтсийн байрнаас гарч мөн зугатаажээ. Тэд гудамжнаас 102-т мэдэгдэж, тусгай тасгийнхан очтол гадаа байцгаажээ.

Алдаа :

§ Гэнэтийн үед ажиллах дадлага туршлагагүй

§ Бүх тусгай хэрэгсэл галт зэвсэг нь сейфэнд нь цоожтой байсан

§ Цагдаа ямар эрх үүрэгтэй билээ гэдгээ тэр үед хоромхон зуур сандарснаас мартаж, цагдаа гэхээсээ хувь хүмүүс болж хувирсан.

§ Албаны тусгай бэлтгэл хангалтгүй.

§ Сэтгэхүйн хувьд сул дорой байсан зэрэг асуудал нь нөлөөлж согтуу бөхчүүдийг зоргоороо аашлахад хүргэсэн.

Зүй нь, олон согтуу хүн дотор нь байгаа ажлын байраа орхих ёсгүй бөгөөд зэвсэггүй тулалдах мэх, тусгай хэрэгслээ дэс дараатай хэрэглэх ёстой байв


Анхаарах зүйл:

Хоногийн туршид хэрэг зөрчлийн мэдээлэл авч дуудлагаар ажилладаг жижүүрийн алба, халуун цэгүүдэд самбо каратэгийн мэхийг сайн эзэмшсэн алба хаагчдыг бодлогын чанартайгаар байршуулж ажиллуулах шаардлагатай. Агсам согтуу тавьсан, танхайрсан үйлдлээ хянах чадваргүй хүмүүстэй ажилладаг жижүүрийн болон эргүүл, эрүүлжүүлэх байрны цагдаагаар бие бялдар, сэтгэл зүй, албаны бэлтгэл сайтай мэргэжлийн цагдааг ажиллуулдаг байх нь зүйтэй.

Баримт

Эмнести Интернэшнл байгууллагын судалгаанаас үзэхэд, Өмнөд Африкт 1994-1997 онд 955 цагдаагийн ажилтан алагджээ. Жилд дундажаар 200 гаруй цагдаа алагддаг байна.

Үүнийг диаграмаар үзүүлбэл:



Дээрхи баримтаас үзэхэд манай цагдаагийн алба хаагчид ч галт зэвсэг, автомашинтай харьцах, гэмт хэргийн газар хоорондоо зөв ойлголцож ажиллах сургалтаа эрчимжүүлэх шаардлагатай юм. Хэдийгээр манай нөхцөлд ийм их хэмжээний хохирол гардаггүй ч гэсэн эрүүгийн нөхцөл байдал хүндэрч байгаа өнөө үед галт зэвсэг, тусгай хэрэгслийг чадварлаг эзэмшиж ашигладаг байх нь өөрийн болон бусдын амь нас эрүүл мэндийг хамгаалах үндэс болно.

Цагдаагийн алба хаагч нь дараахь бэлтгэлийг зайлшгүй хийж дадлагажих шаардлагатай.

Хүний эрх, эрх зүйн талаарх мэдлэг

Харьцааны соёл

Гадаад хэл

Ёс зүй

Самбо, каратэ болон бие хамгаалах бусад төрлүүд мэх эвслүүд

Техник эзэмших мэдлэг, автомашин мотоциклийн жолоодлого

Буудах чадвар, буудлагын зэвсгүүд

Хамгаалах чадвар

Холбоо, цахим холбоо

Эмнэлгийн анхны тусламж

Мал нүдлэх болон таних ялгах

Газар зүйн болон байр зүйн мэдлэг

Ой тогтоолт ба нүдлэх чадвар

Зөрчлийг тайван замаар шийдвэрлэх, хэлцэл хийх, ятгах ур чадвар

Тусгай хэрэгсэл ашиглах чадвар

Дүгнэлт өгөх чадвар

Цагдаагийн байгууллагын үндсэн үйл ажиллагаанд хууль дээдлэх, шударга ёс, тэгш байдлыг хангах, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх зэрэг 4 гол зарчим мөрдөгддөг учир алба хаахтай холбоотой хууль, хуульчилсан актуудыг сайтар мэдэж байх шаардлагатай.

Монгол улсын нутаг дэвсгэр дээр гадаадын иргэд олноор суурьшин ажиллаж амьдарч байна. Мөн аялал жуулчлал хөгжиж байгаа өнөө үед цагдаагийн байгууллагын алба хаагч нь гадаадын иргэдэд туслах, гадаадын иргэдтэй холбогдсон харилцааг зохицуулах, тэдний оролцсон хэв журмын зөрчил, гэмт хэргийг шийдвэрлэхэд дэлхий нийтийн нийтлэг хэл болох англи хэлийг тодорхой хэмжээнд эзэмшсэн байх бас нэгэн, нэн чухал гэмээр шаардлага бий боллоо.

Техник технологи, холбоо харилцаа хөгжсөн өнөө үед шинэ соргог мэдээ мэдээллийг цаг алдалгүй авах буюу дамжуулах, албан үүргээ гүйцэтгэхэд компьютер болон

интернэтийн сүлжээг өргөн цар хүрээгээр ашигладаг байхын зэрэгцээ бусад автомашин, техник, механизмыг чадварлаг эзэмшиж өөрийн ажил үүргээ гүйцэтгэх үедээ ашиглаж чаддаг байх ёстой.

Монгол улсын эдийн засагт мал аж ахуй чухал байр эзэлдэг бөгөөд үүнийг дагаад, малын хулгайн гэмт хэрэг, улсын хэмжээнд үйлдэгддэг гэмт хэргийн зонхилох хувийг эзэлдэг. Үүнийг дагаад энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд цагдаагийн алба хаагч нарт аливаа юмыг нүдлэн тогтоох, малын нас, шүд, зүсийг сайн мэдэж байх чанар, чадварыг эзэмшихэд энэ чиглэлийн мэдрэмжийг хөгжүүлэхэд анхаарах ёстой юм.

Олон нийтийн дунд албан үүрэг гүйцэтгэж явах үедээ өөрийн болон цагдаагийн албаны нэр хүндийг өндөрт өргөж иргэдэд түргэн шуурхай, соёлтой, ёс зүйн өндөр түвшинд үйлчилж чаддаг байх ёстой.



**НИЙГМИЙН ХЭВ ЖУРАМ САХИУЛАХ ҮҮРЭГ БҮХИЙ
АЛБАН ТУШААЛТАН ГАЛТ ЗЭВСЭГ БОЛОН ХҮЧ
ХЭРЭГЛЭХ ҮНДСЭН ЗАРЧМУУД**

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эрх зүйн зөрчил гаргагчидтай харьцах асуудлаархи НҮБ-ын наймдугаар Их хурлаар батлав.

Гавана, Куба,

1990 оны 8-дугаар сарын 27- ноос 9 дүгээр сарын 7.

“ Нийгмийн хэв журам сахиулах үүрэг бүхий албан тушаалтны үйл ажиллагаа нийгмийн чухал ач холбогдолтой учир зохих түвшинд байлгаж шаардлагатай үед эдгээр албан тушаалтны байдал, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах ёстойг харгалзан:

- Нийгмийн хэв журам сахиулах албан тушаалтны амь нас, аюулгүй байдалд заналхийлэх нь бүхэлдээ нийгмийн энх амгалан байдалд заналхийлж байгаа хэмээн үзэх ёстойг харгалзан:

- Нийгмийн хэв журам сахиулах албан тушаалтан Хүний эрхийн түгээмэл тунхаглалаар баталгаажин Иргэний болон улс төрийн эрхийн тухай Олон улсын пактаар батлагдсан хүний амьд явах эрх чөлөө эдлэх, аюулгүй байх хамгаалахад онцгой чухал үүрэг гүйцэтгэдгийг харгалзан:

- Нийгмийн хэв журам сахиулах албан тушаалтны зан үйлийн тухай хуулийн 3 дугаар зүйлд эрх зүйн дэг журам сахиулах албан тушаалтан зөвхөн гарцаагүй байдлын нөхцөлд үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай хэмжээнд хүч хэрэглэж болохыг заасныг харгалзан:

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эрх зүйн зөрчил гаргагчидтай харьцах асуудлаархи Нэгдсэн Үндэстэний Байгууллагын 7-р их хурлыг бэлтгэх талаар Италийн Варенид

мэдвэл зохих гол хуулиуд _____
болсон зөвлөлгөөнөөс эрхзүйн дэг журам сахиулах албан тушаалтнаас галт зэвсэг, хүч хэрэглэхийг хязгаарлах ирээдүйн ажлыг хэлэлцэх явцыг тодорхойлсныг харгалзан:

- 7-дугаар их хурлын 14-р тогтоолд тухайлбал, нийгмийн хэв журам сахиулах албан тушаалтан галт зэвсэг, хүч хэрэглэх хүний эрхийг зохих ёсоор хүндэтгэн үзэх ёстойг тэмдэглэснийг харгалзан:

- НҮБ-ын Эдийн засаг болон Нийгмийн зөвлөл 1986 оны 5-дугаар сарын 21-ний өдрийн 1986/10 дугаар тогтоолын 9-р хэсэгт хуулийг хэрэгжүүлэх хэв журам сахиулах үүрэг бүхий албан тушаалтнаас галт зэвсэг, хүч хэрэглэхэд онцгой анхаарах гишүүн улсуудад зөвлөж Ерөнхий ассамблей 1986 оны 12-р сарын 4-нд 41/149 дүгээр тогтоолоор зөвлөлийн энэхүү зөвлөмжийг сайшаасныг харгалзан:

- Нийгмийн хэв журам сахиулах албан тушаалтны шүүн таслах үйл ажиллагаа явуулахад гүйцэтгэх үүрэг хүний амьд явах эрх, эрх чөлөө, аюулгүй байдал, төрийн аюулгүй байдал, нийгмийн хэв журам хамгаалах зорилго, тэдний мэргэшил, бэлтгэл, үйл ажиллагааны ач холбогдолыг авч үзэж эдгээр албан тушаалтны хувийн аюулгүй байдалд онцгой анхаарах нь чухал тул:

- Засгийн газар өөрийн үндэсний хууль тогтоомжийн болон практик ажлын хүрээнд гишүүн орнуудын хэв журам хамгаалах үүрэг бүхий албан тушаалтнаас зохих үүргээ гүйцэтгэхэд дэмжих зорилгоор боловсруулж гаргасан доорхи Үндсэн зарчмуудыг дагаж мөрдөх, улмаар энэхүү зарчмыг хэв журам сахиулах үүрэг бүхий албан тушаалтан, түүнчлэн шүүгч, прокурор, хуульчид хууль тогтоох болон гүйцэтгэх засаглалын байгууллагын ажилтнууд, улс орныхоо хүн амд бүхэлд нь хүргэх арга хэмжээ авах нь зүйтэй.

- Нийгмийн хэв журам сахиулах үүрэг бүхий албан тушаалтны үйл ажиллагааны тухай хуулийн 1 дүгээр зүйлийн тайлбар ёсоор “Нийгмийн хэв журам сахиулах албан тушаалтанд ялангуяа баривчлах, албадан саатуулах зэрэг Цагдаагийн үүрэг гүйцэтгэж байгаа томилогдсон болон сонгогдсон хуулийн бүх ажилтан хамаарна. Цагдаагийн үүргийг цэргийнхэн болон эсхүл төрийн аюулгүй байдлын хүчин гүйцэтгэдэг улс орнуудын хувьд эдгээр албаны ажилтанг ойлгоно.

Ерөнхий нөхцөл

1. Засгийн газар, хууль хамгаалах байгууллага Нийгмийн хэв журам сахиулах үүрэг бүхий албан тушаалтнаас хүч галт зэвсэг хүний эсрэг хэрэглэх талаар хэм хэмжээ тогтоож хэрэгжүүлнэ. Ийм хэм хэмжээ боловсруулахдаа Засгийн газар, хууль хамгаалах байгууллага хүч галт зэвсэг хэрэглэхтэй холбогдсон ёс зүйн асуудлыг байнга харгалзан үзэж байна.

2. Засгийн газар, хууль хамгаалах байгууллага эрх бүхий албан тушаалтан аль болох ялгамжтай хэргэлэж болох олон төрлийн зэвсэг, хэрэгслийг өргөн хүрээнд боловсруулбал зохино. Түүнд бусдын амь насыг хөнөөх чадалгүй, тухайн үүссэн нөхцөл байдалд тохирох зэвсэг хэрэгслийг оруулахаас гадна бусдын амь насыг хөнөөх буюу шархдуулж болох зэвсэг хэрэгслийг хэрэглэхээс зайлсхийж байх ёстой. Энэ зорилгоор хэв журам сахиулах үүрэг бүхий албан тушаалтанг бамбай, хамгаалалтын малгай, сум нэвтэрдэггүй тээврийн хэрэгсэл зэрэг бусад төрлийн зэвсэг хэрэгсэл хэрэглэх шаардлагыг багасгах боломж нөхцлөөр хангана.

3. Бусдын амь насыг хөнөөх чадалгүй бусад төрлийн зэвсэг хэрэгслийг ашиглах, энэ нь орчин тойрны хүмүүст бага ч болов хохирол учруулах эрсдлийг багасгах, зэвсэг хэрэгсэл хэрэглэхэд хатуу хяналт тавих асуудлыг нарийвчлан авч үзэж боловсруулах.

мэдвэл зохих гол хуулиуд _____

4. Хэв журам сахиулах үүрэг бүхий албан тушаалтан хүч, галт зэвсэг хэрэглэх зайлшгүй шаардлагад хүрэхийн өмнө хүч хэрэглэхгүй зохицуулах боломжтой бүх арга хэрэгслийг ашиглаж үүргээ гүйцэтгэнэ. Тэд зөвхөн бусад төрлийн арга хэрэгсэл хэрэглээд тодорхой үр дүнд хүрээгүй ашиггүй болсон буюу үр дүнд хүрэх ахйдлаггүй болсон нөхцөлд л хүч, галт зэвсэг хэрэглэж болно.

5. Хэв журам сахиулах үүрэг бүхий албан тушаалтан хүч галт зэвсэг зайлшгүй хэрэглэх болсон тохиол бүрт:

а/ зөрчлийн хүнд, хөнгөн, гарч болох үр дагаврыг нарийн тооцож хүлээцтэй хандах,

б/ аль болох бага хор хохирол, шарх үүсгэх үүднээс хандаж хүний амь насыг хамгаалах,

в/ Шархадсан буюу бусад байдлаар хохирсон хэнд чгэсэн аль болох богино хугацаанд эмнэлгийн болон бусад тусламж үзүүлэх боломжоор хангах,

г/ Шархадсан буюу бусад байдлаар хохирсон этгээдийн эцэг, эх, төрөл төрөгсөд, ойр дотны найз нөхдөд богино хугацаанд мэдээлэх боломжоор хангах

6. Хэрэв хэв журам сахиулах үүрэг бүхий албан тушаалтан хүч, галт зэвсэг хэрэглэснээс хүний амь хохирсон буюу шархадсан бол дээд шатны албан тушаалтандаа нэн даруй мэдэгдэнэ.

7. Эрх бүхий албан тушаалтан санаатай буюу хайнга хандаж хүч, галт зэвсэг хэрэглэсэн бол гэмт хэрэг гэж үзэж зохих цээрлэл хүлээлгэх нөхцөлийг засгийн газар хангаж байна.

8. Нийгмийн доторхи улс төрийн тогтворгүй байдал буюу бусад онцгой үйл явдал зэрэг онцгой нөхцөл байдал нь энэхүү үндсэн зарчмаас ухрах хүндэтгэх шалтгаан болохгүй.

Тусгай нөхцөл:

9. Хэв журам сахиулах үүрэг бүхий албан тушаалтан өөрийгөө болон бусад хүмүүсийн амь нас бусад ноцтой хүнд хохирлоос хамгаалах, бусдын амь бие эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах гэмт хэргийг таслан зогсоох, эрх бүхий албан тушаалтанг эсэргүүцсэн буюу ноцтой гэмт хэрэгтэнг баривчлах, эсхүл гэмт хэрэгтнийг оргосныг таслан зогсоох нөхцөлд бусад арга хэрэгсэл хэрэглэхэд үр дүнд хүрэхгүйгээс бусад тохиолдолд зөвхөн амь насыг хамгаалах зайлшгүй шаардлагатай нөхцөлд хэрэглэнэ.

10. Хэрэв хүч, галт зэвсэг хэрэглэх эрх бүхий албан тушаалтанд өөрт нь буюу эргэн тойрны хүмүүст амь хохирох, ноцтой хүнд хор хохирол учрах аюул заналхийлснээс бусад тохиолдолд гэмт хэрэгтэнд 9 дэх зарчимд зааснаар хүч хэрэглэх ийн өмнө галт зэвсэг хэрэглэх гэж байгаа тухай урьдчилан сануулгыг нөгөө этгээдээс хариу өгөх боломжтой хугацаанд өгч байна.

11. Хэв журам сахиулах үүрэг бүхий албан тушаалтан галт зэвсэг хэрэглэх хэм хэмжээ нөхцөл нь дор дурьдсан удирдлага болох зарчмуудыг агуулсан байна.

а/ Эрх бүхий албан тушаалтнаас галт зэвсэг авч явах нөхцөл байдлыг тогтоох, галт зэвсэг, сум хэрэгслийн зөвшөөрөгдөх хэлбэрийг заах,

б/ Галт зэвсгийг хэрэглэхдээ зөвхөн зайлшгүй нөхцөлд онцгой хохирол учруулах явдлыг аль болох бага байлгах

в/ Ноцтой хүнд гэмтээх, зөвтгөж болохооргүй эрсдэл үзүүлэх эх үүсвэр болох төрлийн зэвсэг, сум хэрэгсэл хэрэглэхийг хориглох

г/ Галт зэвсгийг хэрэглэх эрх бүхий албан тушаалтан түүнд олгосон буу, сум хэрэгслийг биечлэн хариуцаж тооцож байх тоо

мэдвэл зохих гол хуулиуд _____
бүртгэл бий болгох, галт зэвсэг олгох, хадгалах, хяналт тавих
асуудлыг зохицуулах

е/ Галт зэвсэг хэрэглэж буудахаас өмнө зохих нөхцөлд өгөх
урьдчилсан сануулгыг тодорхойлох

ё/ Эрх бүхий албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэх явцад
галт зэвсэг хэрэглэсэн тухай бүрт тайлагнаж байх системийг
тусгах

Хууль бус цугларалтын үед хэв журам хамгаалах

12. Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс
төрийн эрхийн тухай Олон улсын пактад зааснаар хууль ёсны
ба тайван жагсаал цуглаанд хүн бүр оролцох эрхтэй тул Засгийн
газар хэв журам сахиулах байгууллага албан тушаалтан зөвхөн
13,14-т заасан зарчимд нийцсэн тохиолдолд галт зэвсэг хэрэглэж
болно

13. Хууль бус боловч аливаа хүч хэрэглээгүй жагсаал
цуглааныг тараахдаа хэв журам сахиулах албан тушаалтан хүч
хэрэглэхээс аль болохоор зайласхийх ба хэрэв хүч хэрэглэх
нөхцөл бүрэлдвэл хамгийн наад талын гарцаагүй байдлыг хүртэл
хязгаарлах хэрэгтэй.

14. Хүч хэрэглэсэн шинж бүхий жагсаал цуглааныг тараахад
галт зэвсгийг зөвхөн аюул багатай бусад хэрэгсэл хэрэглэх
боломжгүй болсон гарцаагүй шаардлага гарсан тохиолдолд
хэрэглэнэ. Хэв журам сахиулах үүрэг бүхий албан тушаалтан 9-
т заасан зарчимд зааснаас бусад тохиолдолд галт зэвсэг
хэрэглэхгүй.

Хоригдож байгаа буюу цагдан хоригдсон

Этгээдэд тавих хяналт

15. Хэв журам сахиулах үүрэг бүхий албан тушаалтан хоригдол буюу цагдан хоригдож байгаа этгээдтэй харилцахдаа хорих байгууллагын доторхи эмх журам, аюулгүй байдлыг хамгаалах зайлшгүй шаардлага гарсан, эсхүл өөрийн нь хувийн аюулгүй байдалд аюул заналхийлснээс бусад тохиолдолд хүч хэрэглэхгүй.

16. Хэв журам сахиулах үүрэг бүхий албан тушаалтан хоригдол буюу цагдан хоригдож байгаа этгээдтэй харилцахдаа өөрийгөө хамгаалах, бусдыг үхлийн буюу хүнд шархдуулах ноцтой хохирол учруулах шууд аюул заналаас хамгаалах, аюул бүхий хоригдол, цагдан хоригдогч оргох явдлыг 9-т заасан зарчмын дагуу таслан зогсоохоос бусад үед галт зэвсэг хэрэглэхгүй.

17. Дээр дурьдсан зарчмыг хоригдол этгээдтэй харьцах хамгийн наад захын жишиг дүрэм, ялангуяа түүний 33.34.54-т заасан шоронгийн ажилтны эрх, чиг үүрэгт хохирол учруулахгүйгээр хэрэглэнэ.

Мэргэшил, бэлтгэх ба зөвлөгөө

18. Засгийн газар болон хууль хамгаалах байгууллага Хэв журам сахиулах үүрэг бүхий албан тушаалтанг зохих журмаар шилж сонгох дүрмийн дагуу шалгаруулж авах, тэдгээр нь өрийн үүргийг амжилттай гүйцэтгэх зан суртахуун, сэтгэл санаа бие бялдрын зохих бэлтгэлтэй, мэргэжлийн хувьд байнгын тасралтгүй бэлтгэлтэй байх нөхцлийг хангана. Тэд ажил, үүрэгтээ тэнцэж байгаа эсэхийг тогтмол шалгаж байвал зохино.

19. Засгийн газар болон хууль хамгаалах байгууллага Хэв журам сахиулах үүрэг бүхий албан тушаалтанг хүч хэрэглэх үйл ажиллагаанд сургаж бэлтгэх, хүч хэрэглэх тусгай бэлтгэлийг шалгах нөхцлөөр хангана. Хэв журам сахиулах албан тушаалтан

мэдвэл зохих гол хуулиуд _____
галт зэвсэг хэрэглэх талаар тусгай курст суралцаж төгссөний дараа галт зэвсгийг биедээ зохих зөвшөөрлийн дагуу авч явах ёстой.

20. Хэв журам сахиулах албан тушаалтанг бэлтгэхдээ цагдаагийн ажилтны ёс зүй, мөрдөн байцаалт явуулах үед хүний эрх, зөрчлийг аль болох тайван замаар шийдвэрлэх, олон нийтийн хандлагыг ойлгох, тэдэнд итгүүлэх, хэлцэл хийх, зуучлах, галт зэвсэг хэрэглэхийг хязгаарлахын тулд бусад техник хэргсэл хэрэглэх боломж зэрэгт сургахад засгийн газар, хууль хамгаалах байгууллага онцгой анхаарах хэрэгтэй. Хууль хамгаалах байгууллага сургалтын праграмм, тодорхой этгээдтэй харьцах шуурхай ажиллагааны журмаа дахин нягтлан авч үзэх ёстой.

21. Хэрэв хэв журам сахиулах үүрэг бүхий албан тушаалтан хүч, галт зэвсэг хэрэглэх нөхцөлд сэтгэл санааны хүчтэй цочролд орсон үед хэрхэх талаар түүнд зөвлөмж өгөхөд засгийн газар, хууль хамгаалах байгууллага онцгой анхаарал тавих хэрэгтэй.

Рапорт бүрдүүлэх, мэдээлэх журам

22. Засгийн газар, хууль хамгаалах байгууллага б: 11-рт заасан зарчимд дурдсан бүх үйлдлийн талаар рапорт бүрдүүлж мэдээлэх журам тогтооно. Дээр дурдсан зарчмын дагуу хийсэн тайланд заасан үйлдлийг зохих ёсоор шүүхийн тулд хараат бус захиргааны буюу шүүн таслах байгууллагаар хэлэлцүүлэх үр ашигтай байцаан шийтгэх журмыг Засгийн газар, хуулийн байгууллага тогтоох ёстой. Хүний амь нас хохирсон хүндээр шархадсан, бусад хүнд хоор хохирол учруулсан тухай бүрт хэрэг бүрдүүлэх үүрэгтэй хараат бус захиргааны буюу шүүхийн хяналт хэрэгжүүлэгч байгууллагад тодорхой илтгэнэ.

23. Хүч ба галт зэвсэг хэрэглэсний улмаас хохирсон этгээд, түүний хууль ёсны төлөөлөгч шүүх болон хараат бус байцаан

шийтгэх ажиллагаанд оролцоно. Хэрэв хохирогч этгээд нас барсан бол энэхүү нөхцөл түүний тэжээн тэтгүүлэгчид зохих журмаар хамаарна.

24. Хэрэв эрх бүхий албан тушаалтан хүч буюу галт зэвсэг хууль бусаар хэрэглэснийг түүний албан тушаалтан мэдсэн буюу мэдэх ёстой байсан бөгөөд тэрээр энэхүү хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох талаар өөрийн эрх хэмжээний дагуу холбогдох арга хэмжээ аваагүй, мэдээлээгүй бол хариуцлагад татаж байх журмыг засгын газар, хууль хамгаалах байгууллага хангана.

25. Хэрэв хэв журам сахиулах үүрэг бүхий албан тушаалтан үйл ажиллагааны тухай хууль энэхүү үндсэн зарчимд заасан үндэслэлээр хүч буюу галт зэвсэг хэрэглэх тушаалыг биелүүлэхээс татгалзсан буюу бусад тушаалтнаас хууль бусаар хүч, галт зэвсэг хэрэглэх гэж буй тухай мэдээлсэн албан тушаалтанд аливаа эрүүгийн болон сахилгын шийтгэл хүлээлгэхгүй байхыг засгийн газар, хууль хамгаалах байгууллага хангана.

26. Хүч галт зэвсэг хэрэглэх талаар дээд тушаалын албан тушаалтнаас өгсөн тушаал нь илт хууль бус болохыг мэдсэн атлаа бусдын амь нас хохироосон буюу хүнд шархдуулсан бол түүнээс ухаалгаар татгалзаагүй хэв журам сахиулах албан тушаалтанг дээд тушаалын хүний тушаал биелүүлсэн гэж хариуцлагаас чөлөөлөхгүй. Харин ямар ч тохиолдолд хууль бус тушаал өгсөн албан тушаалтанд нэгэн адил хариуцлага хүлээлгэнэ.”

МЭДВЭЛ ЗОХИХ ГОЛ ХУУЛИУД

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ

Улаанбаатар хот 1992 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр
Төрийн мэдээлэл сэтгүүл. 1992 он. №01
(хэсэгчлэн авав)

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

МОНГОЛ УЛСЫН БҮРЭН ЭРХТ БАЙДАЛ

Нэгдүгээр зүйл

1. Монгол Улс бол тусгаар тогтносон, бүрэн эрхт, Бүгд найрамдах улс мөн.

2. Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.

Арван нэгдүгээр зүйл

1. Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ

Арван дөрөвдүгээр зүйл

1. Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.

2. Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал,

МЭДВЭЛ ЗОХИХ ГОЛ ХУУЛИУД
шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан
гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.

Арван зургадугаар зүйл

13/ Халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй. Баривчилсан шалтгаан, үндэслэлийг баривчлагдсан хүн, түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ. Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална;

Арван есдүгээр зүйл

1.Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.

3.Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1993 оны 12 дугаар сарын 2-ны өдөр

Улаанбаатар хот

**МОНГОЛ УЛСЫН ЦАГДААГИЙН
БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ**

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын цагдаагийн байгууллага /цаашид “цагдаагийн байгууллага” гэх/-ын тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлж, иргэд цагдаагийн албан хаахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Цагдаагийн байгууллагын тухай хууль тогтоомж

1. Цагдаагийн байгууллагын тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, энэ хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.
2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, удирдлагын зарчим

1. Хуулийг дээдлэх, шударга ёс, тэгш байдлыг хангах, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.

2. Нэгдмэл төвлөрсөн удирдлагыг нутаг дэвсгэрийн удирдлагатай хослуулах нь цагдаагийн байгууллагын удирдлагын зарчим мөн.

3. Цагдаагийн бүх шатны байгууллагыг эрх бүхий дээд шатны байгууллагаас томилсон дарга (захирагч) удирдана.

4 дүгээр зүйл. Цагдаагийн байгууллага, түүний тогтолцоо

1. Цагдаагийн байгууллага нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага мөн.

2. Цагдаагийн байгууллага нь нутаг дэвсгэрийн болон ажил үүргийн зарчмаар зохион байгуулагдана.

3. Цагдаагийн байгууллагын тогтолцоо нь цагдаагийн төв байгууллага, түүний харьяа албад аймаг, нийслэлийн харьяа албад болон аймаг, нийслэлийн цагдаагийн газар (хэлтэс), сум, дүүргийн буюу сум, дүүрэг дундын цагдаагийн хэлтэс (тасаг, хэсэг)-ээс бүрдэнэ.

(Энэ хэсгийг 1996 оны 7 дугаар сарын 26-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан).

4. Цагдаагийн төв байгууллагын харьяанд цагдаагийн мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх сургууль, гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах асуудлаар шинжилгээ, судалгаа явуулах үүрэг бүхий байгууллага байж болно.

5 дугаар зүйл. Монгол Улсын Засгийн газраас цагдаагийн байгууллагыг удирдах

1. Засгийн газар нь хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, гүйцэтгэх ажлаас бусад асуудлаар цагдаагийн төв байгууллагыг удирдаж, үйл ажиллагааг нь шалгаж, үүрэг даалгавар өгч, биелэлтийг хангуулна.

мэдвэл зохих гол хуулиуд _____

2. Цагдаагийн төв байгууллага нь үйл ажиллагаагаа Засгийн газрын өмнө хариуцна.

3. Засгийн газар санхүү, материал-техникийн хангамжийн хувьд цагдаагийн байгууллагын хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.

4. Засгийн газар Монгол Улсын Хууль зүйн сайдын саналыг үндэслэн цагдаагийн төв байгууллагын бүтцийг батална.

/Энэ хэсгийг 1996 оны 7 дугаар сарын 26-ны, 2000 оны 8 дугаар сарын 3-ны өдрийн хуулиудаар тус тус өөрчлөн найруулсан/.

5. Цагдаагийн төв байгууллагын даргыг Монгол Улсын Ерөнхий сайдын санал болгосноор Засгийн газар томилж, чөлөөлнө.

/Энэ хэсгийг 2000 оны 8 дугаар сарын 3-ны өдрийн хуулиар нэмсэн/

6 дугаар зүйл. Нутгийн өөрөө удирдах байгууллага, Засаг даргаас цагдаагийн байгууллагыг удирдах

1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, тэдгээрийн Тэргүүлэгчид, тухайн шатны Засаг дарга нь хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, гүйцэтгэх ажил, цагдаагийн дотоод албаны дүрмээр зохицуулагдахаас бусад асуудлаар нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагыг удирдана.

2. Засаг дарга нь тухайн нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, цагдаагийн байгууллага, алба хаагчийн орон байр, хүнс, тээвэр, холбооны хангамжийг дээшлүүлэх, томилогдон очсон алба хаагч, түүний гэр бүлийн гишүүдийн амьдралыг төвхнүүлэхэд туслах арга хэмжээ авна.

3. Цагдаагийн дээд шатны байгууллага нь нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын даргыг томилох, чөлөөлөхдөө тухайн шатны Засаг даргатай зөвшилцөнө.

7 дугаар зүйл. Цагдаагийн байгууллагын туг, бэлгэ тэмдэг

1. Монгол Улсын цагдаагийн байгууллага тугтай байна. Тугны загвар, хэрэглэх журмыг Монгол Улсын Ерөнхийлөгч батална.

2. Цагдаагийн байгууллага бэлгэ тэмдэгтэй байна. Бэлгэ тэмдгийн загвар, хэрэглэх журмыг цагдаагийн төв байгууллагын дарга батална.

8 дугаар зүйл. Цагдаагийн байгууллагын санхүүжилт

1. Цагдаагийн байгууллага улсын төсвөөс санхүүжинэ.

/Энэ хэсэгт 2003 оны 1 дүгээр сарын 2-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

2. Цагдаагийн төв байгууллагын харьяанд цагдаагийн байгууллага үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах зорилго бүхий төрийн өмчийн аж ахуйн нэгж байж болно.

9 дүгээр зүйл. Цагдаагийн төв байгууллагын чиг үүрэг

Цагдаагийн төв байгууллага дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

1/ хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах төрийн бодлогыг хэрэгжүүлэх;

2/ цагдаагийн байгууллагын ажлыг улсын хэмжээгээр нэгтгэн зохион байгуулж, харьяа албад, орон нутгийн цагдаагийн байгууллагыг мэргэжлийн удирдлагаар хангах;

3/ аймаг, нийслэлийн Засаг даргатай зөвшилцөн орон нутгийн цагдаагийн байгууллагыг байгуулах, татан буулгах;

мэдвэл зохих гол хуулиуд _____

4/ цагдаагийн байгууллагыг зэвсэг техник, тусгай хэрэгсэл, хувцас, бусад материалаар хангах бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх;

5/ цагдаагийн байгууллагын боловсон хүчний бодлого боловсруулж, алба хаагчийг сургаж бэлтгэх, тэдний мэдлэг, чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах;

6/ цагдаагийн алба хаагч, бусад ажиллагчдын эрх, хууль ёсны ашиг сонирхолыг хамгаалах;

7/ цагдаагийн нийт байгууллага, алба хаагчийн үйл ажиллагааг Үндсэн хууль, энэ хууль, хууль тогтоомжийн бусад актад нийцүүлэн явуулах ажлыг зохион байгуулах;

8/ гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалахтай холбогдсон асуудлаар Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдад мэдээлэл өгч, санал тавих;

9/ Монгол Улсын цагдаагийн байгууллагыг төлөөлж дотоод, гадаадын байгууллагатай харилцах.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Цагдаагийн байгууллагын үүрэг

10 дугаар зүйл. Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх

/Энэ зүйлийн гарчигт 1997 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар нэмэлт орсон/

1. Цагдаагийн байгууллага нь гэмт хэрэг, нийгмийн хэв журмын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тэдгээрийн шалтгаан, нөхцөлийг тогтоож арилгах ажлыг хууль тогтоомжид заасан арга, хэрэгслээр хэрэгжүүлнэ.

2. Цагдаагийн байгууллага нь гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа болон үйлдэж байгаа тухай мэдээллийг авмагц

_____ мэдвэл зохих гол хуулиуд таслан зогсоох, учирч болох хор хохирлыг гаргуулахгүй, нэмэгдүүлэхгүй байх шуурхай арга хэмжээ авна.

3. Цагдаагийн байгууллага нь гэмт хэрэг гарсан тухай мэдээллийг хүлээн авмагц түүнийг бүрэн илрүүлэх арга хэмжээ авна.

4. Цагдаагийн байгууллага нь хуулиар харъяалуулсан эрүүгийн хэрэгт хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаа явуулна.

5. Цагдаагийн байгууллага нь нутгийн захиргааны болон төрийн бус байгууллагаас зохион явуулж байгаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг мэргэжлийн удирдлагаар хангаж, давтан гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор хорих ял эдэлж суллагдсан хүнд захиргааны хяналт тогтооно.

(Энэ хэсгийг 1997 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар нэмсэн).

6. Цагдаагийн байгууллага нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн туслалцаа, тэдний хамтын ажиллагаанд түшиглэн зохион байгуулна.

(Энэ хэсгийг 2002 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар нэмсэн).

11 дүгээр зүйл. Нийгмийн хэв журам хамгаалах

1. Цагдаагийн байгууллага нь гудамж, талбай, үйлчилгээний газар, нийтийн тээврийн буудал, орон сууц зэрэг олон нийтийн газар хууль тогтоомжоор болон төрийн эрх бүхий бусад байгууллагаас тогтоосон нийтээр дагаж мөрдөх журмыг сахиулж, хүн амын амгалан тайван байдлыг хамгаална.

2. Цагдаагийн байгууллага нь хуулиар харъяалуулсан захиргааны зөрчлийг шалгаж шийдвэрлэнэ.

12 дугаар зүйл. Хүмүүсийг эрэн сурвалжлах

Цагдаагийн байгууллага сураггүй алга болсон хүн, оргон нуугдсан сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан болон шүүхээс даалгасан бусад хүнийг эрэн сурвалжилна.

13 дугаар зүйл. Гүйцэтгэх ажил

1. Цагдаагийн байгууллага дараахь зорилгоор гүйцэтгэх ажил явуулна:

1/ гэмт хэрэг үйлдсэн, үйлдэхээр бэлтгэж, завдаж буй тухай үндэслэлтэй сэжиг байгаа тохиолдолд гэмт этгээдийг илрүүлэх, гэмт үйлдлийг таслан зогсоох;

2/ энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан хүмүүсийг эрэн сурвалжлах;

3/ алдагдсан галт зэвсэг, сум хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх, мансууруулах, хордуулах бодис, түүх, соёлын дурсгалт болон бусад үнэт зүйлсийг эрж олох.

2. Цагдаагийн байгууллагын гүйцэтгэх ажлыг хуулиар зохицуулна.

14 дүгээр зүйл. Шинжилгээ хийж, дүгнэлт гаргах

Цагдаагийн байгууллага нь шүүх, прокурор, хэрэг бүртгэх болон мөрдөн байцаах байгууллага, тэдгээрийн эрх бүхий албан тушаалтны хууль ёсны шийдвэрийг үндэслэн криминалистикийн болон бусад шинжилгээ хийж, дүгнэлт гаргана.

15 дугаар зүйл. Цагдан хорих, баривчлах, албадан саатуулах шийдвэрийг биелүүлэх

1. Цагдаагийн байгууллага нь эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас хуульд заасны дагуу баривчлахаар шилжүүлсэн хүмүүсийг хүлээн авч, холбогдох шийдвэрийг биелүүлнэ.

(Энэ хэсэгт 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон)

2. Баривчлах шийдвэрийг биелүүлэх журмыг Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн цагдаагийн төв байгууллагын дарга батална.

(Энэ хэсэгт 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон)

3. Цагдаагийн байгууллага нь захиргааны журмаар баривчлагдсан этгээдээр баривчлах байранд байсан хугацааны шууд зардлыг төлүүлнэ. Баривчлагдсан этгээд шууд зардлыг төлөх үүрэгтэй.

16 дугаар зүйл. Ял эдлүүлэх тогтоолыг биелүүлэх

Цагдаагийн байгууллага нь хуулиар харьяалуулсан ял эдлүүлэх тухай шүүхийн хүчин төгөлдөр тогтоолыг биелүүлнэ.

Цагдаагийн байгууллага нь шүүхийн шийтгэх тогтоолоор хорих ял шийтгэгдсэн этгээдийг хорих ял эдлүүлэх байгууллагад хуяглан хүргэнэ

/Энэ хэсгийг 2002 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар нэмсэн/

17 дугаар зүйл. Эрүүлжүүлэх

1. Олон нийтийн газар согтуугаар хэвийн бус яваа хүнийг тусгай байранд эрүүлжүүлэх, эсхүл хамгаалах хүнд хүлээлгэн өгнө.

2. Энэ хэсгийг 2002 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан ба 2003 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон

3. Энэ хэсгийг 2003 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон

18 дугаар зүйл. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах

1. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн эрх бүхий байгууллагаас гаргасан дүрэм, журмыг сахин хангуулж, биелэлтэд нь хяналт тавина.

2. Цагдаагийн байгууллага Монгол Улсын нутаг дэвсгэр дээр ашиглаж байгаа автотээврийн болон замын хөдөлгөөнд оролцдог өөрөө явагч хэрэгслийн тоо бүртгэлийг хөтөлж, тэдгээрийг жолоодох эрхийн үнэмлэх олгоно.

(Энэ хэсгийг 1999 оны 6 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон бөгөөд 2001 оны 11 дүгээр сарын 8-ны өдрийн хуулиар нэмсэн)

19 дүгээр зүйл. Гал түймэртэй тэмцэх

(Энэ зүйлийг 1999 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон).

20 дугаар зүйл. Цагдаагийн байгууллагаас гүйцэтгэх захиргааны үүрэг

Цагдаагийн байгууллага захиргааны дараахь үүрэг гүйцэтгэнэ:

1/ Монгол Улсын иргэдэд бүртгэлийн дугаар олгож, иргэний гэр бүлийн байдлын тоо бүртгэлийг улсын хэмжээгээр нэгтгэн хөтлөх;

2/ Монгол Улсад ирсэн гадаадын иргэд, харьяалалгүй хүмүүс /цагдаагийн байгууллагад бүртгүүлэхээс чөлөөлөгдсөн хүмүүсээс бусад/-ийг эрх бүхий байгууллагын зөвшөөрлийг үндэслэн бүртгэж, нэгдсэн тоо бүртгэлийг хөтлөх, Монгол Улсад оршин сууж байгаа гадаадын иргэд, харьяалалгүй хүмүүсийн талаарх хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих;

3/хүүхдийг гэмт хэрэг, осол, зөрчилд орохоос урьдчилан сэргийлэх ажил зохиож, эцэг эх, асран хамгаалагчийн хараа

хяналтгүй болсон хүүхдийн асуудлыг судалж, шийдвэрлэхэд туслалцаа үзүүлэх;

4/ зэвсэгт хүчин, бусад цэрэг, улсын аюулгүй байдлыг хангах, хорихоос бусад байгууллага, иргэд галт зэвсэг, сум хэрэгсэл үйлдвэрлэх, захиалах, худалдах, тээвэрлэх, эзэмших журмын биелэлтэд хяналт тавих;

5/ тамга, тэмдэг, баталгааны тэмдэг хийх, ашиглах журмын биелэлтэд хяналт тавих;

6/ гэмт хэргийн болон эрүүгийн ял шийтгэгдэгчдийн тоо бүртгэл хөтлөх;

7/ гээгдэл эд зүйл, мөнгийг бүртгэн хадгалж, хууль ёсны эзэмшигчид нь олгох асуудлыг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх;

8/ каратэ, самбо зэрэг зэвсэггүйгээр тулалдах арга/мэх/-ын байлдааны хувилбарыг цэргийн ба цагдаагийн алба хаагч бус хүмүүст зохион байгуулалттайгаар зааж сургахад хяналт тавих.

9/ мөрийтэй тоглоом тоглуулах журмын биелэлтэд хяналт тавих;

/Энэ заалтыг 1995 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн ба энэ заалтад 2002 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

10/ Монгол Улсын нутаг дэвсгэр дээр ашиглаж байгаа өнгөт хувилагчийг бүртгэж, тэдгээрийн ашиглалтад хяналт тавих.

/Энэ заалтыг 1995 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/.

21 дүгээр зүйл. Бусад үүрэг

Цагдаагийн байгууллага хууль тогтоомжид заасан бусад үүргийг гүйцэтгэнэ.

Цагдаагийн байгууллагын эрх

22 дугаар зүйл. Гэмт хэрэг, захиргааны зөрчлийн шалтгаан, нөхцөлийг арилгахыг шаардах

1. Цагдаагийн байгууллага нь гэмт хэрэг, захиргааны зөрчил гарсан ба гарч болзошгүй байгаа шалтгаан, нөхцөлийг арилгуулах талаар иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад хүлээсэн үүргийнх нь хүрээнд шаардлага тавьж биелэлтийг шалгана.

2. Цагдаагийн байгууллага, алба хаагчийн тавьсан шаардлагын дагуу иргэд, аж ахуйн нэгж, байгууллага тодорхой арга хэмжээ авч, тогтоосон хугацаанд хариу мэдэгдэнэ.

23 дугаар зүйл. Танилцуулга, материал гаргуулан авах

Биелэлтэд нь хяналт тавихыг цагдаагийн байгууллагад үүрэг болгосон хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлын явц байдлыг шалгаж, шаардлагатай танилцуулга, материалыг холбогдох байгууллага, албан тушаалтан, иргэнээс гаргуулан авна.

24 дүгээр зүйл. Хойшлуулшгүй ажиллагаа

1. Гэмт хэрэг, захиргааны зөрчил үйлдэж байгаа болон үйлдсэн тухай үндэслэлтэй сэжиг байгаа үед цагдаагийн эрх бүхий алба хаагч хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах эсэхийг шийдвэрлэхийн тулд дараахь хойшлуулшгүй ажиллагаа явуулж болно:

(Энэ хэсэгт 2002 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар нэмэлт орсон)

1/ хүний нэр, хаягийг тодруулах зорилгоор бичиг баримтыг үзэж шалгах;

2/ хүний бие, тээврийн хэрэгсэл, ачаа тээшид үзлэг хийх;

3/ иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын эд зүйл, хөрөнгө, мөнгө агуулсан байр, савыг битүүмжлэх;

4/ гэмт хэрэг, захиргааны зөрчлийг шалгаж шийдвэрлэхэд ач холбогдол бүхий тээврийн хэрэгсэл, эд зүйл, мөнгийг түр хугацаагаар хураан авах;

5/ шүүх эмнэлэг, криминалистикийн болон бусад шинжилгээнд зориулж дээж, хурууны хээ, ул мөрний хэв авах;

6/ согтууруулах ундаа, мансууруулах, хордуулах бодис хэрэглэсэн эсэхийг шалгах;

7/ гэмт хэрэг, захиргааны зөрчлийг илрүүлэхэд ач холбогдол бүхий мэдээ өгч чадна гэсэн үндэслэл байгаа нөхцөлд иргэнээс тодорхойлолт авах, энэ зорилгоор түүнийг цагдаагийн байгууллагад урьж ирүүлэх;

8/ гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журам хамгаалах, иргэдийн амь нас, эрүүл мэндэд хохирол учруулах аюулыг таслан зогсоох зорилгоор замын хөдөлгөөний чиглэлийг өөрчилж, энэ тухай орон нутгийн засаг захиргааны байгууллагад илтгэх;

9/ тодорхой нутаг дэвсгэр, орон байранд нэвтрэн орох, гарахад хяналт тогтох;

10/ гэмт хэрэг, захиргааны зөрчлийг таслан зогсоох, гэмт хэрэг захиргааны зөрчил үйлдсэн этгээдийг мөрдөн хөөх, отолт хийж баривчлах үед байгууллага, иргэдийн орон байранд орох.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн 2, 3, 4 -т заасан ажиллагааг Эрүүгийн байцаан шийтгэх хууль болон Захиргааны хариуцлагын тухай хуульд заасан журмаар гүйцэтгэж, тэмдэглэл хөтөлж, түүнд цагдаагийн алба хаагч, сэрдэгдсэн этгээд, гэрч гарын үсэг зурна.

/Энэ хэсгийг 2002 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

3. Цагдаагийн байгууллага нь гэмт хэрэг, захиргааны зөрчил үйлдсэнд сэрдэгдсэн этгээдийн нэр, хаягийг тодруулах, албадан

мэдвэл зохих гол хуулиуд _____
саатуулах үндэслэл байгаа эсэхийг тогтоохын тулд уул этгээдийг
6 цаг хүртэл хугацаагаар түр саатуулж болно.

/Энэ хэсэгт 2002 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар
өөрчлөлт орсон/

4. Энэ зүйлийн 1, 3 дахь хэсэгт заасан хойшлуулшгүй
ажиллагааг хууль бусаар хийсэн гэж үзэж байгаа иргэн, аж ахуйн
нэгж, байгууллага прокурор буюу цагдаагийн дээд шатны
байгууллагын даргад гомдол гаргах эрхтэй. Гомдлыг хүлээн
авсан албан тушаалтан 14 хоногийн дотор хянан шийдвэрлэж,
хариу өгнө.

5. Энэ зүйлийн 4 дэх хэсгийн заалт нь шүүхэд гомдлоо шууд
гаргах иргэний эрхийг хязгаарлахгүй.

25 дугаар зүйл. Гал түймэр, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх

1. /Энэ хэсгийг 1999 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн хуулиар
хүчингүй болсонд тооцсон/.

2. Техникийн хувьд бүрэн бус, улсын тоо бүртгэлд ороогүй,
улсын дугааргүй болон зохих бичиг баримтгүй, эсхүл жолоодох
эрхгүй буюу согтуу хүн жолоодож яваа тээврийн хэрэгсэлийг
саатуулан шалгаж, хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.

26 дугаар зүйл. Цагдаагийн байгууллагын ажлын шуурхай байдлыг хангах

1. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах үүрэг
гүйцэтгэж яваа үедээ цагдаагийн байгууллага, алба хаагч дараахь
эрх эдэлнэ:

1/ гэмт хэрэг, үйлдвэрлэлийн осол, гал түймэр гарсан,
байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул тохиолдсон, нийтийн
эмх замбараагүй байдал үүссэн газарт хүрэлцэн очих, гэмт
хэрэгтнийг мөрдөн хөөх, амь нас, эрүүл мэндэд нь ноцтой

хохирол учирч болох гэмтэлтэй хүмүүсийг эмнэлэгт, гэмт этгээдийг цагдаагийн байгууллагад хүргэхэд автотээврийн хэрэгслийг өмчийн ялгаа харгалзахгүйгээр дайчлан ашиглах. Харин дипломат төлөөлөгчдийн болон албан тушаалын, түүнчлэн үүргээ гүйцэтгэж яваа эмнэлгийн түргэн тусламжийн, гал унтраах албаны, техникийн ослын дуудлагын автомашиныг дайчилж болохгүй;

2/ гэмт хэрэг, зөрчлийн тухай мэдээлэл шуурхай дамжуулахад байгууллага, иргэдийн холбооны хэрэгсэл ашиглах;

3/ хөдөө орон нутагт албан үүрэг гүйцэтгэхдээ сул чөлөөтэй суудалтай тээврийн хэрэгслээр чиглэлийнх нь дагуу зорчих;

4/ нийтэд түгээх яаралтай мэдээллийг хүн амд хүргэх шаардлага гарсан үед хэвлэл, мэдээллийн хэрэгслийг ашиглах.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1,2-т заасан тохиолдолд цагдаагийн байгууллага өмчийн хэлбэрийг нь харгалзахгүйгээр тээврийн хөлс буюу гарсан шууд зардлыг төлнө. Мөн хэсгийн 3,4-т заасан тохиолдолд цагдаагийн байгууллага төрийн өмчийн тээврийн болон хэвлэл, мэдээллийн хэрэгслийг үнэ төлбөргүй ашиглана. Харин бусад төрлийн өмчийн тээврийн болон хэвлэл, мэдээллийн хэрэгсэл ашигласан бол холбогдох хөлс буюу гарсан шууд зардлыг төлнө.

3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан хөлс, зардлыг цагдаагийн алба хаагч тухайн үед шууд төлөх боломжгүй бол тээврийн болон холбоо, хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашигласан тухай албан ёсны баримт өгч, тооцоог нөхөн хийнэ.

4. Цагдаагийн алба хаагч гэмт хэрэгтэй тэмцэх нийгмийн хэв журам хамгаалах үүрэг гүйцэтгэж яваа үедээ хот, суурингийн доторхи нийтийн тээврийн хэрэгсэл /таксинаас бусад/-ээр үнэ төлбөргүй зорчино.

5. Цагдаагийн алба хаагч гэмт хэргийн тухай мэдээллийг хойшлуулшгүй шалгах, аюултай гэмт хэрэгтнийг баривчлах

мэдвэл зохих гол хуулиуд _____
шаардлага гарсан тохиолдолд зорчигч тээврийн болон холбооны хэрэгслээр дараалал харгалзахгүй үйлчлүүлнэ.

6. Албан хэрэгцээнд тээврийн хэрэгсэл хэрэглэх шаардлагатай цагдаагийн алба хаагчид алба-амины автомашин, мотоцикл, морь, тэмээ гэрээгээр эзэмшүүлж болно.

27 дугаар зүйл. Биечилсэн судалгаа

1. Цагдаагийн байгууллага тодорхой нутаг дэвсгэр, олон нийтийн газарт дараахь зорилгоор алба хаагчаа илгээж биечилсэн судалгаа хийж болно:

- 1/ гэмт хэрэг, захиргааны зөрчлийг илрүүлэх;
- 2/ эрүүгийн ба олон нийтийн хэв журмын нөхцөл байдлыг судлах;
- 3/ эрэн сурвалжлагдаж байгаа хүн, эд зүйл, хөрөнгийн олж илрүүлэх.

2. Цагдаагийн алба хаагч эрхэлсэн ажлынхаа хүрээнд, хариуцсан нутаг дэвсгэр дээрээ энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан зорилгоор өөрийн санаачилгаар биечилсэн судалгаа хийж болно.

28 дугаар зүйл. Мэдээллийн сан

Цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах үйл ажиллагаанд туслах тоо бүртгэл хөтөлж, мэдээллийн сүлжээ, сан байгуулж ашиглана.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Цагдаагийн алба хаагч, түүний эрх зүйн байдал

29 дүгээр зүйл. Цагдаагийн алба хаагч

1. Цагдаагийн тангараг өргөж, цагдаагийн аль нэг байгууллагад ажиллаж, суралцаж байгаа иргэнийг цагдаагийн алба хаагч гэнэ.

2. Цагдаагийн албанд 18 нас хүрсэн, ял шийтгэлгүй, Монгол Улсын иргэнийг хүсэлтээр нь авч ажиллуулна.

Хуульчдаас сонгон шалгаруулах тухай хуульд заасан сонгон шалгаруулалтад тэнцэж, гэрчилгээ авсан иргэнийг цагдаагийн байгууллагын хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчаар томилно.

/Энэ хэсэгт 2003 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн өдрийн хуулиар нэмэлт орсон/

3. Цагдаагийн байгууллагад ажиллах иргэний эрүүл мэнд, бие бялдар, мэргэжил, боловсролын болон ёс зүйн шаардлага, шалгуур үзүүлэлтийг цагдаагийн төв байгууллага тогтооно.

4. Цагдаагийн алба хаагчаар томилохын өмнө туршилтын хугацаагаар, эсхүл дагалдуулан ажиллуулж болно. Дагалдах ажилтан бие дааж цагдаагийн алба хаагчийн үүрэг гүйцэтгэх.

5. Цагдаагийн алба хаагч хууль тогтоомжийг чанд сахиж, хүний эрх, эрх чөлөө, нэр төрийг хүндэтгэн хүнлэг харилцах үүрэгтэй.

6. Цагдаагийн алба хаагч захирах даргын тушаалыг биелүүлэх үүрэгтэй.

7. Цагдаагийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэх явцдаа мэдсэн төр, байгууллага, хувь хүний нууцыг задруулахгүй байх үүрэгтэй.

8. Тайван цагт цагдаагийн алба хааж байгаа иргэнийг цэргийн жинхэнэ албанд татахаас түр чөлөөлнө.

9. Цагдаагийн төв байгууллага цэргийн жинхэнэ алба хаагаагүй 23-25 насны цагдаагийн алба хаагчид цэргийн бэлтгэл эзэмшүүлэх үүрэг хүлээнэ. Цэргийн бэлтгэл эзэмшүүлэх хөтөлбөрийг зэвсэгт хүчний Жанжин штаб батална.

/Энэ хэсэгт 2002 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

мэдвэл зохих гол хуулиуд _____

10. Цагдаагийн алба хаагчийг албанаас халагдахад нь чөлөөнд гаргана. Дараахь тохиолдолд чөлөөнд гаргалгүй цолыг хураан халж болно:

- 1/ сахилгын зөрчил удаа дараа гаргасан;
- 2/ хууль тогтоомж, цагдаагийн алба хаагчийн ёс зүйн шаардлагыг ноцтой зөрчсөн;
- 3/ гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдсон.

30 дугаар зүйл. Цагдаагийн тангараг

1. Монгол Улсын иргэн цагдаагийн албанд орохдоо:

“Монгол Улсын иргэн Би цагдаагийн албанд орж ажиллахдаа төрийн хуулийг дээдлэн биелүүлж, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэж, гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах үйл хэрэгт чин шударгаар зүтгэж, шаардлага гарвал амь насаа үл хайрлахаа батлан тангараглая.

Би цагдаагийн ажлын эрдэм ухаанд цуцалтгүй суралцаж, алба хаагчийн сахилга, ёс зүйг чанд сахиж ажиллахаа тангараглая.

Би энэ тангарагаасаа няцваас төрийн хуулийн цээрлэл хүлээнэ.” гэж Цагдаагийн тангараг өргөнө.

2. Цагдаагийн тангараг өргөх журмыг Монгол Улсын Ерөнхийлөгч батална.

31 дүгээр зүйл. Цагдаагийн цол, дүрэмт хувцас

1. Цагдаагийн алба хаагчийн албан тушаал, алба хаасан хугацаа, ажлын бүтээлийг харгалзан дор дурдсан цол олгоно:

- 1/ сурагч;
- 2/ цагдаагийн;
- 3/ цагдаагийн дэд ахлагч;
- 4/ цагдаагийн ахлагч;
- 5/ цагдаагийн ахлагч ахлагч;
- 6/ цагдаагийн дэслэгч;

- 7/ цагдаагийн ахлагч дэслэгч;
- 8/ цагдаагийн ахмад;
- 9/ цагдаагийн хошууч;
- 10/ цагдаагийн дэд хурандаа;
- 11/ цагдаагийн хурандаа.

2. Цагдаагийн удирдах албан тушаалтанд цэргийн дээд цол олгож болно.

3. Цагдаагийн алба хаагч цагдаагийн дүрэмт хувцас хэрэглэх буюу, эсхүл хувцасны мөнгөн хангамж эдэлнэ.

4. Цагдаагийн цол олгох журам, цагдаагийн дүрэмт хувцасны загварыг Монгол Улсын Ерөнхийлөгч, дүрэмт хувцасны эдэлгээний хугацааг Засгийн газар, хэрэглэх журмыг цагдаагийн төв байгууллага тогтооно.

5. Цагдаагийн дүрэмт хувцастай ижил загварын дүрэмт ба ажлын хувцас хэрэглэхийг бусад байгууллагад хориглоно. Энэ заалтыг зөрчсөн тохиолдолд дүрэмт хувцасыг хураан авна.

/Энэ хэсгийн 2 дахь өгүүлбэрийг 2002 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар нэмсэн/

32 дугаар зүйл. Цагдаагийн албаны дүрэм, сахилгын шийтгэл

1. Цагдаагийн байгууллагын дотоод албаны дүрэм, Цагдаагийн хүрээний ба эргүүл, харуулын албаны дүрэм, Цагдаагийн сахилгын дүрмийг Засгийн газар батална.

2. Сахилгын зөрчил гаргасан цагдаагийн алба хаагчид дор дурдсан сахилгын шийтгэл оногдуулна:

- 1/ сануулах;
- 2/ цолны мөнгийг 3 сар хүртэл хугацаагаар хасах;
- 3/ сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах;
- 4/ цагдаагийн цолыг бууруулах буюу хасах;

мэдвэл зохих гол хуулиуд _____

5/ офицер цолыг 1 жил хүртэл хугацаагаар хурааж, энгийнээр буюу цагдаагаар ажиллуулах ;

/Энэ заалтыг 2002 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар нэмсэн/

6/ албанаас халах.

/Энэ заалтын дугаарыг 2002 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар өөрчилсөн/

33 дугаар зүйл. Цагдаагийн алба хаагчийн амралт

1. Цагдаагийн алба хаагчид жил бүр ажлын 15, сонсогчид 25 өдрийн амралт олгоно.

/Энэ хэсэгт 1998 оны 10 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

2. Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журам сахиулах үүрэг бүхий цагдаагийн алба хаагчид алба хаасан 2 жил тутам ажлын 3 өдрийн, цагдаагийн бусад алба хаагчид алба хаасан 5 жил тутам ажлын 3 өдрийн нэмэгдэл амралт олгоно.

/Энэ хэсгийг 2003 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

34 дүгээр зүйл. Цалингийн нэмэгдэл

Цагдаагийн алба хаагчийн цалин дээр нэмж олгох удаан жил ажилласны болон зарим албаны нэмэгдлийг Засгийн газар тогтооно.

35 дугаар зүйл. Цагдаагийн алба хаагчийг шилжүүлэн томилсны зардал

1. Цагдаагийн алба хаагч удирдлагын шийдвэрээр шилжин томилогдох, томилогдсон газраасаа буцах үед түүнийг гэр бүлийн гишүүд, 5 тонн хүртэл ачаа тээшийн хамт оршин суух

газар нь хүргэх тээврийн хэрэгслийг байгууллагаас нь гаргах буюу, эсхүл зардлыг тухайн үед мөрдөж байгаа автомашин, төмөр замын үнэлгээгээр тооцож олгоно.

2. Цагдаагийн алба хаагч удирдлагын шийдвэрээр өөр газар шилжин алба хаах болсноос түүний эхнэр /нөхөр/ нь хөдөлмөрийн гэрээгээ цуцлахад хүрвэл түүнд нэг сараас доошгүй хугацааны дундаж цалинтай нь тэнцэх хэмжээний тэтгэмжийг цагдаагийн байгууллагаас олгоно.

36 дугаар зүйл. Цагдаагийн алба хаагчийн эрх зүйн байдлын онцлог

1. Цагдаагийн алба хаагч улс төрийн аливаа үйл ажиллагаа явуулдаг эвсэл, холбооны гишүүн байх, цагдаагийн бие бүрэлдэхүүний дотор аль нэг нам, эвсэл, холбооны улс төрийн үзэл баримтлалыг сурталчлахыг хориглоно.

2. Цагдаагийн алба хаагч үзэл бодлоо илэрхийлэх, үг хэлэх, эвлэлдэн нэгдэх, хэвлэн нийтлэх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө эдлэхдээ өөрийн албанд хүндэтгэлтэй хандана.

3. Цагдаагийн байгууллагад ажил хаяхыг хориглоно.

4. Цагдаагийн алба хаагч нь төрийн сонгууль үүрэг хүлээсэн, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр ажил хавсаргаж цалин хөлс тогтоосон, түүнчлэн багшлах, зохион бүтээх, уран бүтээл, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх болон энэ зүйлийн 5 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд ажил хавсран гүйцэтгэж цалин хөлс авахыг хориглоно.

5. Цагдаагийн алба хаагч нь олон нийтийн байгууллагад сонгууль буюу томилолтоор орон тооны бус үүрэг гүйцэтгэж цалин хөлс авах бол захирах даргадаа илтгэнэ.

6. Цагдаагийн алба хаагчийг албан үүргээ биелүүлсэнтэй нь холбогдуулан төрийн төв, орон нутгийн байгууллагаас шагнаж урамшуулах бол албан байгууллагад нь урьдчилан мэдэгдэнэ.

мэдвэл зохих гол хуулиуд _____

Цагдаагийн алба хаагч албан үүргээ биелүүлсэнтэйгээ холбогдуулан бусад байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс шагнал авч болохгүй.

37 дугаар зүйл. Цагдаагийн байгууллага, түүний албан хаагчийн үүргээ биелүүлэх баталгаа

1. Цагдаагийн байгууллага, түүний алба хаагч нь төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийг ёсчлон биелүүлснээс үүссэн хохирлыг хариуцахгүй.

2. Цагдаагийн алба хаагч эрх бүхий дарга, захирагчийнхаа өгсөн тушаал, даалгаврыг ёсчлон биелүүлснээс үүссэн үр дагаврыг тушаал, даалгавар өгсөн дарга, захирагч хариуцна.

3. Цагдаагийн алба хаагчийг албан үүрэгтэй нь холбогдуулан төрийн байгууллагаас шалгах бол захирах даргад нь урьдчилан мэдэгдэнэ.

4. Цагдаагийн байгууллага, түүний алба хаагчаар хуулиар хүлээлгэсэн үүрэгт нь үл хамаарах ажил, үүрэг гүйцэтгүүлэхийг хориглоно.

5. Цагдаагийн алба хаагч албаны бус цагаар, түүнчлэн хариуцуулснаас өөр нутаг дэвсгэрт иргэдийн хүсэлт, өөрийн санаачилгаар гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах хууль ёсны үйл ажиллагаа явуулсан бол албан үүргээ гүйцэтгэсэнд тооцно.

6. Цагдаагийн алба хаагчийн эрх хэмжээнийхээ хүрээнд тавьсан хууль ёсны шаардлагыг иргэд, албан тушаалтан харьяалал харгалзахгүйгээр биелүүлэх үүрэгтэй.

7. Цагдаагийн алба хаагчийн хууль ёсны шаардлагыг зориуд үл биелүүлсэн, биелүүлэхгүй байхыг уриалсан, эсэргүүцсэн, албан үүргээ биелүүлэхэд нь санаатай саад учруулсан, албан үүрэгтэй нь холбогдуулан цагдаагийн алба хаагч, түүний гэр бүлийн гишүүд, чөлөөнд гарсан цагдаагийн ажилтныг

доромжилсон, гүтгэсэн, заналхийлсэн, хүч хэрэглэсэн этгээдэд эрүүгийн болон захиргааны хариуцлагын тухай хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

8. Үүргээ ёсчлон биелүүлснээс цагдаагийн алба хаагчид учирсан эд хөрөнгийн хохирлыг цагдаагийн байгууллага төлж, гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.

9. Цагдаагийн алба хаагч өндөржүүлсэн бэлэн байдал, шөнийн ээлжинд ажиллахад хоолны зардлыг, хээрийн сургууль, дадлагын үед хүнсний болон эдийн хангалтыг цагдаагийн байгууллага хариуцна.

10. Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад цагдаагийн алба хаагчийн алдаанаас бусдад учирсан хохирлыг төр хариуцна.

11. Цагдаагийн алба хаагч гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах үүргээ гүйцэтгэж яваад эрүүл мэнд нь хохирсон буюу амь насаа алдсан тохиолдолд түүнд болон ар гэрт нь дараахь тэтгэвэр, тэтгэмж, зардлыг олгоно:

/Энэ хэсэгт 2003 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

1/ хөдөлмөрийн чадвараа түр алдсан бол эмнэлгийн чөлөөтэй байсан хугацааны тэтгэмж, авч байсан цалингийн зөрүү;

2/ тахир дутуу болсон тохиолдолд тахир дутуугийн тэтгэвэр, авч байсан цалингийн зөрүү;

3/ амь насаа алдсан тохиолдолд ар гэрт нь тэжээгчээ алдсаны тэтгэвэр, төрөөс 5 жилийн цалинтай нь тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тэтгэмж;

/Энэ заалтад 2003 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

4/ хиймэл эрхтэн хийлгэх бол түүний зардал.

12. Энэ зүйлийн 11 дахь хэсгийн 2,3-т заасан тэтгэвэр тогтоосноос хойш хохирогчийн тухай үед авч байсан цалинд

мэдвэл зохих гол хуулиуд _____
өөрчлөлт орсон бол зөрүүг шинээр тогтоосон хэмжээнээс тооцож олгоно.

13. Энэ зүйлийн 11 дахь хэсгийн 2,3-т заасан цалингийн зөрүүг тахир дутуугийн ба тэжээгчээ алдсаны тэтгэвэр авч байгаа хугацаанд олгоно.

14. Энэ зүйлийн 11 дахь хэсэгт заасан тэтгэвэр ба цалингийн зөрүү, хиймэл эрхтэн хийлгэх зардлыг цагдаагийн байгууллага олгож, хуульд заасны дагуу гэм буруутай этгээдээр хохирлыг нөхөн төлүүлнэ.

15. Цагдаагийн сургуулийн сонсогч, багш, гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах шууд үүрэггүй цагдаагийн бусад алба хаагчийг эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах, харуул хамгаалалтын ажилд оролцуулж болно. Энэ тохиолдолд цагдаагийн алба хаагчид хуулиар олгосон баталгаа тэдгээрт нэг адил хамаарна.

38 дугаар зүйл. Цагдаагийн алба хаагчид үзүүлэх тусламж, хөнгөлөлт

1. Цагдаагийн алба хаагчийн ажилласан хугацааг тооцоход түр саатуулах байранд харуул, жижүүрээр ажилласан 1 жилийг 1 жил 3 сараар, эрүүлжүүлэх байранд эмч, жижүүрээр ажилласан 1 жилийг 1 жил 2 сараар тооцно.

/Энэ хэсэгт 2002 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

2. Цагдаагийн алба хаагч орон тоо, зохион байгуулалтын өөрчлөлт, эрүүл мэндээр халагдах болон амины сууц барих, орон сууц худалдаж авахад нь Засгийн газраас тогтоосон журмын дагуу тусламж, хөнгөлөлт үзүүлж болно.

3. Цагдаагийн алба хаагч ээлжийн амралтаараа өөрийн буюу эхнэр/нөхөр/-ийн төрсөн нутагт явах бол түүнд ирэх, очих замын

зардлыг тухайн үед мөрдөж байгаа автомашин, төмөр замын үнэлгээгээр тооцож 2 жилд нэг удаа олгоно.

ТАВДУГААР БҮЛЭГ

Цагдаагийн байгууллага, албан хаагчийн зэвсэг, тусгай хэрэгсэл

39 дүгээр зүйл. Цагдаагийн байгууллагын зэвсэг

1. Цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах, харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэх алба хаагчиддаа галт зэвсэг олгох, алба хаагчид нь уул зэвсгийг биедээ авч явах эрхтэй.

2. Цагдаагийн байгууллага нь цэрэг, цагдаагийн албанд зориулж үйлдвэрлэсэн нисдэг тэрэг, хуягт тээвэрлэгч, газар уснаа явагч зэрэг тээврийн хэрэгсэл ашиглах эрхтэй.

40 дүгээр зүйл. Галт зэвсэг хэрэглэх

1. Гэмт үйлдлийг өөр арга, хэрэгслээр таслан зогсоох боломжгүй бол цагдаагийн алба хаагч дараахь тохиолдолд галт зэвсэг хэрэглэж болно:

1/ цагдаагийн алба хаагч болон бусад хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болзошгүй байдлаар довтолсон;

2/ цагдаагийн болон дотоодын цэргийн хамгаалалтад байгаа объект руу нууцаар нэвтрэн орсон, эсхүл зэвсэг хэрэглэн буюу бүлэглэн довтолсон;

3/ хүнийг барьцаанд авсан;

4/ ялтан, цагдан хоригдогч оргосон, хүнд, онц хүнд гэмт хэрэгт сэжиглэгдсэн этгээд зугатсан;

5/ галт зэвсэг, нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч, хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болох бусад зүйлээр зэвсэглэсэн этгээд зэвсгээ хураалгах шаардлагыг үл биелүүлэн эсэргүүцсэн;

мэдвэл зохих гол хуулиуд _____

6/ хуяглан хүргэж яваа этгээдийг суллахаар зэвсэг хэрэглэн, эсхүл бүлэглэн довтолсон;

7/ хорих,цагдан хорих,баривчлах байранд нийтийн эмх замбараагүй байдал гарч, хүний амь нас, эд хөрөнгөд ноцтой хохирол учрах бодитой нөхцөл байдал бий болсон.

2. Цагдаагийн алба хаагч бололцоотой бүх тохиолдолд галт зэвсэг хэрэглэхийн өмнө урьдчилан сануулна.

3. Галт зэвсэг хэрэглэснээс хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учирсан бол зэвсэг хэрэглэсэн цагдаагийн алба хаагч эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх арга хэмжээ авч захирах даргадаа, дарга нь прокурорт нэн даруй мэдэгдэнэ.

41 дүгээр зүйл. Цагдаагийн тусгай хэрэгсэл, мэх

1. Цагдаагийн байгууллага, алба хаагч гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах, харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэхдээ дараахь тусгай хэрэгсэл, мэх ашиглана:

1/ олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл;

2/ нэг бүрийн тусгай хэрэгсэл;

3/ тээврийн хэрэгсэл албадан зогсоох тусгай хэрэгсэл;

4/ хамгаалах тусгай хэрэгсэл;

5/ самбо, каратэ зэрэг зэвсэггүйгээр тулалдах мэх;

6/ албаны нохой.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1,2,3-т заасан тусгай хэрэгслийг цагдаагийн төв байгууллагын зөвшөөрөлгүйгээр үйлдвэрлэх, дуурайлган хийх, гадаадаас оруулж ирэхийг хориглоно.

42 дугаар зүйл. Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл

1. Хоёр ба түүнээс дээш хүнд нэгэн зэрэг хэрэглэх боломжтой хэрэгслийг олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл гэнэ.

2. Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэлд дараахь хэрэгсэл хамаарна:

1/ олон хүнд нэг зэрэг нөлөөлөх нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч;

2/ усан хөөрөг;

3/ утаан хөшиг үүсгэгч

3. Цагдаагийн алба хаагч олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг дараахь зорилгоор хэрэглэж болно:

1/ нийтийн эмх замбараагүй байдлыг таслан зогсоох;

2/ нийгмийн хэв журмыг бүлэглэн зөрчиж байгааг таслан зогсоох;

3/ байгууллага, иргэдийн мэдэлд байгаа барилга байгууламж, орон байрыг эзлэн авсан, гудамж, замын хөдөлгөөнийг бүслэн хаасныг чөлөөлөх;

4/ хориглон эсэргүүцэж байгаа сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтныг баривчлах;

5/ энэ хуулийн 40 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан тохиолдолд.

4. Энэ зүйлийн 3 дахь хэсгийн 1,3-т заасан тохиолдолд олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэхийн өмнө урьдчилан сануулна.

43 дугаар зүйл. Нэг бүрийн тусгай хэрэгсэл

1. Нэг хүнд нөлөөлөх хэрэгслийг нэг бүрийн тусгай хэрэгсэл гэнэ.

2. Нэг бүрийн тусгай хэрэгсэлд дараахь хэрэгсэл хамаарна:

1/ гар, хөл, хурууны гав;

2/ хүлэг, ороох цамц;

3/ резинэн бороохой;

4/ цахилгаан бороохой;

5/ нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчаар цэнэглэсэн буу, шүршүүр;

мэдвэл зохих гол хуулиуд _____

6/ резинэн ба хуванцар сумтай буу.

3. Цагдаагийн алба хаагч дараахь тохиолдолд нэг бүрийн тусгай хэрэгслийг хэрэглэж болно:

1/ цагдаагийн алба хаагчийн хууль ёсны шаардлагыг зориуд биелүүлээгүй, эсхүл эсэргүүцсэн;

2/ сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтныг хуяглан хүргэх;

3/ цагдаагийн алба хаагчийн амь нас, эрүүл мэндэд аюултайгаар эсэргүүцэж болох сэжигтэн, яллагдагч, ялтанг баривчлах;

4/ энэ хуулийн 40 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 42 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан тохиолдолд;

4. Дараахь тохиолдолд хүлэг буюу ороох цамц хэрэглэж болно:

1/ сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан амиа хорлож болзошгүй бол;

2/ сэтгэл мэдрэлийн өвчний улмаас өөрийгөө жолоодох чадвараа алдсан буюу согтуу этгээд догшин хэрцгий авирлаж бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулахаар бол.

5. Энэ зүйлийн 4 дэх хэсгийн 2-т заасан тохиолдолд уул этгээдэд хүлэг, ороох цамц хэрэглэж болох эсэх тухай эмнэлгийн магадлагаа урьдчилан гаргуулах буюу, эсхүл эмч байлцуулна.

44 дүгээр зүйл. Тээврийн хэрэгсэл албадан зогсоох тусгай хэрэгсэл

1. Тээврийн хэрэгслийг зогсоох зорилгоор ашиглах зориулалттай төхөөрөмжийг тээврийн хэрэгсэл албадан зогсоох тусгай хэрэгсэл гэнэ.

2. Тээврийн хэрэгсэл албадан зогсоох тусгай хэрэгслийг дараахь тохиолдолд хэрэглэж болно:

1/ хүний амь нас, эрүүл мэндэд учирч болох бодит аюулыг таслан зогсоох шаардлага тулгарсан;

2/ сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан өөрөө жолоодон зугатсан, эсхүл тийм этгээдийг тээвэрлэн зугатсан;

3/ тээврийн хэрэгслийг зогсоох талаар цагдаагийн алба хаагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг үл биелүүлэн зугатсан.

3. Энэ зүйлийн 2 дахь хэсгийн 1,2-т заасан тохиолдолд тээврийн хэрэгсэл албадан зогсоох тусгай хэрэгсэл хэрэглэх боломжгүй бол галт зэвсэгт хэрэглэн, эсхүл ачааны автомашин болон бусад зүйлээр хаалт тавьж тээврийн хэрэгслийг албадан зогсоож болно.

45 дугаар зүйл. Галт зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэх заавар, хамгаалах тусгай хэрэгслийн жагсаалтыг батлах

1. Галт зэвсэг, бүх төрлийн тусгай хэрэгсэл хэрэглэх зааврыг улсын ерөнхий прокурортой зөвшилцөн цагдаагийн төв байгууллагын дарга батлана.

2. Хамгаалах тусгай хэрэгслийн жагсаалтыг цагдаагийн төв байгууллагын дарга батална.

46 дугаар зүйл. Галт зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэхийг хориглох

Хүүхэд болон жирэмсэн болох нь илэрхий мэдэгдэж байгаа хүмүүст дор дурдсанаас бусад тохиолдолд галт зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэхийг хориглоно:

1/ энэ хуулийн 40 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасан тохиолдолд;

2/ галт зэвсэг хэрэглэж довтолсон, буюу эсэргүүцсэн;

3/ нийтийг хамарсан эмх замбараагүй байдал бий болсон буюу бүлэглэн довтолсон үед оролцсон хүмүүсийг дотор нь ялгах боломжгүй онцгой тохиолдолд.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Цагдаагийн байгууллагад иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас үзүүлэх туслалцаа

47 дугаар зүйл. Байгууллага, иргэдийн туслалцаа

1. Цагдаагийн байгууллага үүргээ биелүүлэхэд нь иргэд, аж ахуйн нэгж, байгууллага дэмжлэг туслалцаа үзүүлнэ.
2. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаа явуулахдаа гэмт хэрэг гарах, ш нийгмийн хэв журам зөрчигдөх нөхцөл бүрдүүлэхгүй байх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.

48 дугаар зүйл. Цагдаагийн туслах ажилтан

1. Цагдаагийн байгууллага 18 насанд хүрсэн иргэнийг, өөрийн нь зөвшөөрснөөр туслах ажилтнаар авч ажиллуулж болно.
2. Цагдаагийн байгууллага туслах ажилтантай гэрээ байгуулж, түүнд туслах ажилтны хариуцах ажил, талуудын харилцан хүлээх үүрэг, олгох хөлс, гэрээ цуцлах үндэслэлийг заана.
3. Цагдаагийн туслах ажилтны дүрмийг энэ хуульд нийцүүлэн Засгийн газар батална.
4. Цагдаагийн туслах ажилтан хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэж, Үндсэн хууль, энэ хууль, хууль тогтоомжийн бусад актыг чанд сахиж, зөвхөн гэрээнд заасан үүргийг биелүүлнэ.
5. Цагдаагийн туслах ажилтнаар хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаа гүйцэтгүүлж болохгүй.
6. Цагдаагийн туслах ажилтан гэмт хэрэг, захиргааны зөрчил гарсан газар, ул мөрийг хамгаалах, сэжиглэгдсэн болон гэрч болох хүмүүсийн бичиг баримтыг шалгаж хаягийг тогтоох, хэв журам сахиу талаар иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад шаардлага тавих, гэмт хэрэг, захиргааны зөрчил үйлдсэн этгээдийг цагдаагийн байгууллагад хүргэх эрхтэй.

7. Цагдаагийн туслах ажилтан гэмт хэрэг, захиргааны зөрчил гарсан тухай төрийн зохих байгууллагад яаралтай мэдээлэх шаардлагатай үед байгууллага, иргэдийн холбооны хэрэгслийг ашиглаж болно.

8. Энэ хуулиар олгосон эрх хэмжээнийхээ хүрээнд цагдаагийн туслах ажилтны тавьсан шаардлагыг иргэд, аж ахуйн нэгж, байгууллага биелүүлэх үүрэгтэй.

9. Цагдаагийн туслах ажилтныг үүргээ биелүүлсэнтэй нь холбогдуулан доромжилсон, заналхийлсэн, бусад хохирол учруулсан, түүний тавьсан хууль ёсны шаардлагыг зориуд үл биелүүлсэн, эсэргүүцсэн этгээдэд эрүүгийн ба захиргааны хариуцлагын тухай хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

ДОЛДУГААР БҮЛЭГ

Гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалахад дотоодын цэргийн гүйцэтгэх үүрэг

/Энэ бүлгийг /49, 50 дугаар зүйл/ 1995 оны 10 дугаар 17-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

НАЙМДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

51 дүгээр зүйл. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналт

1. Монгол Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний Тэргүүлэгчид, Засаг дарга, төрийн хяналтын албад тус тусын эрх хэмжээний дотор цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавина.

2. Монгол Улсын Прокурорын байгууллага нь цагдаагийн байгууллагын хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавина.

мэдвэл зохих гол хуулиуд _____

3. Цагдаагийн төв байгууллага нь цагдаагийн нийт байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаанд, цагдаагийн байгууллагын дарга, захирагч нар тухайн байгууллагын алба хаагчдын өдөр тутмын ажилд дотоодын хяналт тавьж, хууль тогтоомж, цагдаагийн алба хаагчийн ёс зүйн шаардлага, хүний эрх, эрх чөлөөг зөрчих явдалтай тэмцэж, шалтгаан, нөхцөлийг арилгах арга хэмжээ авна.

4. Тодорхой нутаг дэвсгэр хариуцсан нийтлэг үүрэг бүхий цагдаагийн байгууллага, албан хаагч жилд нэгээс доошгүй удаа оршин суугчид буюу тэдгээрийн төлөөлөгчдөд тайлан тавина.

52 дугаар зүйл. Цагдаагийн алба хаагчид хүлээлгэх хариуцлага

Монгол Улсын хууль тогтоомж, өргөсөн тангаргаа зөрчсөн цагдаагийн алба хаагчид хууль тогтоомжийн дагуу эрүүгийн, захиргааны болон сахилгын хариуцлага хүлээлгэнэ.

53 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 1994 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.



**ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

1999 оны 3 дугаар сарын 31-ний өдөр
Улаанбаатар хот

Дугаар 75

ЗААВАР БАТЛАХ ТУХАЙ

“Монгол улсын Цагдаагийн байгууллагын тухай” хуулийн 45 дугаар зүйл, ЦЕГ-ын даргын зөвлөлийн 1994 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТУШААХ НЬ:

1.Бүх төрлийн тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх зааврыг нэгдүгээр хавсралтаар, хамгаалах тусгай хэрэгслийн жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай

2.Зааврыг алба хаагч нараар судлуулан, шалгалт авч тусгай хэрэгсэл хэрэглэх зөвшөөрлийг алба хаагч бүрт тушаалаар олгож байхыг Цагдаагийн газар, хэлтэс, анги, байгууллагын дарга, захирагч нарт үүрэг болгосугай.

3.Энэ зааврыг 1994 оны 06-р сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

4.Энэ тушаал гарсантай холбогдуулан Цагдаагийн ерөнхий газрын даргын 1990 оны А/8 тоот, 1991 оны Б/176 тоот тушаалуудыг тус тус хүчингүй болгосугай.

ДАРГА, ХОШУУЧ ГЕНЕРАЛ Б.ПҮРЭВ
Цагдаагийн ерөнхий газрын даргын 1994 оны
75 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт
ЗӨВШӨӨРӨВ: МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ ПРОКУРОР Н.ГАНБЯР

ЦАГДААГИЙН ТУСГАЙ ХЭРЭГСЭЛ, МЭХ ХЭРЭГЛЭХ ЗААВАР

Нэг: Нийтлэг үндэслэл

1.Цагдаагийн байгууллага, алба хаагч гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах, харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэхдээ Монгол улсын Цагдаагийн байгууллагын тухай хуульд заасан тусгай хэрэгслийг, мөн хуульд заасан үндэслэл бүхий нөхцөлд хэрэглэнэ. Хуульд заагаагүй тусгай хэрэгсэл алба хаагчид тавьж олгох ба хэрэглэхийг хориглоно.

2.Бүх төрлийн тусгай хэрэгслийг хэрэглэхдээ Монгол улсын Цагдаагийн байгууллагын тухай хууль, энэ зааврыг баримтлахын зэрэгцээ тусгай хэрэгслийг үйлдвэрлэгчийн гаргасан ашиглах зааврыг мөн мөрдөнө.

3.Олон хүнд нөлөөлөх, нэг бүрийн болон тээврийн хэрэгсэл албадан зогсоох тусгай хэрэгслийг /хүлэгнээс бусад/ ЦЕГ-аас бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр үйлдвэрлэх, дууриалган хийх, гадаадаас оруулж ирэхийг хориглоно.

4.Цагдаагийн алба хаагч болон бусад хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болзошгүй байдлаар болон галт зэвсэг хэрэглэж довтолсон буюу эсэргүүцсэн, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал бий болсон буюу бүлэглэн довтолсон хүмүүсийг дотор нь ялгах боломжгүйгээс бусад тохиолдолд хүүхэд болон жирэмсэн болох нь илэрхий мэдэгдэж байгаа хүмүүст тусгай хэрэгсэл хэрэглэхийг хориглоно. Харин мэх хэрэглэж болно.

5.Бүх төрлийн тусгай хэрэгсэл, мэх хэрэглэсний дараа хүний эрүүл мэндийн байдалд өөрчлөлт гарах болон гэмтэл учирвал эмнэлгийн тусламж үзүүлж, эмчийн магадлагаа гаргуулна. Мөн тусгай хэрэгслэл, мэх хэрэглэсэн үндэслэл, хэрэглэсэн тусгай

хэрэгсэл ба мэх, хүний эрүүл мэндийн байдалд гарсан өөрчлөлт, эмнэлгийн тусламж үзүүлсэн тухай даргадаа нэн даруй илтгэнэ.

6.Бүх төрлийн тусгай хэрэгсэл, мэхийг үндэслэлгүй, буруу хэрэглэсэн, тусгай хэрэгслийг гээгдүүлж үрэгдүүлсэн, бусдад шилжүүлсэн тохиолдолд албаны шалгалт явуулж, буруутай алба хаагчид сахилгын арга хэмжээ авах буюу эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр эрх бүхий байгууллагад шилжүүлнэ. Албаны шалгалтын дүнг ЦЕГ-т нэн даруй мэдэгдэнэ.

7.Тусгай хэрэгсэл, мэхийг хуулийн үндэслэлгүй буюу буруу хэрэглэсэн зөрчлийг давтан гаргасан хүнийг цагдаагийн байгууллагад ажиллах найдваргүй гэж үзнэ.

8.Олон хүнд нөлөөлөхөөс бусад бүх төрлийн тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх шийдвэрийг цагдаагийн алба хаагч өөрөө гаргаж, үр дагаварыг хариуцана.

9.Дотоодын цэргийн алба хаагч гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах, харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэхдээ тусгай хэрэгсэл хэрэглэх бол энэхүү зааврыг мөрдөнө.

10.Цагдаагийн туслах ажилтанд тусгай хэрэгсэл олгохыг хориглоно.

Хоёр: Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл

11.Хоёр ба түүнээс дээш хүнд нэгэн зэрэг хэрэглэх боломжтой хэрэгслийг олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл гэнэ.

12.Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэлд дараах хэрэгсэл хамаарна.

а/ Олон хүнд нэг зэрэг нөлөөлөх нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч

б/ Усан хөөрөг

в/ Утаан хөшиг үүсгэгч

мэдвэл зохих гол хуулиуд _____

13.Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг дараах зорилгоор хэрэглэж болно.

А/Нийтийн эмх замбараагүй байдлыг таслан зогсоох

Б/Нийгмийн хэв журмыг бүлэглэн зөрчиж байгааг таслан зогсоох

В/ Байгууллага, иргэдийн мэдэлд байгаа барилга байгууламж, орон байрыг эзлэн авсан, гудамж, замын хөдөлгөөнийг бүслэн хаасныг чөлөөлөх

Г/Хориглон эсэргүүцэж байгаа сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтныг баривчлах

Д/Цагдаагийн алба хаагч болон бусад хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болзошгүй байдлаар довтолсон

Е/Цагдаагийн болон дотоодын цэргийн хамгаалалтанд байгаа объект руу нууцаар нэвтрэн орсон, эсхүл зэвсэг хэрэглэн буюу бүлэглэн довтолсон.

Ё/Хүнийг барьцаанд авсан

Ж/ ялтан, цагдан хоригдогч оргосон, хүнд, онц хүнд гэмт хэрэгт сэжиглэгдсэн этгээд зугтсан

З/Галт зэвсэг, нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч, хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болох бусад зүйлээр зэвсэглэсэн этгээд зэвсгээ хураалгах шаардлагыг үл биелүүлэн эсэргүүцсэн.

И/Хуяглан хүргэж яваа этгээдийг суллахаар зэвсэг хэрэглэн, эсхүл бүлэглэн довтолсон

К/Хорих, цагдан хорих, баривчлах байранд болон шүүх хуралдааны үед нийтийн эмх замбараагүй байдал гарч, хүний амь нас, эд хөрөнгөнд ноцтой хохирол учрах бодитой нөхцөл байдал бий болсон.

14.Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэх шийдвэрийг тухайн нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын дарга буюу

тухайн ажиллагааг удирдаж байгаа албан тушаалтан гаргаж, үр дагаварыг хариуцана. Түүний үүрэг нь

а/ Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэх үндэслэл байгаа эсэхийг магадлан, тусгай хэрэгсэл хэрэглэх зорилгыг тодорхойлно.

б/ Хэрэглэх тусгай хэрэгслийн төрөл, тоо хэмжээ, хэрэглэх хүрээ, дэс дараа, тактикийг тодорхойлно.

15. Энэ зааврын 13-р зүйлийн а, в-д заасан тохиолдлуудад олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэхийн өмнө урьдчилан сануулна. Урьдчилан сануулахдаа чанга яригчаар зарлах, удирдагч, зохион байгуулагчийг нь буюу тэдний төлөөлөгчдийг урьж мэдэгдэх, сануулага бичиг тараах зэрэг боломжтой аргыг хэрэглэнэ. Урьдчилан сануулгыг сонсож мэдсэний дараа үйлдлээ таслан зогсоох шинж тэмдэг мэдэгдэхгүй бол тусгай хэрэгсэл хэрэглэж болно.

16. Цаг хугацааны хувьд боломжтой бүх тохиолдолд олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг хэрэглэх үндэслэлийг прокурорт урьдчилан танилцуулж, байлцахыг урина.

17. Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэх үйл ажиллагааг тусгай хэрэгсэл хэрэглэх шийдвэр гаргасан албан тушаалтан, эсхүл түүний томилсон алба хаагч удирдах ба түүний үүрэг нь:

а/ Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэхийн өмнө бие бүрэлдэхүүнд гүйцэтгэх үүргийг тодорхой ойлгуулж, тэднийг тусгай хэрэгслийн нөлөөнөөс хамгаалах арга хэмжээ авна.

б/ Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэхийн өмнө уг хэрэгслийн нөлөөллийн бүсэд байгаа гэм зэмгүй хүмүүс, ялангуяа эмнэлэгт болон хүүхдийн байгууллагад байгаа өвчтөн, хүүхдүүдийг урьдчилан холдуулах арга хэмжээ авна.

мэдвэл зохих гол хуулиуд _____

в/Тусгай хэрэгсэл хэрэглэх ажиллагааг урьдчилан төлөвлөсөн хэмжээ, тактикийн дагуу явуулах ба зогсоох, дуусгах шийдвэрийг гаргаж, үр дагаварыг хариуцах.

г/Тусгай хэрэгслийг бусдад булаалгахгүй байх арга хэмжээ авах

д/Тусгай хэрэгслийг хэрэглэхэд цагдаагийн байгууллагын тухай хууль, энэ заавар болон тусгай хэрэгслийн үйлдвэрлэгчийн зааврын заалтыг чанд мөрдөх явдлыг хангах.

е/Энэ зааврын 18-р зүйлд заасан арга хэмжээг хариуцан зохион байгуулна.

18.Олон хүнд нэг зэрэг нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэсний дараа дор дурддсан ажлыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

а/Эмнэлгийн тусламж үзүүлэх шаардлагатай хүмүүст тусламж үзүүлэх арга хэмжээ авна.

б/Хордсон хүн, амьтан, гал түймэр гарах эх үүсвэр байгаа эсэхийг шалгаж холбогдох арга хэмжээ авна

в/Тусгай хэрэгслийн үйлчлэх чадвар дуусах хүртэл тухайн орчинд харуул хамгаалалт тавьж, иргэдэд зөвлөлгөө, сануулга өгнө.

г/Тухайн орчныг ариутгах, цэвэршүүлэх арга хэмжээ авна

д/Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэсэн үндэслэл, үр дүн, ялангуяа учирсан хохирлын тухай дэлгэрэнгүй актыг хэрэглэснээс хойш 4 цагийн дотор бичиж цагдаагийн дээд шатын байгуулагад аль болох богино хугацаанд таницуулна.

Гурав: Нэг бүрийн тусгай хэрэгсэл

19.Гавыг дараах тохиолдолд хэрэглэж болно.

а/Цагдаагийн алба хаагчийн хууль ёсны шаардлагыг зориуд биелүүлээгүй,эсхүл эсэргүүцсэн

б/ Энэ зааврын 13-р зүйлд заасан бүх тохиолдолд гавыг хэрэглэж болно.

20. Гавыг гар, хөл, хуруунд хийж болно. Үүнд:

1. хоёр гарыг урьд нь болон ард нь бугуйгаар холбож хийнэ.
2. Хөлөнд хоёр хөлийн нарийн шилбээр эсхүл өвдөгний дээгүүр тушиж хийнэ.

3. Хурууны гавыг хоёр гарын эрхий хуруунд хийнэ

4. Хоёр ба түүнээс дээш хүний эрхий хуруу, гар болон хөлийг холбон гавлаж болно

5. Хүнийг хуяглан хүргэх үед гарыг нь өөртэйгээ холбон гавлаж болно

6. Хүнийг тээвэрлэх үед гар буюу хөлийг автомашины суудал, тэвш бусад эд зүйлтэй холбон гавлаж болно

7. Гавыг хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учирхааргүй өөр зүйлээс түр хугацаагаар аргамжиж болно

21. Хүйтний улиралд гавыг гадаа хэрэглэхдээ хөл гарыг хайрч гэмтээхээс хамгаална.

22. Гав, ороох цамц хэрэглэж болох тохиолдлуудад хүлэг хэрэглэж болно. Хүлгийг хүний гар, биед шигдэхээргүй, сунадаггүй, үрж гэмтэл учруулахгүй эдлэлээр хийнэ. Дараах байдлаар хүлэнэ.

1. хүлэгний үзүүрт тооно тушиж, жижиг гогцоо гарган баруун гарынх нь бугуйгаар гогцоолдон, хагас тугавчилж уяад гарыг ар нуруунд нь нугалан дээш нь татаж, хүлэгний үзүүрийг зүүн мөрөн дээгүүр давуулан мөрөвчлүүлж баруун суга доогуур гаргасны дараа зүүн гарыг ар талд нь нугалан шуугаар нь бүтэн тугавчилж уяад, зүүн далны маяа ясны орчимд мөрөвчилсөн хүлэгнээс гогдон эрхийвчилж, баруун гарыг давхар давуулан аль нэг хөлийг ар дээш сойж хөврөхөөр зангидна. Энэ арга “дөрвөлжин хүлэг” гэж нэрлэнэ.

2. Хоёр гарыг урд нь ба ард нь зөөлөн эдээр холбон тугавчилж үзүүрийг хөврөхөөр уяна. Тэгэхдээ хоёр гарыг бугуйгаар юм уу эрхий хуруунуудыг холбон хүлнэ. Энэ үед хүлгийг уг этгээд өөрөө тайлах боломжтойг анхаарна.

3. Шаардлагатай бол сандал дээр даруулах болон багана зэрэг зүйлтэй холбож хүлж болно. Ингэхдээ холбож хүлсэн зүйл нь унаж дарагдах, цохигдохоос сэрэмжилнэ.

23.Ороох цамцыг даавуун эдлэлээр 2 м урт ханцуйтай хийнэ. Ороох цамцыг хүний урд талаас өмсгөж, арын гурван бүчийг хөврөхөөр уяж, ханцуйтай гарыг урд нь зөрүүлэн, ханцуйг хоёр суган доогуур оруулан ар тийш татаж, нуруун дээр нь зөрүүлээд урагш эргүүлэн хоёр гарын булчинг даруулан, суган доогуур оруулан ар тийш татаж, нуруун дээр нь зөрүүлээд урагш эргүүлэн хоёр гарын булчинг даруулан, суган доогуур оруулж үзүүрийг зөрүүлэн буцааж ар нуруунд хөврөхөөр уяна.

24.Ороох цамц, дөрвөлжин хүлэгтэй хүнийг байнгын хяналтад байлгах ба ороох цамц, дөрвөлжин хүлгийг нэг цагаас илүү хугацаагаар үргэлжлүүлэн хэрэглэж болохгүй. Нэг цагаас илүү хугацаагаар хэрэглэх шаардлагатай бол өөр арга ба тусгай хэрэгсэлтэй ээлжилнэ. Жирэмсэн болох нь илэрхий мэдэгдэж байгаа эмэгтэй хүнд ороох цамц, дөрвөлжин хүлэг хэрэглэж үл болно.

25.Сэтгэл мэдрэлийн өвчний улмаас өөрийгөө жолоодох чадвараа алдсан буюу согтуу этгээд догшин хэрцгий авирлаж бусдын болон цагдаагийн алба хаагчийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд хохирол учруулахаар бол уг этгээдэд хүлэг, ороох цамц хэрэглэж болох ба энэ тохиолдолд эмчийн зөвшөөрөл авах эсхүл эмчийн хяналтад байлгах шаардлагатай.

26.Дараах тохиолдолд цахилгаан ба резинэн бороохой, нэг хүнд нөлөөлөх нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчаар

цэнэглэсэн буу буюу шүршүүр, резинэн ба хуванцар сумтай бууны аль нэгийг хэрэглэж болно. Үүнд:

1. гэмт хэрэг, зөрчлийг шалгаж, шийдвэрлэхэд саад болсон үйлдлээ зогсоох талаар цагдаагийн алба хаагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг зориуд биелүүлээгүй

2. цагдаагийн алба хаагчийн хууль ёсны үйл ажиллагаа, шаардлагыг эсэргүүцсэн

3. харилцан зодолдож байгаа хүмүүс үйлдээ зогсоох шаардлагыг зориуд биелүүлээгүй

4. цагдаагийн алба хаагчийн амь нас, эрүүл мэндэд аюултайгаар эсэргүүцэж болох, мөн хориглон эсэргүүцэж байгаа сэжигтэн, яллагдагч, ялтан этгээдийг баривчлах

5. сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан оргон зайлах оролдлого хийсэн бол цагдаагийн алба хаагчийн хууль ёсны шаардлагыг эсэргүүцсэн гэж үзэж энэ зүйлд заасан нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэж болно.

6. Нийтийн эмх замбараагүй байдалд ороцож буй этгээдийн үйлдлийг таслан зогсоох ба баривчлах

7. Нийгмийн хэв журмыг бүлэглэн зөрчиж байгаа этгээдийн үйлдлийг таслан зогсоох ба баривчлах

8. Байгууллага, иргэдийн мэдэлд байгаа барилга байгууламж, орон байрыг эзлэн авсан, гудамж замын хөдөлгөөнийг бүслэн хаасныг чөлөөлөх

9. Галт зэвсэг хэрэглэж болох үндэслэл байгаа тохиолдолд 27.Энэ зааврын 26-р зүйлд заасан тусгай хэрэгслийг хэрэглэхийг хориглох тохиолдлууд

1. тусгай хэрэгслийг хэрэглэсний үр дүнд тусгай хэрэгсэл дахин хэрэглэх үндэслэл арилсан бол

2. энэ зааврын 26-р зүйлийн 1, 2, 3-т заасан тохиолдолд резинэн бороохойгоор хүний толгой, давсаг, бүсэлхий, бөөрний

мэдвэл зохих гол хуулиуд _____

тус газар цохих, цахилгаан бороохойгоор хүний нүүр болон биеийн ил хэсэгт хүргэж хэрэглэхийг хориглоно.

3. Энэ зааврын 26-р зүйлийн 8-д зааснаас бусад тохиолдолд нэг хүнд нөлөөлөх нулимс асгаруулагч амьсгал боогдуулагч, резинэн ба хуванцар сумтай бугаар нэг метрээс ойр зайд нүүр лүү шууд чиглүүлэн буудахыг хориглоно.

4. Ухаангүй согтуу хүнд энэ зааврын 26-р зүйлд заасан нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэхийг хориглоно

5. Нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч нөлөөлсөн хүн эсэргүүцэх, довтлохоо зогсоосны дараа түүнд нүүрээ угаах, арчиж цэвэрлэх боломж олгоно.

ДӨРӨВ: ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ АЛБАДАН ЗОГСООХ ТУСГАЙ ХЭРЭГСЭЛ ХЭРЭГЛЭХ

28.Тээврийн хэрэгслийн дугуйнд болон гинжний завсарт шигдэж эргэлтийг сааруулах зориулалттай хэрэгслийг тээврийн хэрэгсэл албадан зогсоох тусгай хэрэгсэл гэнэ

29.Тээврийн хэрэгсэл албадан зогсоох тусгай хэрэгслийг дараах тохиолдолд зам, газарт дэлгэн тавьж хэрэглэнэ. Үүнд:

1. хүний амь нас, эрүүл мэндэд учирч болох бодит аюулыг таслан зогсоох шаардлага тулгарсан

2. сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан өөрөө жолоодон зугатсан эсхүл тийм этгээдийг тээвэрлэн зугатсан

3. тээврийн хэрэгслийг зогсоох талаар цагдаагийн алба хаагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг үл биелүүлж зугатсан

30.Хүний амь нас, эрүүл мэндэд учирч болох бодит аюулыг таслан зогсоох шаардлага тулгарсан мөн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч ялтан өөрөө жолоодон зугатсан эсхүл тийм этгээдийг тээвэрлэн зугатсан тохиолдолд тээврийн хэрэгсэл албадан зогсоох тусгай хэрэгсэл хэрэглэх боломжгүй бол галт зэвсэг

хэрэглэн эсхүл ачааны автомашин болон бусад зүйлээр хаалт тавьж тээврийн хэрэгслийг албадан зогсоож болно.

31. Галт зэвсэг хэрэглэж тээврийн хэрэгслийг албадан зогсоохдоо жолооч болон зорчигчийг буудахгүй байх нөхцлийг хангана.

32. Ачааны автомашинаар хаалт тавихдаа шатахууны банкинд шууд цохилт ирэхгүй байхаар байрлууна.

33. Тээврийн хэрэгслийг албадан зогсоох тохиолдолд түүний хурд, замын онцлог зэргээс шалтгаалж онхолдолж, замаас гарах зэргээр жолооч, зорчигч, бусад хүмүүсийн амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учирч болзошгүй нөхцөлд эрүүгийн хуулийн гарцаагүй байдлын хэм хэмжээг хэтрүүлэхгүй байх үүрэгтэй.

34. Тээврийн хэрэгслийг албадан зогсоохын өмнө хурдыг хасах зорилгоор саад хэрэглэж болно.

ТАВ: САМБО, КАРАТЭ ЗЭРЭГ ЗЭВСЭГГҮЙГЭЭР ТҮЛАЛДАХ МЭХ ХЭРЭГЛЭХ

35. Мэхийг дор дурьдсан тохиолдолд хэрэглэж болно. Үүнд:

1. галт зэвсэг, нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэх үндэслэл бүхий бүх тохиолдолд

2. цагдаагийн алба хаагчийн хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй бол

3. гав, хүлэггүйгээр хуяглан хүргэх үед

36. Цагдаагийн алба хаагч болон бусад хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болзошгүй байдлаар довтолсноос бусад нөхцөлд дор дурьдсан мэх хэрэглэхийг хориглоно. Үүнд:

1. жирэмсэн болох нь илэрхий мэдэгдэж байгаа хүний хэвлийн дэх урагийг гэмтээж болох мэх хийх

мэдвэл зохих гол хуулиуд _____

2. тахир дутуу, гэмтэлтэй болох нь илэрхий мэдэгдэж байгаа хүний тухайн гэмтлийг сэдрээж болох мэх хийх

3. мэх хийснээс хүний биед гэмтэл учирч болзошгүй нөхцөлд эрүүгийн хуулийн гарцаагүй байдлын хэм хэмжээг хэтрүүлэхгүй байх үүрэгтэй.

37.Эхний мэх хийсний дараа мэх хийх үндэслэл арилбал давтан хийхийг хориглоно.



**Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр
хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр
төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн
эсрэг конвенц**

/Хэсэгчлэн авав/

Энэхүү Конвенцид Оролцогч улсууд,

Нэгдсэн Үндэсний Байгууллагын Дүрэмд тунхагласан зарчмын дагуу хүн төрөлхтөн хэмээх нэгэн гэр бүлийн гишүүн бүрийн адил тэгш, салшгүй эрхийг хүлээн зөвшөөрөх нь эрх чөлөө, шудрага ёс, бүх нийтийн энхтайвны үндэс болохыг анхаарч,

Эдгээр эрх нь хүн бүрийн төрөлхийн нэр төрөөс урган гардгийг хүлээн зөвшөөрч,

Дүрмийн 55 дугаар зүйлийн дагуу хүний эрх, үндсэн эрх чөлөөг бүх нийтээр хүндлэн сахих үйлсэд хувь нэмрээ оруулах үүргээ анхаарч,

Хэнийг ч эрүүдэн шүүх болон хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхгүй хэмээн Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын 5 дугаар зүйл, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 7 дугаар зүйлд заасныг харгалзан,

Ерөнхий Ассамблейгаас 1975 оны 12 дугаар сарын 9-ний өдөр баталсан Хүн бүрийг эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхээс хамгаалах тухай Тунхаглалыг харгалзан,

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг тэмцлийн үр ашгийг дэлхий дахинд дээшлүүлэхийг эрмэлзэн,

Дараахи зүйлийг хэлэлцэн тохиров:

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

Нэгдүгээр зүйл

1. Энэхүү Конвенцийн зорилгоор “эрүүдэн шүүх” гэж хэн нэг хүн буюу гурав дахь этгээдээс мэдээ сэлт, мэдүүлэг авах, тухайн хүн буюу гурав дахь этгээдийн үйлдсэн буюу сэрдэгдсэн хэрэгт шийтгэх, айлган сүрдүүлэх, шахалт үзүүлэх, аливаа байдлаар алагчилах зорилгоор төрийн албан тушаалтан, албан үүрэг гүйцэтгэж буй бусад хүний өдөөн хатгалтаат, ил далд зөвшөөрлөөр тухайн хүн буюу гурав дахь этгээдийн бие махбодь, сэтгэл санааг хүчтэй шаналган зовоох аливаа үйлдлийг хэлнэ. Энэхүү тодорхойлолт нь хуулийн дагуу авах шийтгэл, арга хэмжээ, түүнээс үүдэн буюу холбогдон үүсэх зовлон шаналалд хамаарахгүй

2. Хэрэв олон улсын болон бусад дотоодын хуулинд уг ойлголтыг илүү өргөн утгаар хэрэглэдэг бол энэ зүйл нь тэдгээрт хохирол учруулахгүй.

Хоёрдугаар зүйл

1. Оролцогч улсууд харьяа нутаг дэвсгэртээ эрүүдэн шүүх аливаа үйлдлээс урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй хууль тогтоох, захиргааны, шүүхийн болон бусад арга хэмжээг авна.

2. Дайны байдал, дайны аюул занал, дотоодын улс төрийн тогтворгүй байдал, нийтийг хамарсан онц байдал тогтоох зэрэг нь эрүүдэн шүүхийг зөвтгөх үндэслэл болохгүй.

3. Дээд шатны албан тушаалтнаас буюу төрийн эрх бүхий байгууллагаас өгсөн үүрэг даалгавар нь эрүүдэн шүүхийг зөвтгөх үндэслэл болохгүй.

Гуравдугаар зүйл

1. Эрүүдэн шүүх аюул тулгарна гэж үзэх хангалттай үнэслэл байвал оролцогч улс уг этгээдийг өөр улсад албадан гаргах, буцаах, шилжүүлэн өгөхгүй.

2. Тийм үндэслэл байгаа эсэхийг тогтоох эрх бүхий байгууллага уг асуудалд холбогдох бүх нөхцөл байдлыг, тэр дундаа тус улсад балмадаар, үй олныг хамруулан хүний эрхийг байнга зөрчдөг эсэхийг анхааралдаа авна.

Дөрөвдүгээр зүйл

1. Оролцогч улс бүр эрүүдэн шүүх бүх үйлдлийг эрүүгийн хуулийнхаа дагуу гэмт хэрэг гэж үзнэ. Үүнд эрүүдэн шүүхийг завдах, түүнчлэн эрүүдэн шүүхэд хамжих болон хамтран оролцох явдал мөн адил хамаарна.

2. Оролцогч улс бүр ийм гэмт хэрэгт хуулиар зохих шийтгэл тогтоох бөгөөд чингэхдээ энэ нь онц аюултай гэмт хэрэг гэдгийг харгалзан үзнэ.

Тавдугаар зүйл

1. Оролцогч улс бүр дараах тохиолдолд 4 дүгээр зүйлд заасан гэмт хэргийг шүүн таслах шаардлагатай арга хэмжээ авна:

А. гэмт хэргийг тус улсын нутаг дэвсгэрт, эсхүл тус улсад бүртгэлтэй хөлөг онгоц эсвэл агаарын хөлгийн бүхээгт үйлдэгдсэн бол:

Б гэмт хэрэгт сэжиглэгдэж буй этгээд тус улсын иргэн бол:

В хохирогч нь тус улсын иргэн бөгөөд тус улс гүүн таслах нь зохистой гэж үзвэл

2. Хэрэгт сэжиглэгдэж буй этгээд харъяа нутаг дэвсгэрт нь байгаа бөгөөд энэ күйлийн 1-д заасан улсад 8 дугаар зүйлийн дагуу шилжүүлэн өгөөгүй бол уг гэмт хэргийг

шүүн таслах шаардлагатай арга хэмжээг оролцогч улс авна.

3. Энэхүү Конвенц нь дотоодын хуулийн дагуу эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үгүйсгэхгүй.

Зургадугаар зүйл

1. 4 дүгээр зүйлд заасан гэмт хэрэгт сэжиглэгдэж буй этгээд нутаг дэвсгэрт нь байгаа оролцогч улс өөртөө буй мэдээллийг шалган судалж, нөхцөл байдал шаардвал уг этгээдийг цагдан хорих буюу байцаан шийтгэх ажиллагаанд оролцуулах хууль ёсны арга хэмжээг авна. Цагдан хорих болон бусад арга хэмжээг тухайн улсын хуулийн дагуу авах бөгөөд энэ нь эрүүгийн байцаан шийтгэх буюу шилжүүлэн өгөх ажиллагаа эхлэх хүртэл үргэлжилнэ.

2. Тухайн улс хэргийн талаарх урьдчилсан байцаалтыг нэн даруй явуулна.

3. Энэхүү зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу цагдан хоригдсон этгээд харьяа улсынхаа, хэрэв иргэний харьяалалгүй бол нутаг дэвсгэрт нь байнга оршин суудаг улсынхаа хамгийн ойр байгаа төлөөлөгчтэй нэн даруй холбоо тогтооход туслалцаа үзүүлнэ.

4. Энэ зүйлийн дагуу аливаа этгээдийг цагдан хоривол цагдан хорьсон аливаа улс цагдан хорьсон үндэслэл, нөхцөл байдлыг 5 дугаар зүйлийн 1-д заасан улсад нэн даруй мэдэгдэнэ. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу урьдчилсан байцаалт хийж буй улстогтоосон баримт сэлтээ дээр дурьдсан улсад даруй тайлагнаж, тухайн хэргийг шүүн таслах эсэхээ мэдэгдэнэ.

Долдугаар зүйл

1. Оролцогч улсын нутаг дэвсгэрт 4 дүгээр зүйлд заасан гэмт хэрэгт сэжиглэгдэж буй этгээд байгаа бөгөөд түүнийг өөр улсад шилжүүлэн өгөхгүй бол 5 дугаар зүйлд заасан тохиолдолд эрх бүхий байгууллагаараа уг хэргийг шийдвэрлүүлэхээр шилжүүлнэ.

2. Эдгээр байгууллага нь тухайн улсын хуулийн дагуу ердийн хүнд хэргийг шийдвэрлэх журмаар хэргийг шийдвэрлэнэ. 5 дугаар зүйлийн 2-т заасан тохиолдлуудад яллах болон шүүн таслахад шаардлагатай нотолгооны түвшин 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан тохиолдлоос доогуур байх ёсгүй.

3. 4 дүгээр зүйлд заасан гэмт хэрэгт холбогдуулан эрүүгийн хэрэг үүсгэсэн аливаа этгээдэд байцаан шийтгэх ажиллагааны бүх шатанд шударга хандах баталгаагаар хангана.

Наймдугаар зүйл

1. 4 дүгээр зүйлд заасан гэмт хэрэг нь оролцогч улсуудын хооронд байгуулсан хэрэгтэн шилжүүлэх тухай гэрээний дагуу шилжүүлэх гэмт хэрэгт тооцогдоно. Оролцогч улсууд хэрэгтэн шилжүүлэх асуудлаар цаашид байгуулах гэрээндээ ийм гэмт хэргийг шилжүүлэх талаар тусгах үүрэг хүлээнэ.

2. Оролцогч улс хэрэгтэн шилжүүлэх гэрээний нөхцөлийн дагуу гэрээ байгуулаагүй өөр нэг оролцогч улсаас хэрэгтэн шилжүүлэх тухай хүсэлт хүлээн авбал энэхүү Конвенцийг ийнхүү шилжүүлэх эрх зүйн үндэс гэж үзэж болно. Шилжүүлэх тухай хүсэлт хүлээн авсан улсын хуулинд заасан бусад нөхцлийн дагуу хэрэгтэнийг шилжүүлнэ.

3. Хэрэгтэн шилжүүлэх нөхцлийг гэрээнд тусгаагүй оролцогч улсууд хүсэлт гаргасан улсын хуульд заасан нөхцөл журмын дагуу хэргийг шилжүүлэн шийдвэрлүүлнэ.

4. Оролцогч улсууд хэрэгтэн шилжүүлэх зорилгоор тийм гэмт хэрэг гарсан газарт төдийгүй 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн дагуу хянан шийдвэрлэх улсын нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэж үзнэ.

Есдүгээр зүйл

1. Оролцогч улсууд 4 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн талаар өөртөө байгаа шүүн таслах ажиллагаанд шаардлагатай бүх нотлох баримтыг өгөх зэргээр эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаатай холбоотой тусалцааг бие биедээ аль болохоор бүрэн үзүүлнэ.

2. Оролцогч улсууд энэхүү зүйлийн 1 дэх хэсэгт заасан үүргээ өөр хоорондоо байгуулсан эрх зүйн тусалцаа харилцан үзүүлэх тухай гэрээндээ нийцүүлэн биелүүлнэ.

Аравдугаар зүйл

1. Оролцогч улсууд аливаа хэлбэрээр баривчлагдсан, саатуулагдсан, хоригдсон этгээдийг харгалзах, байцаах, харьцах, хууль сахиулах, энгийн, цэргийн болон эмнэлгийн бүрэлдэхүүн, төрийн албан тушаалтан, бусад хүмүүсийн сургалтад эрүүдэн шүүхийг хориглох тухай сургалтын материал, мэдээллийг тусгана.

2. Оролцогч улс бүр йинхүү хориглосон заалтыг аливаа этгээдийн гүйцэтгэх үүрэг, үйл ажиллагааны журам, зааварт тусгана.

Арваннэгдүгээр зүйл

Оролцогч улсууд эрүүдэн шүүх явдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор нутаг дэвсгэртээ аливаа хэлбэрээр баривчлагдсан, саатуулагдсан, хоригдсон хүмүүсийг

байцаахтай холбогдсон журам, заавар, арга хэрэгсэл, түүнчлэн тэднийг хянан харгалзах, тэдэнтэй харьцах талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээнд шат дараалсан хяналт тавина.

Арванхоёрдугаар зүйл

Оролцогч улсууд өөрсдийн харьяа нутаг дэвсгэрт эрүүдэн шүүх үйлдэл үйлдэгдсэн гэж үзэх хангалттай үндэслэл байвал мөрдөн шалгах ажиллагааг эрх бүхий байгууллагаараа шударга болон шуурхай явуулна.

Арвангуравдугаар зүйл

Оролцогч улс бүр нутаг дэвсгэрт нь эрүүдэн шүүгдсэн гэж мэдүүлж буй этгээдэд гомдлоо эрх бүхий байгууллагад гаргаж, хэргээ шуурхай, шударгаар хянан шалгуулах явдлыг хангана. Гомдол гаргасан, гэрчийн мэдүүлэг өгсөн, нотлох баримт өгсөнтэй нь холбогдуулан зүй бусаар харьцах, айлган сүрдүүлэхээс хамгаалах арга хэмжээг авна.

Арвандөрөвдүгээр зүйл

1. Оролцогч улс өөрийн эрх зүйн тогтолцоогоороо эрүүдэн шүүгдсэн этгээд хохирлоо арилгуулах, шударга, хангалттай нөхөн төлбөр авах эрх, түүний дотор эрүүл мэндээ аль болох бүрэн сэргээхэд шаардлагатай төлбөр гаргуулах эрхийг хүлээн зөвшөөрнө. Эрүүдэн шүүгдсэний улмаас хохирогч нас барвал нөхөн төлбөр авах эрхийг түүнээс санхүүгийн хувьд хараат гэр бүлийн гишүүн, төрөл, төрөгсөд нь эдэлнэ.

2. Энэхүү зүйл нь хохирогч буюу бусад этгээд дотоодын хууль тогтоомжийн дагуу хохирогч нөхөн төлбөр авах эрхийг хөндөхгүй.

Арвантавдугаар зүйл

Оролцогч улсууд эрүү шүүлтийн улмаас хийсэн гэж тогтоогдсон мэдэгдлийг шүүн таслах аливаа ажиллагаанд нотлох баримт болгохгүй, харин эрүү шүүлт тулгасан хэмээн буруутгагдсан хүний эсрэг мэдэгдэл хийгдсэн тухай нотолох баримт болгон ашиглаж болно.

Арванзургаадугаар зүйл

1. Оролцогч улсууд харьяа нутаг дэвсгэртээ 1 дүгээр зүйлд тодорхойлсон эрүүдэн шүүх гэдэгт тооцогдохгүй төрийн албан тушаалтан буюу албан үүрэг гүйцэтгэх буй этгээд өөрөө эсвэл түүний өдөөн хатгаснаар, эсвэл түүний ил, далд зөвшөөрснөөр хэрцгий, хүнлэг бусаар, хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэх явдлаас урьдчилан сэргийлэх үүрэг хүлээнэ. Тухайлбал, 10, 11, 12, 13 дугаар зүйлд заасан үүргийг бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэсэн тохиолдолд орлуулан хэрэглэнэ.

2. Энэ Конвенцийн заалт нь хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийг хориглох, гэмт хэрэгтэнг шилжүүлэх, албадан гаргах тухай олон улсын бусад гэрээ, дотоодын хуульд харшлахгүй.

НОМ ЗҮЙ

- Amnesty International: Guns and Policing-Standards to prevent misuse
- Amnesty international: Towards Human rights-based policing
- Олон улсын гэрээ хэлэлцээрүүдийн эмхтгэл. УБ.,1998 он
- Шүүх эрх мэдлийн салбар дахь хүний эрх. УБ.,1996 он
- Монгол улсын үндсэн хууль. УБ.,1992 он
- Эрүүгийн хууль. УБ.,2002 он
- Иргэний хууль. УБ.,2002 он
- Цагдаагийн байгууллагын тухай хуулийн тайлбар / Б.Пүрэв / . УБ.,1997 он
- Цагдаагийн байгууллагын тухай хууль. УБ.,1993 он
- “Цагдаа” сэтгүүл. УБ.,2005 №2
- Монгол улсын цагдаагийн эрх зүй. УБ.,2000 он
- Цагдаагийн ажилтны гарын авлага. УБ.,2005 он
- Цагдаагийн мэргэжлийн сургалт. УБ.,2005 №4
- Цагдаагийн мэргэжлийн сургалт. УБ.,2003 он
- Цагдаагийн мэргэжлийн сургалт. УБ.,2005 №8
- Орчин үеийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа. УБ., 2004 он
- Александар Жук. Современные пистолеты и револьверы. 2004г
- Ян Хогг. Огнестрельное оружие. 2004г
- Осол гэмтлийн үед үзүүлэх анхны тусламж. УБ.,2005 он
- Brady. Яаралтай тусламж . 2005 он
- ЦЕГ-ийн Тусгай Хэлтсийн сургалтын материал / товчлол/
- Петр Николаевич Иванов. Рукопашный бой. 2004г

- Андрей Иванович Брестов. Русский Рукопашный бой. 2004г
- Роямя Хацуо. Моя жизнь каратэ. 2003г
- В.Суханов. Боевое каратэ /секреты мастерства/. 2000г
- В.Суханов. Боевое каратэ /книга тренер/. 2000г
- В.Суханов. Боевое каратэ и его нераскрытые тайны. 2000г